

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК ХХК
(Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)

Аудитлагдсан санхүүгийн тайлан
2024 оны 12 дугаар сарын 31



МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Аудитлагдсан санхүүгийн тайлан

Агуулга	Хуудас
Банкны талаарх мэдээлэл	1
Гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл	2
Хараат бус аудиторын тайлан	3 – 6
Товчилсон үгийн тайлбар	7
Санхүүгийн байдлын тайлан	8
Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан	9
Өмчийн өөрчлөлтийн тайлан	10
Мөнгөн гүйлгээний тайлан	11
Санхүүгийн тайлангийн тодруулгууд	12 – 84

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК

Банкны талаарх мэдээлэл

ТУЗ-ийн гишүүд	Б. Анар Ц. Эрдэнэбат Г. Хонгор Б. Чойжил
ТУЗ-ийн хараат бус гишүүд	Д. Сувдаа С. Насанжаргал Г. Буян Б. Энхтуяа
Нарийн бичгийн дарга	П. Нэргүй
Албан хаяг	Монгол улс, Улаанбаатар 14210 Сүхбаатар Дүүрэг, 1 дүгээр хороо Энхтайваны өргөн чөлөө, 19 байр 11,12 дугаар давхар
Аудитор	Эрнст энд Янг Монголия Аудит ХХК Мэргэшсэн нягтлан бодогчид

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК

Гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл

Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК-ийн (цаашид “Банк” гэх) Гүйцэтгэх захирал Загдхүүгийн Нарантуяа болон Санхүү удирдлагын газрын захирал Даваагийн Аюурзана бид Банкны санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.



Даваагийн Аюурзана
Санхүү удирдлагын газрын захирал

Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2025 оны 3 сарын 31

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

Бид Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК (“Банк”)-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Банкны санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (“НББОУСЗ”)-өөс баталж гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)-ын дагуу материаллаг алдаагүй, бодитойгоор илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)-уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”-ийн дагуу Банкнаас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд гэдэг нь тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн ач холбогдолтой байсан гэж аудиторын мэргэжлийн үнэлэмжээр үзсэн асуудлууд юм. Эдгээр асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь анхаарч, аудиторын дүгнэлт өгөхдөө авч үзсэн бөгөөд бид уг асуудлуудын талаар тусдаа дүгнэлт гаргадаггүй болно. Аудитын гол асуудлыг бид хэрхэн авч үзсэн талаарх тайлбарыг дор өгөв.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага хэсэгт дурдсан үүрэг хариуцлагууд болон эдгээр асуудлуудтай холбоотой үүрэг хариуцлагыг бид бүрэн биелүүлсэн. Үүний дагуу бид санхүүгийн тайлангуудын материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээнд тохирсон аудитын горимуудыг гүйцэтгэсэн. Дор дурдсан асуудлыг анхаарч үзэхдээ гүйцэтгэсэн горимуудыг багтаасан аудитын горимуудын үр дүн нь энд хавсаргасан санхүүгийн тайлангуудад өгсөн бидний аудитын дүгнэлтийн үндэслэл болно.

Аудитын гол асуудал	Гүйцэтгэсэн аудитын горимууд
3-р шатлалын зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралт 2024 оны 12 сарын 31-нээр, харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа нь Банкны нийт хөрөнгийн ойролцоогоор 57%-г эзэлж байгаа ба 3-р шатлалын зээл болон урьдчилгаа нь Банкны нийт зээлийн дүнгийн 63%-ийг, Банкны нийт зээлийн үнэ цэнийн бууралтын сангийн 99%-ийг эзэлж байна. Банкны удирдлага нь 3-р шатлалын зээлийн үнэ цэнийн бууралтыг зээл тус бүрийн хувьд нэг бүрчлэн тусгайлан тооцохдоо үнэлэмж болон өндөр төвшний төсөөлөл ашигладаг. Тухайлбал: хүлээгдэж буй мөнгөн урсгалын цаг хугацаа, барьцаа хөрөнгийн үнэлгээ, барьцаа хөрөнгийн үнийн хорогдуулалт болон хөнгөлөлтүүд орно. Санхүүгийн тайланд үзүүлэх нөлөө болон тооцооллын тодорхойгүй байдлаас үүдэн бид 3-р шатлалын зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтыг аудитын гол асуудал гэж үзсэн.	Эдгээр аудитын гол асуудалд бид доорх аудитын горимуудыг хийж гүйцэтгэсэн: - Удирдлагын зээлийн үнэ цэнийн бууралтын үнэлгээний процессын талаар ойлголт авч, түүнийг нь үнэлсэн. - Зээлийн үнэ цэнийн бууралтын хүлээн зөвшөөрөлт, бүртгэл, гол хяналтуудын загвар болон үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг үнэлсэн. Тусгайлан үнэлсэн зээлүүдийн хувьд, бид удирдлагын ашигласан аргачлал, өгөгдөл, таамаглалыг үнэлсэн. Үүнд: - Банкны хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн урсгалын талаарх таамаглал, барьцаа хөрөнгийн хэрэгжих боломжит үнэ цэнэ болон борлуулах төлөвлөгөөт хугацааны талаарх таамаглалуудыг шалгасан. - Засгийн газрын шийдвэртэй холбоотойгоор худалдан борлуулах, шилжүүлэх төлөвлөгөөний хувьд, бид удирдлагын үнэлэмжийг үнэлэхдээ засгийн газрын шийдвэрүүд, улсын төсвийн холбогдох баримт бичгүүдийг үзэж шалгасан.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК-ийн хувьцаа эзэмшигчид (үргэлжлэл)

Аудитын гол асуудал (үргэлжлэл)

Аудитын гол асуудал	Гүйцэтгэсэн аудитын горимууд
Холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлого болон нягтлан бодох бүртгэлийн гол тооцооллууд, үнэлэмжүүдийг санхүүгийн тайлангийн Тодруулга 2.4-д толилуулсан. 3-р шатлалын зээл болон урьдчилгаатай хамааралтай тодруулгууд болон холбогдох мэдээллүүдийг тайлангийн 8 болон 29 дугаар тодруулгад тус тус толилуулсан.	- Барьцаа хөрөнгийн оршин байгаа эсэхийг шалгахдаа холбогдох өмчлөлийн гэрээг үзэж шалгасан. - Барьцаа хөрөнгүүдийн хэрэгжих боломжит үнэ цэнийг үнэлэхдээ барьцаа хөрөнгийн гэрээ, болон үнэлгээний тайланг шалгасан. Үнэлгээний тайлангийн хувьд, түүвэрчилсэн байдлаар бид дотоод үнэлгээний мэргэжилтнүүдийг оролцуулан, ашигласан арга, таамаглал, өгөгдлийг нь шалгасан. - Бид хорогдуулсан мөнгөн урсгалын загваруудад ашигласан өгөгдлүүд болох хөнгөлөлтийн хувь хэмжээ болон хүү зэргийг үнэлсэн. - Бид үнэ цэнийн бууралтын аргачлалын математик тооцооллын нарийвчлалыг шалгасан. - Бид ирээдүйд чиглэсэн хүчин зүйлс болон хувилбарт шинжилгээг хянасан. Мөн бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгуудын зохистой байдлыг үнэлсэн.
Өрийн эргэн төлөлт ба хөрвөх чадвар 2024 оны 12 сарын 31-нээр Банк 387,812 сая төгрөгийн цэвэр хөрөнгөтэй байсан бөгөөд тайлант жилд 12,284 сая төгрөгийн алдагдалтай ажилласан. Түүнчлэн тодруулга 30-д дурдсанаар хөрөнгө ба өр төлбөрийн хугацааны шинжилгээнд Банк 12 сарын дотор эргэн төлөгдөх эсвэл барагдуулахаар хүлээгдэж буй 795,469 сая төгрөгийн цэвэр хөрөнгөтэй ба 313,009 сая төгрөгийн өрийн бичиг нь 12 сарын дотор, 1,414,712 төгрөгийн зээлээр татсан санхүүжилт нь 12 сараас дээш хугацааны дараа төлөгдөнө. Санхүүгийн тайлангийн 2.1 тайлан бэлтгэх үндэслэлд тодруулснаар, Банк мөнгөн урсгалын таамаглал, түүний дотор гол таамаглалуудыг стресс тест зэргийг харгалзан үзэж, Банк тайлангийн огнооноос хойш 12 сараас багагүй хугацаанд өр төлбөрөө хугацаандаа төлөх чадвартай ба эргэлтийн хөрөнгөө удирдах боломжтой гэж үнэлсэн. Банкны эргэлтийн хөрөнгө болон хөрвөх чадварын байдлыг сайжруулах төлөвлөгөөгөө нь өөрөө тодорхойгүй байдал, хэрэгжилтийн эрсдэлтэй учир аудитын гол асуудалд тооцсон.	Эдгээр аудитын гол асуудалд бид доорх аудитын горимуудыг хийж гүйцэтгэсэн: - Бид Банкны бизнес төлөвлөгөө, Банкны мөнгөн урсгалын таамаглал болон Банкны үргэлжилсэн бизнесийн үйл ажиллагааг дэмжих удирдлагын үйл ажиллагааны талаар ойлголт авсан. - Бид Банкны мөнгөн урсгалын таамаглалыг тооцохдоо ашигласан мэдээллүүдийн бодитой, найдвартай байдлыг үнэлсэн. - Бид Банкны төлөвлөгөөний хэрэгжих боломжууд дээр тусгайлан үнэлгээ хийсэн. - Бид орлогын өсөлт, барьцаа хөрөнгийн борлуулалт болон мөнгөн урсгалын хугацаа зэрэг гол үзүүлэлтүүдийг нь үнэлсэн. - Бид мөнгөн урсгалын таамаглал дээр хувилбаруудын дүн шинжилгээ хийж, Банкны өр төлбөрөө барагдуулах чадварт эдгээр хувилбаруудын нөлөөллийг үнэлсэн. - Бид Банкны хувьцаа эзэмшигч болох Монгол Улсын Эдийн Засаг, Хөгжлийн Яамнаас дэмжлэг үзүүлэх бичиг авсан. Түүнчлэн бид удирдлагын зүгээс санхүүгийн тайлангийн тайлан бэлтгэх үндэслэл хэсэгт тодруулгуудын үнэн, зөв толилуулсан байдлыг үнэлсэн.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК-ийн хувьцаа эзэмшигчид (үргэлжлэл)

Жилийн тайланд тусгагдсан бусад мэдээлэл

Захирлууд болон Гүйцэтгэх удирдлагууд бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт аудитын тайлан гарсан өдрөөс хойш гарахаар хүлээгдэж буй жилийн тайланд тусгагдах санхүүгийн тайлангууд болон тэдгээрт хамаарах аудиторын тайлангаас бусад мэдээлэл (“Бусад хэсэг”) багтана.

Санхүүгийн тайлангуудад өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй бөгөөд тэдгээрт аливаа хэлбэрийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайлангуудын аудиттай холбоотой бидний хүлээх хариуцлага нь бусад мэдээллийг уншиж, тэдгээр нь санхүүгийн тайлангууд эсвэл аудитын явцад бидний олж авсан мэдээллээс материаллаг байдлаар зөрүүтэй эсвэл алдаатай эсэхийг харгалзаж үзэх явдал юм.

Жилийн тайлангийн “Бусад хэсэг”-ийг унших үед тэнд материаллаг буруу илэрхийлэл байна гэж дүгнэвэл уг асуудлын талаар бид засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгдэх шаардлагатай байдаг.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад хариуцлага хүлээнэ.

Банкны удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Банкны үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Банкны үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд нь Банкны санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь; бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч “АОУС”-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

“АОУС”-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийллийн эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Банкны дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК-ийн хувьцаа эзэмшигчид (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага (үргэлжлэл)

- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Банкны үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Банкны тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь бодитой илэрхийлэгдэх шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

Мөн бид өөрсдийн хараат бус байдлыг хөндсөн ёс зүйн шаардлагуудыг хангасан тухай мэдэгдлийг засаглал хариуцсан этгээдүүдэд хүргэж, бидний хараат бус байдалд зохистойгоор хамааралтай гэж үзэж болох бүхий л харилцаа болон бусад асуудлуудын талаар болон хэрвээ шаардлагатай тохиолдолд аливаа эрсдэлийг арилгахаар авсан арга хэмжээг мэдэгддэг.

Засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгдсэн асуудлаас бид тухайн тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн өндөр ач холбогдол бүхий асуудлуудыг аудитын гол асуудлууд гэж тодорхойлдог. Хууль тогтоомж нь уг асуудлуудын талаар олон нийтэд мэдээллэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайланд тухайн асуудлуудын талаар мэдээллэх нь олон нийтийн хүртэх үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлуудыг бид аудиторын тайландаа толилуулдаг.

Бусад зүйл

2023 оны 12 дугаар сарын 31-нээрх дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн тайлангуудад өөр аудитын компани аудит хийж 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдөр "СТОУС"-д тулгуурлан Монголбанкнаас баталсан заавар журмын дагуу өөрчлөлтгүй дүгнэлтийг анхаарал хандуулах асуудлын хамт гаргасан.

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Банкны хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Банкны хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Ernst & Young Mongolia Audit LLC

ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Гарын үсэг зурсан



ДОРЖБАТЫН МАНДАХБАЯР
Партнер

Баталсан



АДРИАН ЧУ
Партнер

Монгол улс, Улаанбаатар хот
Огноо: 2025 оны 3 дугаар сарын 31

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АХЧ	Алдагдалд хүргэх чанаргүйдэл
БҮЦӨАА	Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх
БҮЦӨБДО	Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх
БЗҮХХ	Борлуулах зориулалттай үл хөдлөх хөрөнгө
ЗҮЦХА	Зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал
SOFR	Баталгаажсан овернайт санхүүжилтийн хүү
МИК	Монголын Ипотекийн Корпораци
НББОУСЗ	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ҮТХТ	Үндсэн төлбөр ба хүүгийн төлбөр
ҮАХ	Үр ашигт хүү
ХУХ	Хөрөнгийн удирдлагийн хороо
ХУХ	Хөрөнгийн удирдлагийн газар
ХАҮҮЦБ	Худалдаж авсан болон үүссэн үнэ цэнийн бууралт
ЧМ	Чанаргүйдлийн магадлал
ЧӨД	Чанаргүйдэлд өртөх дүн
ЭУХ	Эрсдэлийн удирдлагын хороо
VaR	Эрсдэлийн үнэ цэнэ

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тодруулга	2024 мян.төг	2023 мян.төг	2023 оны 1 -р сарын 1 мян.төг
ХӨРӨНГӨ				
Бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	4	361,954,096	142,882,488	884,865,829
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өмчийн хэрэглүүр	7	51,067,994	67,803,010	62,440,408
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүр	7	–	136,639,681	241,081,123
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	6	2,559,996	–	21,753,965
Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэглүүр	7	195,767,047	187,750,879	572,998,816
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	8	1,294,322,795	1,214,273,740	1,447,567,566
Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	11	110,000,000	110,000,000	114,961,047
Орлогын албан татварын авлага	28	196,283	2,511	–
Бусад хөрөнгө	12	72,743,070	82,820,806	87,792,163
Үндсэн хөрөнгө	13	22,336,870	22,879,917	23,724,723
Биет бус хөрөнгө	13	236,381	245,016	306,228
Өмчлөх бусад хөрөнгө	9	89,835,112	166,027,223	174,805,705
Борлуулах зориулалттай хөрөнгө	10	76,508,604	–	–
Хойшлогдсон татварын хөрөнгө	28	–	–	47,414,084
НИЙТ ХӨРӨНГӨ		2,277,528,248	2,131,325,271	3,679,711,657
ӨР ТӨЛБӨР				
Үүсмэл санхүүгийн өр төлбөр	6	1,381,978	4,227,824	5,681,789
Харилцагчдын харилцах	14	3,160,662	37,915,273	35,390,012
Хугацаат хадгаламж	14.1	–	34,123,720	–
Бусад өр төлбөр	15	2,831,889	10,855,382	11,040,936
Тайлант жилийн орлогын албан татварын өглөг		–	–	8,063,524
Бусад татварын өглөг		1,359,526	783,255	17,980
Хойшлогдсон татварын өр төлбөр	28	35,217,680	11,537,956	–
Бусад банкуудад өгөх өглөг	16	108,043,345	225,210,272	29,583,716
Өрийн бичиг	17	1,392,012,468	687,477,828	2,572,205,220
Зээлээр авсан санхүүжилт	18	345,708,957	707,401,712	582,540,605
НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,889,716,505	1,719,533,222	3,244,523,782
ЭЗДИЙН ӨМЧ				
Хувь нийлүүлсэн хөрөнгө	20	1,216,300,341	1,216,300,341	1,216,300,341
Бусад нөөц	20	26,276,637	37,972,640	21,761,615
Хуримтлагдсан ашиг		(854,765,235)	(842,480,932)	(802,874,081)
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ		387,811,743	411,792,049	435,187,875
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		2,277,528,248	2,131,325,271	3,679,711,657

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН

АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

	Тодруулга	2024 мян.төг	2023 мян.төг
Хүүгийн орлого	21	161,310,701	180,672,702
Хүүгийн зардал	22	(188,655,484)	(215,093,546)
Хүүгийн цэвэр зардал		(27,344,783)	(34,420,844)
Үнэ цэнийн бууралтын сангийн буцаалт	23	77,046,970	59,209,225
Үнэ цэнийн бууралтын сангийн дараах хүүгийн цэвэр орлого		49,702,187	24,788,381
Шимтгэл ба хураамжийн орлого		58,865	55,090
Шимтгэл ба хураамжийн зардал		(153,533)	(136,294)
Бусад орлого	24	5,364,479	500,453
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс олсон цэвэр олз/(гарз)	26	2,746,266	(14,121,067)
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн (гарз)/олз	25	(18,286,359)	19,431,456
Удирдлагын болон бусад үйл ажиллагааны зардал	27	(14,800,726)	(12,513,481)
Татварын өмнөх ашиг		24,631,179	18,004,538
Орлогын албан татварын зардал	28	(36,915,482)	(57,611,389)
Тайлант жилийн алдагдал		(12,284,303)	(39,606,851)
Бусад дэлгэрэнгүй (алдагдал)/орлого (татварын дараах):			
<i>Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдах бусад дэлгэрэнгүй орлого (татварын дараах):</i>			
Ашиг, алдагдлын тайлан руу шилжсэн цэвэр дүн	20	855,259	21,795,486
<i>Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдахгүй бусад дэлгэрэнгүй орлого (татварын дараах):</i>			
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өмчийн хэрэглүүрийн дахин үнэлгээний өөрчлөлт		(12,551,262)	4,021,951
Ашиг, алдагдал руу шилжсэн цэвэр дүн	20	–	(9,606,412)
Бусад дэлгэрэнгүй (алдагдал)/орлого		(11,696,003)	16,211,025
Тайлант жилийн татварын дараах нийт дэлгэрэнгүй алдагдал		(23,980,306)	(23,395,826)

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Хувь нийлүүлсэн хөрөнгө мян.төг (Тод. 20)	Бусад нөөц мян.төг (Тод. 20)	Хуримтлагдсан ашиг мян.төг	Нийт ээдийн өмч мян.төг
2023 оны 1 сарын 1-ний байдлаар	1,216,300,341	21,761,615	(802,874,081)	435,187,875
Тайлант жилийн алдагдал	—	—	(39,606,851)	(39,606,851)
Бусад дэлгэрэнгүй орлого	—	16,211,025	—	16,211,025
Нийт дэлгэрэнгүй орлого	—	16,211,025	(39,606,851)	(23,395,826)
2023 оны 12 сарын 31-ний болон 1 сарын 1-ний байдлаар	1,216,300,341	37,972,640	(842,480,932)	411,792,049
Тайлант жилийн алдагдал	—	—	(12,284,303)	(12,284,303)
Бусад дэлгэрэнгүй алдагдал	—	(11,696,003)	—	(11,696,003)
Нийт дэлгэрэнгүй алдагдал	—	(11,696,003)	(12,284,303)	(23,980,306)
2024 оны 12 сарын 31-ний байдлаар	1,216,300,341	26,276,637	(854,765,235)	387,811,743

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК ХХК

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

		2024	2023
	Тодруулга	мян.төг	мян.төг
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Татварын өмнөх ашиг		24,631,179	18,004,538
<i>Тохируулгууд:</i>			
Элэгдэл, хорогдлын зардал	13	932,904	1,012,652
Зээл ба урьдчилгааны эрсдэлийн сангийн буцаалт	23	(77,046,970)	(59,209,225)
Гадаад валютын арилжааны хэрэгжээгүй гарз		12,360,468	3,542,085
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн хэрэгжээгүй (олз)/гарз	26	(5,382,691)	64,305,566
Охин компани татан буулгаснаас олсон олз		–	(54,413)
Охин компанид оруулсан хөрөнгө оруулалтаас олсон олз		–	(46,922)
Хүүгийн орлого	21	(161,310,701)	(180,672,702)
Хүүгийн зардал	22	188,655,484	215,093,546
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны (алдагдал)/ашиг		(17,160,327)	61,975,125
Үйл ажиллагааны хөрөнгө ба өр төлбөрийн өөрчлөлтүүд:			
Банкны харилцах, хадгаламжийн цэвэр (өсөлт)/бууралт		(1,705,148)	(40,598)
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг хэрэглүүрийн цэвэр бууралт		135,600,395	138,623,228
Хорогдуулсан өртгөөрх өрийн бичгийн цэвэр (өсөлт)/бууралт		(992,178)	361,116,311
Зээл ба урьдчилгааны цэвэр бууралт		25,037,100	253,711,825
Бусад хөрөнгийн цэвэр бууралт		16,810,684	18,093,924
Охин компани дахь хөрөнгө оруулалтын цэвэр бууралт		–	5,015,460
Харилцагчдын харилцах дансны цэвэр өсөлт/(бууралт)		(34,754,512)	2,543,814
Хадгаламжийн дансны цэвэр өсөлт/(бууралт)		(34,106,900)	34,523,700
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламжийн цэвэр өсөлт/(бууралт)		(115,670,011)	192,964,499
Бусад өр төлбөрийн цэвэр өсөлт/(бууралт)		(7,255,298)	(3,309,712)
Үндсэн үйл ажиллагаанаас орсон/(-нд зарцуулсан) мөнгөн гүйлгээ		(34,196,195)	1,065,217,576
Төлсөн орлогын албан татвар		(9,245,776)	(8,066,036)
Хүлээн авсан хүү		109,702,934	221,446,329
Төлсөн хүү		(168,469,107)	(268,978,051)
Үндсэн үйл ажиллагаанаас орсон/(-нд зарцуулсан) цэвэр мөнгөн гүйлгээ		(102,208,144)	1,009,619,818
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Охин компанид оруулсан хөрөнгө оруулалтаас орж ирсэн мөнгө		–	1,208,000
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	13	(337,530)	(106,634)
Биет бус хөрөнгийн худалдан авалт	13	(43,692)	–
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас орсон/(-нд зарцуулсан) цэвэр мөнгөн гүйлгээ		(381,222)	1,101,366
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Өрийн бичгээс орж ирсэн мөнгө	18	817,615,836	455,359,860
Зээлээр авсан санхүүжилт	18	135,024,132	503,373,558
Өрийн бичгийн эргэн төлөлт	18	(143,480,903)	(2,327,858,348)
Зээлээс авсан санхүүжилтийн эргэн төлөлт	18	(487,207,780)	(383,576,834)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		321,951,285	(1,752,701,764)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө дэх гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үзүүлсэн нөлөө			
		(290,311)	(2,761)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт		219,071,608	(741,983,341)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4	142,882,488	884,865,829
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4	361,954,096	142,882,488

1. БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЧИН

Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК (цаашид “Банк” гэх) нь Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 195 дугаар тогтоолын дагуу 2011 оны 3 дугаар сарын 25-ны өдөр байгуулагдсан бөгөөд үйл ажиллагаагаа 2011 оны 5 дугаар сард эхлүүлсэн. Банкныг Монгол Улсын Засгийн газар 100% эзэмшдэг.

Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын Хөгжлийн Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдөр хэлэлцэн баталсан ба уг хууль нь 2017 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Монгол Улсын Хөгжлийн банкны шинэчлэгдсэн хууль нь байгууллагын засаглалыг сайжруулж, зээлийн үйл ажиллагааны хяналт болон бие даасан байдлыг нэмэгдүүлэх боломжийг олгосон. Банк нь Төв банкны тухай хууль болон арилжааны банкуудад хамаарах Монголбанкны журмуудаас илүүтэйгээр шинэчилсэн Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулиар зохицуулагддаг хэдий ч Монголбанк нь хөрөнгийн зохистой байдал болон хөрөнгийн хөрвөх чадварыг хянах үүрэгтэй байдаг. Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 4 хараат бус гишүүн болон Монгол Улсын Засгийн Газраас томилдог 5 гишүүдээс бүрддэг. Санхүүжүүлсэн төслүүдийн 60-аас доошгүй хувь нь Монгол Улсын уул уурхайн салбараас бусад нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн экспортлох чадварыг дээшлүүлэх болон экспортыг дэмжсэн хөтөлбөрүүдийг дэмжих ёстой байдаг. Мөн Банк нь засаглал, хяналт болон бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Монгол Улсын Хөгжлийн Банкны тухай хуулийн хоёр дахь шинэчлэлтийг хэлэлцэж байгаа болно.

Банкны үйл ажиллагааны хүрээг өргөжүүлж төрөлжүүлэх зорилгоор дараах охин компаниудыг үүсгэн байгуулж, үйл ажиллагааг эхлүүлсэн. Эдгээр охин компаниуд нь Банкны бүрэн эзэмшилд байдаг. Үүнд:

1. Ди Би Эм Лизинг ХХК нь 2017 оны 6 дугаар сарын 16-ны өдөр үүсгэн байгуулагдсан бөгөөд Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдал, эдийн засгийн хөгжлийг дэмжих уул уурхай, хөдөө аж ахуй, эрчим хүч, дэд бүтэц болон эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлж буй стратегийн төсөл хөтөлбөрүүдэд тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлдэг.
2. Ди Би Эм ассет менежмент УЦК ХХК нь эдийн засгийн өсөлтийг дэмждэг дунд болон том хэмжээний төслүүдэд урт хугацааны санхүүжилт олгох зорилгоор төрөл бүрийн хөрөнгө оруулалтын сангууд бий болгох төлөвлөгөөтэй компани юм. Ди Би Эм Ассет Менежмент УЦК ХХК нь 2018 онд хувийн хөрөнгө оруулалтын сан болох Үндэсний стратегийн хөрөнгө оруулалт хувийн ХОС ТЗК ХХК-ийг үүсгэн байгуулсан

Банкны албан ёсны хаяг нь Монгол Улс, Улаанбаатар хот 14210, Энхтайваны өргөн чөлөө 19, Худалдаа Хөгжлийн Банкны Барилга, 11 болон 12 давхар болно. Эдгээр хоёр давхрыг Банк эзэмшдэг.

2024 оны 12 сарын 31-ний санхүүгийн тайлангууд нь Банкны Гүйцэтгэх удирдлагын 2025 оны 3 сарын 31-ний өдрийн зөвшөөрлөөр батлагдсан.

Банкны эх үүсвэрийн орчин

Банкны үндсэн зорилтын хүрээнд эдийн засгийн тогтвортой хөгжилд ач холбогдол бүхий салбарын өсөлтийг дэмжих зорилгоор зээл, санхүүжилт олгохын тулд урт хугацаатай, хямд өртөг бүхий эх үүсвэрийн багцыг бүрдүүлэх, багцыг төрөлжүүлэх болон бие даан эх үүсвэр татан төвлөрүүлэх чадварыг сайжруулах зорилго тавин ажиллаж байна.

Банкны зээлжих зэрэглэлийг Монгол Улсын зээлжих зэрэглэлтэй ижил Олон улсын зээлжих зэрэглэл тогтоох агентлагууд болох Стандарт энд Пүүрс 2024 оны 10 сарын 04-ний өдөр В+ “тогтвортой”, Мүүдийз 2024 оны 11 сарын 19-ний өдөр В2 “тогтвортой”, Фитч 2024 оны 09 сарын 20-ны өдөр В+ “тогтвортой” гэж тус тус үнэлсэн. Мөн Мүүдийз банкны зээлийн суурь үнэлгээг САА1 түвшнээс 2 шат өсгөлөө. Зээлжих зэрэглэл тогтоох агентлагууд нь Банкныг Монгол Улсын стратегийн ач холбогдол бүхий салбарууд, томоохон төслүүдийг санхүүжүүлэх үндсэн бодлогын үүрэг гүйцэтгэдэг байгууллага бөгөөд Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль, Өрийн удирдлагын тухай хуулиудын дагуу шаардлагатай тохиолдолд Засгийн Газрын бүрэн дэмжлэгт хамрагдах засгийн газрын өмчит, бодлогод чиглэсэн хууль ёсны санхүүгийн байгууллага гэж үздэг.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО

2.1 Тайлан бэлтгэх үндэслэл ба нийцлийн мэдэгдэл

Банкны санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (“НББОУСЗ”)-өөс баталж гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)-ын дагуу бэлтгэгдсэн болно.

Банк нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон жилийн санхүүгийн тайлангуудыг СТОУС 9 “Санхүүгийн хэрэглүүр”-ийн хэрэгжилтээс бусдаар НББОУСЗ-өөс баталж гаргасан СТОУС-ын дагуу боловсруулсан банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу бэлтгэж толилуулсан ба санхүүгийн хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтын бүртгэлдээ Монголбанкаас баталсан заавар, журмыг мөрдсөн.

Банк нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилээс СТОУС 9-г анх удаа хэрэгжүүлж эхэлсэн. Иймээс Банкны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангууд нь СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн анхны тайлан болно. Дэлгэрэнгүйг Тодруулга 2.5-аас харна уу.

Санхүүгийн тайлангууд нь бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн болон өмчийн хэрэглүүр, бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө, бодит үнэ цэнийн аргаар бүртгэгдэх санхүүгийн үүсмэл хэрэглүүр, борлуулах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгийг эс тооцвол түүхэн өртөгийн зарчмаар бэлтгэгдсэн болно. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд мянгачилан, Монгол Улсын мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр тайлагнасан.

Тасралтгүй үйл ажиллагаа

2024 оны 12-р сарын 31-ний байдлаар Банкны цэвэр хөрөнгө нь 387,811,743 мянган төгрөг (2023 оны 12-р сарын 31-ний байдлаар: 411,792,049 мянган төгрөг) бөгөөд татварын дараах алдагдал нь 12,284,303 мянган төгрөг (2023 оны ашиг нь 39,723,454 мянган төгрөг) байна. Тайлант жилд Банк нь шинэ зээл олгоогүй бөгөөд чанаргүй зээлдэгчдээс авлага хураах, барьцаа хөрөнгө хурааж авах үйл ажиллагаанууд дээр анхаарлаа төвлөрүүлэн ажилласан.

2024 оны 12-р сарын 31-ний байдлаар Банкны мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө нь 361,954 сая төгрөг нийт бонд, зээл нь 1,737,721 сая төгрөг үүнээс 313,009 сая төгрөг нь нэг жилийн дотор төлөгдөх бөгөөд 704,829 сая төгрөг буюу 200 сая ам.долларын бонд нь 2026 оны 3-р сард төлөгдөнө. Бонд, зээлээр татсан санхүүжилт, хөрвөх чадварын эрсдэлийн шинжилгээ, хөрөнгө, өр төлбөрийн хугацааны шинжилгээний дэлгэрэнгүй мэдээлэл нь санхүүгийн тайлангийн 17, 18, 29 болон 30 дугаар тодруулгад тусгагдсан болно.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэж, Банкны ирээдүйн санхүүгийн чадавх, ажиллах чадвар, санхүүжилтийн эх үүсвэрийг сайтар нягтлан үзэж, Банкны цаашдын тасралтгүй үйл ажиллагаагаа явуулах хангалттай санхүүгийн нөөцтэй эсэхийг үнэлсэн.

Удирдлага Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн баталсан бизнес төлөвлөгөөний дагуу мөнгөн урсгалын урьдчилсан тооцооллыг боловсруулсан бөгөөд энэ нь удирдлагын гол хувьсагчдын мэдээлэл, зах зээлийн сүүлийн үеийн нөхцөл байдалд үндэслэн дүгнэлт, тооцоолол хийсэн. Мөнгөн урсгалын таамаглалыг ирээдүйн мөнгөн урсгалын тооцоог үндэслэн боловсруулсан бөгөөд энэ нь төсөвлөсөн орлого, зарлага, эргэлтийн хөрөнгийн хэрэгцээг багтаасан болно. Төлөвлөгдсөн орлого нь ихэвчлэн зээлийн өр төлбөрийн эргэн төлөлтийн орлого, өмчлөх бусад хөрөнгийн борлуулалтаас орж ирэх орлого зэрэг багтсан бол эргэлтийн хөрөнгийн хэрэгцээнд бондын болон зээлээр татсан санхүүжилтийн эргэн төлөгдөх багтана. Мөн Банк шинээр урт хугацааны санхүүжилт авахад хүчин чармайлт гаргах гэж үзэж байгаа бөгөөд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн баталсан төлөвлөгөөний дагуу Банк одоогоор төлөвлөгөөний анхны шатандаа явж байна.

Мөн Банкны хувьцаа эзэмшигч Эдийн Засаг Хөгжлийн Яам нь Монгол Улсын Хөгжлийн Банкны тухай хуулийн дагуу Банкны санхүүгийн тогтвортой байдал, төлбөрийн чадварыг хангах үүргийг хүлээсэн тухай дэмжих захидлыг ирүүлсэн.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)**2.2 Санхүүгийн тайлангийн толилуулга (үргэлжлэл)****Тасралтгүй үйл ажиллагаа (үргэлжлэл)**

Аудитын Хороо болон Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Банкны удирдлагад итгэлтэй байгаа бөгөөд Банкны ирэх арван хоёр сарын бизнес төлөвлөгөө нь биелэгдэхүйц, хэрэгжих боломжтой гэж үзсэн. Монгол Улсын Засгийн газарт Банкны бизнес төлөвлөгөөний талаар мэдээллийг хүргүүлсэн бөгөөд Засгийн газартай холбоотой зээлүүдийг төлөх, боломжит хөрөнгө оруулалтын дэмжлэгийг батлах шийдвэр гаргасан. Банк нь ашиг орлогыг нэмэгдүүлэх, мөнгөн урсгалыг сайжруулах зорилгоор дээрх бүх сайжруулалтын зорилтуудыг идэвхтэй хэрэгжүүлж байна. Иймд Төлөөлөн Удирдах Зөвлөл нь санхүүгийн тайланг тасралтгүй үргэлжлэх чадвартай байдлаар бэлтгэх нь зохистой гэж үзэж байна.

2.2 Санхүүгийн тайлангийн толилуулга

Банк нь санхүүгийн байдлын тайлангийн зүйлсийг хөрвөх чадварынх нь дарааллаар толилуулсан. Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн дараах 12 сарын дотор (богино хугацаанд) ба 12 сараас хойших хугацаанд (урт хугацаанд) хүлээн авах эсвэл төлөх төлбөрийн талаарх шинжилгээг тодруулга 29-д толилуулсан.

Ирээдүйн үйл ажиллагаанаас хамааран болзошгүй байх үндэслэлгүй хүлээн зөвшөөрөгдсөн дүнг хооронд нь хаах хууль эрх зүйн эрхтэй байх, мөн цэвэр дүнгээр нь төлбөр хийх эсвэл нэгэн зэрэг хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах зорилготой үед буюу дараах бүх тохиолдолд цэвэр дүнгээр төлж барагдуулах зорилго бүхий санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр нь тусгадаг.

Үүнд:

- Бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед;
- Төлбөрийн чадваргүй болсон үед;
- Банк болон/эсвэл түүний хамтрагч талууд төлбөрийн чадваргүй болсон эсвэл дампуурсан үед

2.3 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд

Банкны санхүүгийн тайлангуудыг батлан гаргах өдрийн байдлаар батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартуудын жагсаалтыг дор үзүүлэв. Банк энэхүү стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийг хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх үед дагаж мөрдөнө.

НББОУС 21-ийн нэмэлт өөрчлөлт

СТОУС 9 болон СТОУС 7-ийн нэмэлт өөрчлөлт

СТОУС 18

Өөр валютад хөрвөх боломжгүй байх¹

Санхүүгийн хэрэгслүүдийн ангилал болон үнэлгээний нэмэлт өөрчлөлт

Санхүүгийн тайлангийн толилуулга, тодруулга³

- ¹2025 оны 1 сарын 1-ний өдрөөс хойших тайлант жилүүдэд хүчинтэй
- ²2026 оны 1 сарын 1-ний өдрөөс хойших тайлант жилүүдэд хүчинтэй
- ³2027 оны 1 сарын 1-ний өдрөөс хойших тайлант жилүүдэд хүчинтэй

Эдгээр нэмэлт өөрчлөлтүүд нь тайлант хугацаанд Банкны санхүүгийн тайланд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.

2.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО

Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуй

Санхүүгийн хэрэглүүр – анхны хүлээн зөвшөөрөлт

Хүлээн зөвшөөрөх өдөр

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа, харилцагчдын харилцах болон хадгаламжаас бусад бүх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө арилжаа хийсэн өдрөөр (Банк нь тухайн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон өдөр) хүлээн зөвшөөрнө. Үүнд хэвийн нөхцөлтэй арилжаа буюу санхүүгийн хөрөнгө худалдан авах, худалдахад холбогдох хөрөнгийг зах зээлийн журам, хэлцлээр тогтоосон хугацаанд зайлшгүй шилжүүлэхийг шаарддаг арилжаа орно. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа нь хөрөнгийг харилцагчдын дансанд шилжүүлсэн үед хүлээн зөвшөөрнө. Банк нь харилцагчдын харилцах, хадгаламжийг Банкинд шилжсэн үед хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хэрэглүүрийн анхны хэмжилт

Санхүүгийн хэрэглүүрийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн ангилал нь гэрээний нөхцөл болон бизнес загвар дээр үндэслэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрөөс бусад бүх санхүүгийн хэрэглүүрийн анхны хэмжилт нь тэдгээрийн бодит үнэ цэн дээр гүйлгээний зардлыг нэмсэн дүн байна. Худалдааны авлагын анхны хэмжилт нь гүйлгээний дүнгээр байна. Санхүүгийн хэрэглүүрийн анхны хүлээн зөвшөөрөлтийн бодит үнэ цэн нь ажил гүйлгээний үнээс ялгаатай үед Банк дор дурдсан “Эхний өдөр”-ийн ашиг алдагдлыг доор тайлбарласны дагуу бүртгэнэ.

“Эхний өдөр”-ийн ашиг ба алдагдал

Ажил гүйлгээний үнэ нь бодит үнэ цэнээсээ ялгаатай бөгөөд бодит үнэ цэнэ нь зах зээлийн ажил гүйлгээнээс ажиглагдахуйц өгөгдөлд суурилсан үнэлгээний аргачлал ашигласан байдал Банк нь бодит үнэ цэнэ болон ажил гүйлгээний үнийн зөрүүг цэвэр арилжааны орлогоор хүлээн зөвшөөрнө. Зарим өгөгдөл нь ажиглагдахуйц мэдээлэлд суурилаагүй үнэлгээний загвараар тооцсон тохиолдолд ажил гүйлгээний үнэ болон бодит үнэ цэнийн зөрүүг зөвхөн орлого орж ирэх нь тодорхой болсон эсвэл санхүүгийн хэрэглүүрийг үл хүлээн зөвшөөрөх тохиолдолд л ашиг алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хэмжих ангилал

Банк өөрийн бүх хөрөнгийг бизнесийн загвар болон гэрээний нөхцөл дээр үндэслэн дараах аль нэгээр нь ангилна:

- Хорогдуулсан өртгөөр бүртгэх
- Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх;
- Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх

Банк нь үүсмэл санхүүгийн хэрэглүүр болон арилжааны үнэт цаасны багцыг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгөөр ангилж хэмжинэ. Хэмжилт болон хүлээн зөвшөөрөлтийн зөрчлийг арилгаж эсвэл бууруулж байгаа нөхцөлд Банк нь санхүүгийн хэрэглүүрийг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх гэж тодорхойлж болно. Зээлийн үүрэг болон санхүүгийн баталгаанаас бусад санхүүгийн өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр эсвэл, арилжааны зорилгоор эзэмшиж буй эсвэл санхүүгийн үүсмэл хэрэглүүр тохиолдолд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг алдагдлын тайланд бүртгэж хэмжинэ.

Бодит үнэ цэнийн тодорхойлолт

Бодит үнэ цэнэ гэдэг нь хэмжилт хийсэн өдрийн зах зээлд оролцогчдын хооронд хийсэн дэс дараалалтай гүйлгээний үр дүнд борлуулснаас орж ирэх мөнгөн дүн болон өр төлбөрт шилжүүлсэн мөнгөн дүн юм. Бодит үнэ цэнийн хэмжилт нь дараах зах зээл дээр хөрөнгийг борлуулсан эсвэл өр төлбөрийг шилжүүлсэн гүйлгээний дэнгээр тодорхойлно. Үүнд:

- Хөрөнгө ба өр төлбөрийн үндсэн зах зээлд, эсвэл
- Үндсэн зах зээл байхгүй тохиолдолд, хөрөнгө ба өр төлбөрийн хувьд хамгийн ашигтай зах зээлд

Үндсэн болон хамгийн ашигтай зах зээл нь Банкны хувьд оролцож болохуйц зах зээлүүд байх ёстой.

Хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжихэд ашигласан үнэ нь зах зээлд оролцогчид нь хөрөнгө ба өр төлбөрийн эдийн засгийн хамгийн өндөр үр өгөөжийг хүртэнэ гэсэн төсөөлөл дээр үндэслэдэг.

2.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО

Бодит үнэ цэнийн тодорхойлолт (үргэлжлэл)

Санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилтийг, тухайн зах зээлд оролцогч тал нь хөрөнгийг ашигласнаар хамгийн өндөр эдийн засгийн үр өгөөжийг хүртэж чадаж байх уг хөрөнгийг борлуулснаар худалдан авсан талд уг хөрөнгийг ашигласнаар хамгийн өндөр эдийн засгийн үр өгөөжийг өгч байх, нөхцөлд тооцно.

Банк нь бодит үнэ цэнэ тооцоход шаардлагатай мэдээллүүд нь хангалттай олдцотой үед үнэлгээний техникүүдийг хэрэглэх нь тохиромжтой байдаг ба ажиглагдахуйц өгөгдлийн хэрэглээг нэмэгдүүлж, үл ажиглагдахуйц өгөгдлийн хэрэглээг хамгийн бага түвшинд байлгадаг.

Бодит үнэ цэнээрээ хэмжигдэж, санхүүгийн тайланд тайлагнаж багаа бүх хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлох, толилуулахдаа дараах түвшнийг хэрэглэдэг. Үүнд:

- Түвшин 1- санхүүгийн хэрэглүүр – үнэлгээнд ашиглагдсан өгөгдлүүд нь хэмжилтийн өдрөөрх бирж дээр бүртгэлтэй ижил төсөөтэй хөрөнгө болон өр төлбөрийн (залруулаагүй) идэвхтэй зах зээл дээрх үнэ юм. Банк нь хэмжээ болон хөрвөх чадварын хувьд адил төсөөтэй хөрөнгө болон өр төлбөрийг санхүүгийн тайлангийн өдрөөр боломжтой, заавал болон хэрэгжих үнийн хангалттай арилжааны үйл ажиллагаатай байхыг идэвхтэй зах зээл гэж үзнэ.
- Түвшин 2- санхүүгийн хэрэглүүр – Үнэлгээнд ашиглагдсан өгөгдлүүдийг санхүүгийн хэрэглүүрийн дуусах хугацааны туршид боломжтой байх зах зээлийн бүх өгөгдлүүдээс шууд болон шууд бусаар үнэлгээнд ашигласан өгөгдлүүд юм. Эдгээр өгөгдлүүдийн дотор идэвхтэй зах зээл дээрх ижил төстэй хөрөнгө болон өр төлбөрийн үнэ, идэвхгүй зах зээл дээрх ижил төстэй хэрэглүүрийн үнэ болон үүнээс өөр хүүгийн түвшин, өгөөжийн муруй, харгалзах хэлбэлзэл, зээлийн эрсдэлийн үнэ гэх зэрэг ажиглагдахуйц өгөгдлүүд орно. Мөн түүнчлэн, тухайн хөрөнгийн шинж байдал болон байршил, харьцуулах зүйлсийн аль нь үнэлгээ тогтоосон хэрэглүүртэй холбогдох зэргээс хамааран залруулга хийж болно. Гэвч ажиглагдахуйц бус өгөгдөл дээр үндэслэн нийт хэмжилтэнд чухал ач холбогдолтой дээрх залруулгыг хийсэн бол Банк нь хэрэглүүрийг Түвшин 3-р ангилна.
- Түвшин 3 – санхүүгийн хэрэглүүр – Эдгээрт, хэмжилтийн хувьд бүхэлдээ чухал ач холбогдол бүхий нэг болон түүнээс дээш ажиглагдахуйц бус өгөгдлүүд багтана.

Банк нь үнэлгээний техник болон хэрэгжүүлж буй аргачлалууд болон загварын тохируулгуудыг тогтмол шалгаж үздэг. Гэвч суурь загвар нь Банкны санхүүгийн хэрэглүүрийг үнэлэхтэй холбоотой бүх хүчин зүйлүүд болох зээлийн эрсдэл, өөрийн зээлийн болон/эсвэл санхүүжилтийн зардал зэргийг бүрэн дүүрэн хамруулж чадахгүй байх магадлалтай юм.иймд Банк нь бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хэрэглүүртэй холбоотой зээлийн эрсдэлийг тооцоолоход төрөл бүрийн техник хэрэглэдэг ба үүнд хөрөнгө тус бүрийн хувьд ашиглалтын хугацааны туршид холбогдох талд хүлээгдэж буй зээлийн эрсдэлийг багцад суурилан тооцох аргачлал багтдаг бөгөөд энэ нь холбогдох талд хүлээгдэж буй барьцаагүй санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдэлийг тусгахын тулд хийгддэг. Банк өөрийн зээлийн үнэ цэнийг зах зээлийн бодит өгөгдлүүдээс, тухайлбал, арилжаалагдсан өрийн хоёрдогч үнэ зэргээс тооцдог.

Тайлант хугацааны эцэс бүрд Банк нь санхүүгийн тайландаа тайлагнасан хөрөнгө, өр төлбөрийн хувьд түвшин хооронд хөдөлгөөн гарсан эсэхийг дахин нягталж үздэг.

Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн шинжилгээ болон бусад шаардлагатай мэдээллийг Тодруулга 29-д тусгасан.

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр

Бусад Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах хадгаламж, харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа болон хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хэрэглүүр

Банк нь доорх нөхцөлүүд хангагдсан тохиолдолд бусад Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах хадгаламж, харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа болон бусад санхүүгийн хэрэглүүрийг хорогдуулсан өртгөөр бүртгэхэд ангилна:

- Бизнесийн загварын зорилго нь гэрээнд заасан мөнгөн төлбөрийг цуглуулах зорилгоор санхүүгийн хөрөнгийг эзэмшдэг.
- Санхүүгийн хөрөнгүүдийн гэрээний нөхцөл нь тодорхой үеүүдэд үлдэгдлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийн мөнгөн гүйлгээг ихэсгэдэг.

Эдгээр нөхцөлүүдийн дэлгэрэнгүй тайлбарыг дор үзүүлэв.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр (үргэлжлэл)

Бизнесийн загварын үнэлгээ. Банкны бизнес загвар нь хэрэглүүрийн түвшинд биш нийлмэл багцын түвшинд хянагддаг ба дараах ажиглагдахуйц хүчин зүйлсээс хамаарна:

- Бизнес загварын (тухайн бизнес загварт хамаарагдах санхүүгийн хөрөнгө) үр дүнд нөлөөлж буй эрсдэл ба эдгээр эрсдэлийг хэрхэн хянах аргачлал
- Эдгээр хөрөнгүүдээс мөнгөн гүйлгээг өмнө нь хэрхэн хүлээн авч байсан туршлага
- Багцын гүйцэтгэлээс хэмжих болон тайлагнахад ашигласан хэмжигдэхүүнүүд
- Байгууллагын удирдлагуудад хэрхэн урамшуулал олгодог (санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ эсвэл гэрээний цуглуулсан мөнгөн урсгал дээр үндэслэдэг)

Борлуулалтын хүлээгдэж буй давтамж, үнэ цэнэ ба хугацаа нь үнэлгээ хийхэд чухал хүчин зүйл болно.

Бизнес загварын тест нь хамгийн боломжит хувилбар дээр үндэслэдэг ба ‘хамгийн муу’ эсвэл ‘стресс’ нөхцөлүүдийг харгалзан үздэггүй. Хэрэв анхны хүлээн зөвшөөрөлтийн дараах мөнгөн урсгал нь анхны таамагласан хүлээлтээс өөр байвал Банк тухайн бизнес загварт хамааралтай санхүүгийн хөрөнгийн ангиллыг солиогүй бөгөөд харин уг мэдээллийг санхүүгийн хөрөнгө шинээр худалдаж авах үед үнэлгээндээ оруулдаг.

Үндсэн төлбөр ба хүүгийн төлбөрийн шалгуур (ҮТХТ шалгуур). Санхүүгийн хэрэглүүрийн ангиллын хоёр дахь шат бол Банк үндсэн болон хүүгийн төлбөрийн шалгуурын шаардлагыг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нөхцөлийг дүгнэдэг.

Энэхүү шалгуурын хүрээнд ‘Үндсэн’ гэдэг нь анхны хүлээн зөвшөөрөх үсийн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ бөгөөд санхүүгийн хөрөнгийн ашиглах хугацааны туршид өөрчлөгдөж болно (жишээ нь үндсэн төлбөрийн эргэн төлөлт эсвэл урамшуулал/хөнгөлөлтийн хорогдуулалт)

Зээлийн гэрээн дэх хүүгийн хамгийн гол элемент нь мөнгөний өнөөгийн үнэ цэнэ болон зээлийн эрсдэл байдаг. Үндсэн төлбөр ба хүүгийн төлбөрийн шалгуурын үнэлгээг хийхийн тулд Банк нь хүүгийн түвшнийг тогтоосон хугацаа гэх мэт холбогдох хүчин зүйлс, үнэлэмжийг авч үздэг.

Нөгөө талаас, эрсдэл үүрэх магадлал багатай гэрээний заалт эсхүл үндсэн зээлийн зохицуулалттай холбоогүй гэрээний мөнгөн урсгалын тогтворгүй байдал зэрэг нь зөвхөн үндсэн болон хүүгийн төлбөрийн үлдэгдэл дүнгийн гэрээний мөнгөн урсгалд нөлөөлөхгүй. Ийм тохиолдолд санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ.

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд бүртгэх үүсмэл санхүүгийн хэрэглүүр

Үүсмэл санхүүгийн хэрэглүүр нь санхүүгийн хэрэглүүр эсвэл бусад гэрээ байхын тулд доорх гурван шинж чанарыг бүхэлд нь агуулах шаардлагатай:

- Үнэ цэнэ нь тодорхой хүүгийн түвшин, санхүүгийн хэрэглүүрийн үнэ, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ, валютын ханшийн өөрчлөлт, зээлжих зэрэглэл болон гэрээний холбогдох талын үүрэг хариуцлагад хамаарахгүй бусад хувьсагчийн өөрчлөлтөөс хамаардаг бол
- Анхны цэвэр хөрөнгө оруулалт шаарддаггүй эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөд ижил байдлаар хандахаар хүлээгдэж буй адил төсөөтэй гэрээнд шаардлагатайгаас бага анхны цэвэр хөрөнгө оруулалт шаарддаг бол
- Ирээдүйд төлөгдөхөөр бол

Банк нь төрөл бүрийн харилцагчидтай үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн хэлцлүүд хийдэг бөгөөд эдгээрт кросс своп, гадаад валютын болон хүүгийн форвард гэрээ хэлцлүүд зэрэг орно. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийг бодит үнэ цэнээр нь бүртгэдэг ба бодит үнэ цэнэ нь эерэг байгаа үед хөрөнгө, харин сөрөг байгаа үед өр төлбөр гэж бүртгэнэ.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр (үргэлжлэл)

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд бүртгэх үүсмэл санхүүгийн хэрэглүүр (үргэлжлэл)

Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг хейджийн нягтлан бодох бүртгэл хэрэглэж байгаагаас бусад үед “Бусад орлого”-д бүртгэдэг.

Санхүүгийн хэрэглүүрт агуулагдсан санхүүгийн үүсмэл хэрэглүүр нь дээр дурдсан тодорхойлолтод нийцэж байгаа ба эдийн засгийн үзүүлэлт болон эрсдэлийн хувьд агуулагч гэрээтэй нягт холбоотой биш, мөн агуулагч гэрээг арилжааны зорилгоор эзэмшээгүй тохиолдолд тус санхүүгийн үүсмэл хэрэглүүрийг салгаж бодит үнэ цэнээр бүртгэнэ. Агуулагч гэрээнээс салгасан санхүүгийн үүсмэл хэрэглүүрийг бодит үнээр арилжааны багцад хүлээн зөвшөөрөх ба бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Арилжаалах зориулалттай санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр

Банк нь санхүүгийн хөрөнгийг арилжааны үйл ажиллагаагаар дамжуулан богино хугацаанд ашиг олох зорилгоор худалдаж авсан эсвэл багцаар нь удирдаж буй санхүүгийн хэрэглүүрийн багцын нэг хэсэг болгон арилжаалах зориулалттай гэж ангилдаг. Арилжаалах зориулалттай хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь хэмжин бүртгэдэг. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг цэвэр арилжааны орлогод хүлээн зөвшөөрнө. Хүү, ногдол ашгийн орлого болон зардлыг гэрээний нөхцөлийн дагуу, эсвэл төлбөр хийх эрх нь тогтоогдсон үед арилжааны цэвэр орлогод бүртгэнэ.

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэх өрийн хэрэглүүр

Банк нь өрийн хэрэглүүрийг доорх нөхцөлүүдийг хангасан тохиолдолд Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх өрийн хэрэглүүрт ангилна:

- Бизнесийн загварын дагуу гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах болон санхүүгийн хэрэглүүрийг борлуулах зорилгоор эзэмших
- Санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөл нь зөвхөн үндсэн төлбөр ба хүүгийн шалгуурыг хангах

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүр нь бодит үнэ цэнээр хэмжигдэх бөгөөд бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз, гарз нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэнэ. Хүүгийн орлого болон гадаад валютын ханшийн олз, гарзыг хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгүүдийн адил ашиг алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүрийн зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын тооцооллыг 29-р тодруулгад тайлбарласан болно. Үл хүлээн зөвшөөрөх үед бусад орлогод хуримтлагдсан олз, гарз нь бусад дэлгэрэнгүй орлогын тайлангаас ашиг, алдагдалын тайлан руу дахин ангилагдана.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өмчийн хэрэглүүр

Анх хүлээн зөвшөөрсний дараа, Банк НББОУС-32 санхүүгийн хэрэглүүр толилуулга болон арилжаалах зорилгоор эзэмшдэггүй өмчийн тодорхойлолтод нийцсэн зарим өмчийн хэрэглүүрийг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх өмчийн хэрэглүүр рүү буцаах боломжгүйгээр ангилна. Энэ ангилал нь хэрэглүүрийн түвшинд суурилан тодорхойлогддог.

Энэ өмчийн хэрэглүүрийн олз гарзыг хэзээ ч ашиг алдагдлын тайланд бүртгэхгүй. Банк хүлээн авах орлогын санхүүгийн хэрэглүүртэй холбоотой зардлыг нөхөн төлбөрт ашигласан тохиолдолд ашиг нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх бол бусад үед төлбөрийн эрх нь баталгаажсан тохиолдолд ногдол ашгийг бусад үйл ажиллагааны орлого гэж ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэх өмчийн хэрэглүүр нь үнэ цэнийн бууралтын үнэлгээнд хамаарахгүй.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр (үргэлжлэл)

Гаргасан өрийн хэрэглүүр ба зээлээр авсан санхүүжилт

Анх хүлээн зөвшөөрсний дараа, зээллэгүүдийг дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг тооцохдоо зээл авах үеийн хөнгөлөлт, урамшуулал ба үр ашигт хүүгийн нэг салшгүй хэсэг болж буй зардлуудыг авч үзнэ. Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн аль алиных нь элементүүдийг агуулсан нийлмэл санхүүгийн хэрэглүүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг, хүлээн зөвшөөрөгдөх өдөр салгана.

Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн аль алиных нь элементүүдийг агуулсан нийлмэл санхүүгийн хэрэглүүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хүлээн зөвшөөрөгдөх тусад нь бүртгэнэ. Банк нь эдгээр үүсмэл бус санхүүгийн хэрэглүүрийг бүртгэлд тусгахдаа эхлээд тухайн хэрэглүүр нь нийлмэл эсэх талаар болон тухайн хэрэглүүр болон бүрэлдэхүүн хэсгүүдийг НББОУС 32-н дагуу санхүүгийн өр төлбөр болон хөрөнгө эсвэл өөрийн хөрөнгө гэж ангилна. Банк нь санхүүгийн хэрэглүүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө: (а) Банкинд санхүүгийн өр төлбөр болж байвал, (б) Тухайн хэрэглүүрийг эзэмшигчид, Банкны өөрийн хөрөнгөнд хөрвөх боломж олгож байвал. Хөрвөх хэрэгслийн өр төлбөр болон өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнүүдийн ангилал нь, тухайн хөрвөх нөхцөл нь зарим нэг эзэмшигчдийн хувьд эдийн засгийн давуу талтай байсан ч хөрвөх нөхцөл нь хэрэгжих эсэх болон түүний өөрчлөгдөх магадлалаас шалтгаалан өөрчлөгддөггүй. Хөрвөх санхүүгийн хэрэглүүрийн өөрийн хөрөнгө болон өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн бүртгэлийн дүнг хуваарилахдаа, өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүний дүн нь тухайн хэрэглүүрийн нийт бодит үнэ цэнээс өр төлбөрийн бүрэлдэхүүн гэж тусад нь тодорхойлсон дүнг хассанаас үлдсэн дүн байна. Нийлмэл санхүүгийн хэрэглүүрт агуулагдсан өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнээс (өөрийн хөрөнгийн хөрвөх нөхцөл гэх мэт) бусад аливаа үүсмэл хэрэглүүрийн үнэ цэнэ нь (худалдан авах опцион гэх мэт) өр төлбөрийн бүрэлдэхүүнд багтана. Банк нь тухайн хэрэглүүрийн өөрийн хөрөнгө болон өр төлбөрийн бүрэлдэхүүнүүдийг тусад нь бүртгэх гэж буй бол тухайн өр төлбөрт салгах шаардлагатай агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүр байгаа эсэхийг үнэлнэ.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр

Энэ ангилал дахь санхүүгийн хөрөнгө нь арилжаалах зорилгоор эзэмшээгүй бөгөөд анх хүлээн зөвшөөрөхдөө удирдлагаас тодорхойлогдсон эсвэл СТОУС-9-н дагуу бодит үнэ цэнээр хэмжих зайлшгүй шаардлагатай гэж тодорхойлсон байна.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө нь санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр бүртгэгдэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгөд тодорхойлсон хэрэглүүрээс олсон хүүгийн орлого эсвэл зардал нь үр ашигт хүүг ашиглан мөн хөнгөлөлт/урамшууллыг нь харгалзах дүнгээр тооцдог. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгөөс олсон хүүгийн хэмжээг гэрээний хүүг ашиглан бүртгэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх өмчийн хэрэглүүрийн ногдол ашгийн орлогыг төлбөр хийх эрх тогтоогдсон үед үйл ажиллагааны бусад орлогод бүртгэнэ.

Санхүүгийн баталгаа, аккредитив болон ашиглагдаагүй зээлийн үүрэг

Банк нь санхүүгийн баталгаа, аккредитив болон зээлийн амлалт гаргадаг. Санхүүгийн баталгаа гаргаж өгсний улмаас хүлээн авсан урамшууллыг санхүүгийн тайлангуудад анхлан бүртгэхдээ бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Ийнхүү анхлан хүлээн зөвшөөрсний дараагийн тайлант үед баталгаа бүрд Банкны хүлээх хариуцлагыг хэмжихдээ анхлан хүлээн зөвшөөрсөн дүнгээс ашиг, алдагдлын тайланд бүртгэсэн хуримтлагдсан хорогдлыг хассан дүн хоёрын аль өндрөөр нь хэмжинэ.

Хүлээн авсан урамшууллыг баталгааны хугацааны туршид ашиг, алдагдлын тайланд “Хураамж ба шимтгэлийн орлого”-оор хүлээн зөвшөөрнө.

Ашиглагдаагүй зээлийн үүрэг болон аккредитив нь амлалт бөгөөд энэхүү амлалтын хугацаанд Банк нь урьдчилан тодорхойлсон нөхцөлтэй зээлийг харилцагчид олгох шаардлагатай. Санхүүгийн баталгааны гэрээнүүдийн адилаар тэдгээр гэрээнүүдэд “Зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал”-ын шаардлагуудын дагуу сан байгуулна. Санхүүгийн баталгаа, аккредитив болон ашиглагдаагүй зээлийн гэрээний үнэ цэнэ нь зах зээлд олгогдох зээлийн гэрээний нөхцөлтэй ижил байхаас гадна санхүүгийн

байдлын тайланд тусгагдахгүй. Энэхүү санхүүгийн хэрэглүүрийн нэрлэсэн үнэ болон үнэ цэнийн бууралтын хүлээгдэж буй алдагдал нь Тодруулга 33-д тусгагдсан.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийн дахин ангилал

Банк санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрснөөс хойш бизнесийн шугам худалдан авах, дуусгах болон цуцлах онцгой нөхцөл байдлаас бусад нөхцөлд дахин ангилахгүй. Санхүүгийн өр төлбөр дахин ангилагддаггүй.

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн өөрчлөлт

Санхүүгийн хөрөнгө өөрчлөх

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын болог зээлийн эрсдэлийн бус шалтгаанаар арилжааны бүтцийн өөрчлөлтийн үйл ажиллагааны үр дүнд гэрээний мөнгөн гүйлгээг дахин тохиролцсон эсвэл өөр хэлбэрээр бүтцийн өөрчлөлт оруулсан тохиолдолд, Банк уг өөрчлөлт нь тухайн санхүүгийн хөрөнгийг данснаас хасахад хүргэсэн эсэхийг тодорхойлох үнэлгээг хийдэг. Санхүүгийн хөрөнгийн хувьд энэхүү үнэлгээ нь чанарын хүчин зүйл дээр суурилдаг.

Банк харилцагчид олгосон зээлийг үл хүлээн зөвшөөрөх эсэхийг үнэлэхдээ доорх нөхцөлүүдийг авч үздэг.

- Зээлийн валют өөрчлөгдсөн
- Өмчийн шинж чанар тодорхойлогдсон
- Бизнесийн түнш өөрчлөгдсөн
- Өөрчлөлтийн улмаас ҮТХТ-ийн шалгуур хангахгүй байх

Хэрвээ өөрчлөлт нь мөнгөн урсгалд мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй бол энэ өөрчлөлтийг үл хүлээн зөвшөөрөх гэж авч үзэхгүй. Мөнгөн урсгалын өөрчлөлтийг анхны үр ашигт хүүгээр хорогдуулсан дүнд үндэслэн Банк үнэ цэнийн бууралтын алдагдал бүртгээгүй бол өөрчлөлтийг нь ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ.

Санхүүгийн өр төлбөрийг өөрчлөх

Одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн нөхцөлийн өөрчлөлт нь ихээхэн ач холбогдолтой гэж дүгнэгдээгүй, улмаар данснаас хасахад хүргэхгүй бол санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртгийг гэрээнд заасан ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг тооцоолохдоо санхүүгийн өр төлбөрийн анхны үр ашигт хүүгийн хямдруулалтын аргаар дахин тооцоолно. Үүний үр дүнд гарсан аливаа зөрүүг шууд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Банк санхүүгийн өр төлбөрийн хувьд, чанарын хүчин зүйлээс хамаарч, засварласан хямдруулсан өнөөгийн үнэ цэнэ болон санхүүгийн өр төлбөрийн анхны дансны үнийн хооронд арав буюу түүнээс дээш хувьтай зөрүү гарахад хүргэсэн өөрчлөлтийг мэдэгдэхүйц гэж үзнэ.

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт

Хугацаа болон нөхцөлд их хэмжээгээр өөрчлөлт орсонтой холбоотой үл хүлээн зөвшөөрөх

Харилцагчдад олгосон зээл гэх мэт санхүүгийн хөрөнгийг гэрээний нөхцөл нь шинэ зээл шиг болж өөрчлөгдөхөд үл хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралт хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд эдгээр хөрөнгийн хувьд зөрүүг нь үл хүлээн зөвшөөрөлтийн олз, гарзаар бүртгэнэ. Шинээр хүлээн зөвшөөрсөн зээл нь үнэ цэнэ буурсан зээлийг худалдаж авсан нөхцөлд биш бол уг зээл нь зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал тооцоолох үүднээс 1-р шатлалд ангилагдана.

Их хэмжээний өөрчлөлтөөс бусад үед үл хүлээн зөвшөөрөх

Санхүүгийн хөрөнгө. Банк санхүүгийн хөрөнгийг (санхүүгийн хөрөнгийн хэсэг эсвэл хоорондоо төстэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгүүдийн хэсэг) тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан үед үл хүлээн зөвшөөрнө. Мөн Банк нь хөрөнгийг шилжүүлсэн бөгөөд шилжүүлэлт нь үл хүлээн зөвшөөрөх шаардлагыг хангаж байгаа нөхцөлд хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр (үргэлжлэл)

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (санхүүгийн хөрөнгийн хэсэг эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгийн хэсэг) үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Банк тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхээ шилжүүлсэн, эсвэл
- “Дамжуулан өнгөрөөх” хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн.

Дамжуулан өнгөрөөх хэлцэл нь Банк нь тухайн санхүүгийн хөрөнгөөс хүлээх гэрээний эрхээ хадгалж үлдэх, бөгөөд (анхны хөрөнгө) доорх гурван нөхцөл биелж байх нөхцөлд гэрээний үүргийн дагуу тэдгээр хүлээн авсан мөнгөн урсгалыг нэг болон түүнээс дээш байгууллагад (эцсийн хүлээн авагчид) шилжүүлнэ:

- Хэрэв тухайн нэг байгууллагын зээлдүүлсэн дүн дээр зах зээлийн хүүгээр хуримтлагдсан хүүтэй хамт бүрэн авах эрхтэй богино хугацаат урьдчилгааг оруулахгүйгээр Банк нь эцсийн хүлээн авагчид анхны хөрөнгө нь дүйцэх хэмжээний мөнгөн урсгалыг цуглуулаагүй цагт ямар нэгэн төлбөр төлөх үүрэггүй болно.
- Банк нь эцсийн хүлээн авагчдаас үнэт цааснаас бусад нөхцөлөөр анхны хөрөнгийг зарах эсвэл барьцаалж болохгүй.
- Банк нь эцсийн хүлээн авагчдын өмнөөс цуглуулсан мөнгөн урсгалыг удаан хугацаагаар саатуулалгүйгээр шилжүүлэх үүрэгтэй.

Шилжүүлэлтийг зөвхөн доорх нөхцөлүүдийг хангасан тохиолдолд үл хүлээн зөвшөөрнө:

- Банк хөрөнгийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн, эсвэл
- Банк нь тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг шилжүүлээгүй болон хадгалж үлдээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн.

Хэрвээ шилжүүлэгч холбогдолгүй гуравдагч этгээдэд хөрөнгийг бүхэлд нь зарах болон шилжүүлэхэд нэмэлт хязгаарлалтгүйгээр тухайн чадварыг эзэмшдэг гэж үзсэн үед Банк хяналтыг шилжүүлсэн гэж үзнэ.

Банк хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл “дамжуулан өнгөрөөх” хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнх эрсдэл, өгөөж болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Банкны уг хөрөнгөд үргэлжлүүлэн оролцсоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Банк холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө. Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөр Банкны хадгалж үлдсэн эрх, үүргийг тусган харуулсан сууриар хэмжинэ.

Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Банкны төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ. Хэрэв шилжүүлсэн хөрөнгөд үргэлжилсэн оролцоо бичгээр эсвэл худалдан авах опцион (эсвэл аль аль нь) хэлбэрээр байвал, Банкны үргэлжилсэн оролцоо нь эргүүлэн худалдан авахад төлөх шаардлагатай дүнгээр хэмжигдэнэ. Хөрөнгөд бичгээр худалдан авах опцион заасан байгууллагын үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ болон нөхцөлийн хэрэгжих үнийн аль багаар хязгаарлагдана.

Санхүүгийн өр төлбөр

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзнэ. Анхны санхүүгийн өр төлбөрийн бүртгэлийн дүн ба төлсөн дүн хоёрын зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Гэрээний нөхцөлд өөрчлөлт орсон зээлүүд

Банк заримдаа барьцаа хөрөнгийг хураах гэхээсээ илүү зээлдэгчийн санхүүгийн хүндрэлийн улмаас зээлийн анхны нөхцөлд хөнгөлөлт, өөрчлөлт оруулдаг. Зээлдэгчийн одоогийн эсвэл хүлээгдэж буй санхүүгийн хүндрэлээс үүдэн хөнгөлөлт, өөрчлөлтийг хийсэн ба зээлдэгч санхүүгийн хувьд хэвийн байсан бол Банк энэхүү хөнгөлөлт, өөрчлөлтийг зөвшөөрөхгүй байх байсан тохиолдолд уг зээлийг Банк өөрчлөлттэй зээл гэж үзнэ. Санхүүгийн хүндрэлийг харуулсан үзүүлэлтүүд нь гэрээний шалгуур үзүүлэлтүүдийг хангахгүй байх эсвэл Зээлийн Эрсдэлийн хэлтсээс гаргасан үзүүлэлтүүдээр тодорхойлогдоно.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)**Гэрээний нөхцөлд өөрчлөлт орсон зээлүүд (үргэлжлэл)**

Энэхүү өөрчлөлтүүдэд төлбөрийн хугацааг сунгах, зээлийн шинэ нөхцөл тохирох зэрэг орно. Банк нь нөхцөл өөрчилсөн зээлийг тогтмол хянах бодлого баримталж ирээдүйн зээлийн төлөлт тасалдахгүй төлөгдөх боломжийг хянадаг.

Хэрэв ихээхэн өөрчлөлттэй бол дээр тайлбарласны дагуу зээлийг үл хүлээн зөвшөөрнө. Зээлийг үл хүлээн зөвшөөрөхгүйгээр, зээлийн нөхцөлийг дахин авч хэлэлцсэний дараа нөхцөл өөрчлөхөөс өмнө тооцсон анхны үр ашигт хүүгээр үнэ цэнийн бууралтыг тооцдог.

Зээлийн нөхцөл дахин тохирч, өөрчилсөн хэдий ч үл хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд зээлийн эрсдэл ихээхэн хэмжээгээр нэмэгдсэн гэж үздэг тул зээлийг 2-р шатанд ангилдаг. Нөхцөл өөрчилсөн актив гэж ангилагдсан харилцагч уг ангиллаас гарахын тулд дараах бүх шалгуурыг хангасан байх шаардлагатай

- Бүх зээлүүд нь хэвийн байх ёстой
- Хамгийн багадаа туршилтын хугацааны талд нь шинэчилсэн эргэн төлөлтийн хуваарийн дагуу тогтмол төлбөрийг хийсэн байх
- Үйлчлүүлэгч 30 хоногоос дээш хугацаа хэтрэлтэй гэрээгүй байх

Шинэчилсэн буюу Өөрчлөлт орсон хөрөнгийн талаарх мэдээллийг 8-р тодруулгад тусгасан болно.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

“Зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал (ЗҮЦХА)” аргын ерөнхий ойлголт

Банк “санхүүгийн хэрэглүүр” ангилалд хамаарах зээлийн үүрэг болон санхүүгийн баталгаа, бодит үнэ цэнийн өөрчлөлт ашиг, алдагдлын тайланд бүртгэгдээгүй бусад өрийн хэрэглүүр болон бүх зээлд зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын сан байгуулсан. СТОУС-9-н дагуу өмчийн хэрэглүүр нь үнэ цэнийн бууралтанд орохгүй. Зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал нь хөрөнгийн ашиглалтын нийт хугацаанд үүсэх зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлаас хамаарна. Хэрвээ анх бүртгэснээс алдагдал нь мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн бол алдагдал нь 12 сарын хүлээгдэж буй алдагдлаас хамаарна. Зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өөрчлөгдсөнийг хэмжих Банкны бодлого журмыг тодруулга 29-д тусгасан.

Ирээдүйн 12 сарын ЗҮЦХА нь нийт хугацааны ЗҮЦХА аргын нэг хэсэг байх бөгөөд тайлагналын өдрийн дараах 12 сард санхүүгийн хэрэглүүрийн чанаргүйдлийн магадлалын үр дүнгээр ЗҮЦХА-г илэрхийлнэ.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)**Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)**

Санхүүгийн хэрэглүүрийн үндсэн багцаас шалтгаалан нийт хугацааны ЗҮЦХА болон ирээдүйн 12 сарын ЗҮЦХА-г тусгай болон бүлгийн үнэлгээгээр тооцоолно. Банк нь бүлэг санхүүгийн хөрөнгийг бүлгийн үнэлгээний аргаар хэмжинэ. Банк нь үнэлгээ хийх журмыг тодорхойлсон бөгөөд тайлант үеийн эцэс бүрд санхүүгийн хэрэглүүрийн үлдэх хугацаанд үүсэж болох эрсдэлийн өөрчлөлтийг харгалзан санхүүгийн хэрэглүүрийг анх бүртгэснээс хойш ЗҮЦХА-д мэдэгдэхүйц өссөн эсэхийг харгалзан авч үзнэ.

Дээр дурдсан процесс дээр тулгуурлан, доор дурдсанаар Банк зээлийг шатлал 1, шатлал 2, шатлал 3 гэж ангилдаг.

Шатлал 1: Зээлийг анх хүлээн зөвшөөрөх үед Банк нь 12 сарын ЗҮЦХА-г бүртгэнэ. Мөн шатлал 1-рүү үүсч болох эрсдэл нь буурсан шатлал 2-ын зээлүүд дахин ангилагдана.

Шатлал 2: Анх хүлээн зөвшөөрсөн үеэс зээлийн үүсэж болох эрсдэл ихэссэн үед Банк нь нийт хугацааны ЗҮЦХА-г бүртгэнэ. Мөн шатлал 2-руу үүсэж болох эрсдэл нь буурсан шатлал 3-ын зээлүүд дахин ангилагдана.

Шатлал 3: Үнэ цэнийн бууралтад орсон зээлүүд багтана. Банк нь нийт хугацааны турш ЗҮЦХА-г бүртгэнэ.

ХААҮЦБ: ХААҮЦБ хөрөнгө нь анх хүлээн зөвшөөрөх үед үнэ цэнэ буурсан байсан санхүүгийн хөрөнгө юм. ХААҮЦБ хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр бүртгэх бөгөөд дараа үеийн хүүгийн орлогыг үнэ цэнийн бууралтаар тохируулсан ҮАХ-р тооцно. Тус хөрөнгийн хүлээгдэж буй зээлийн алдагдалд өөрчлөлт орсон тохиолдолд зөвхөн холбогдох ЗҮЦХА-г тэр хэмжээгээр нэмэгдүүлж эсвэл багасгана.

Банк нь санхүүгийн хөрөнгийг төлөгдөх нийт дүн эсвэл зарим хэсгийг төлөгдөх боломжгүй гэж үзвэл санхүүгийн хөрөнгийн дансны үнийг бууруулна. Үүнийг санхүүгийн хөрөнгийн (хэсэгчилсэн) үл хүлээн зөвшөөрөлт гэнэ.

ЗҮЦХА тооцоолол

Банк нь үр ашигт хүүгээр хорогдуулсан хүлээгдэж буй мөнгөний дутагдлыг хэмжих магадлалын-жигнэсэн гурван хувилбараар ЗҮЦХА-г тооцоолдог. Мөнгөний дутагдал нь гэрээний дагуух мөнгөн гүйлгээ болон эргэн төлөгдөхөөр хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний зөрүү юм.

ЗҮЦХА тооцооллын механизмыг болон гол элементүүдийн хамт доор үзүүлэв:

ЧМ Чанаргүйдлийн магадлал (ЧМ) нь өгөгдсөн цаг хугацаанд төлбөрийн чадваргүй болох магадлалаар тооцоолно. Хэрвээ хэрэглүүр нь өмнө нь үл хүлээн зөвшөөрч байгаагүй мөн харгалзах багцад үргэлжлүүлэн байгаа бол үнэлсэн хугацааны тодорхой хугацаанд нэг удаа алдагдал үүсэх боломжтой.

ЧӨД Чанаргүйдэлд өртөх дүн (ЧӨД) нь тайлагналын дараах зээлийн хүлээгдэж буй өөрчлөлт, гэрээний дагуух үндсэн төлбөр болон хүүгийн эргэн төлөлт, зээлийн үүргийн хүрээнд нэмж олгосон дүн болон төлбөр хоцорсноор үүсэх хуримтлагдсан хүүг харгалзсан тооцоолол.

АХЧ Алдагдалд хүргэх чанаргүйдэл (АХЧ) нь өгөгдсөн цаг хугацааны туршид чанаргүйдлийн үеийн алдагдлын тооцоолол юм. Энэ нь гэрээний дагуу мөнгөн урсгал болон зээлдэгч хүлээн авахаар тооцоолсон дүн, барьцаа хөрөнгө борлуулсан дүнгийн нийлбэрийн зөрүүнээс тооцно.

ЗҮЦХА тооцоолох үед Банк гурван хувилбарыг авч үздэг (суурь, эерэг болон сөрөг). Эдгээр нь өөр өөр ЧМ, ЧӨД болон АХЧ-д хамаарагдана.

ЗҮЦХА-г ЧМ, ЧӨД, АХЧ-г ирээдүйн сар бүр болон тусгайлсан эсвэл бүлгийн сегмент бүрээр төсөвлөн тодорхойлдог. Эдгээр гурван үндсэн бүрэлдэхүүнийг хооронд нь үржүүлэн, цаашид эдгээр нь хэвээр үйлчлэх магадлалаар мөн тохируулна (тухайлбал, чанаргүйдэлд өртөх дүн нь ойрын саруудад урьдчилан төлөгдөхгүй эсвэл чанаргүйдэхгүй). Үүгээр ирээдүйн сар бүрээрх ЗҮЦХА-г тооцох ба тайлагналын өдрөөр үүнийг буцаан дискаунтлан нийлбэрийг нь авдаг. ЗҮЦХА-ийн тооцоололд ашиглагдах дискаунтын хувь нь зээлийн анхны үр ашигт хүүгийн хувь байх эсвэл түүний ойролцоо хувь байна.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)**Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)**

Үнэ цэнийн бууралтын зардал болон буцаалт нь санхүүгийн хөрөнгийн дансны үнийн өөрчлөлтийн ашиг, алдагдлын тохируулгаас тусдаа бүртгэгдэх болон толилуулагдана.

ЗҮЦХА-ын тооцооллын аргыг доор хураангуйлав:

Шатлал 1:	Ирээдүйн 12 сарын ЗҮЦХА нь нийт хугацааны ЗҮЦХА загварын нэг хэсэг байх бөгөөд тайлагналын өдрийн дараах 12 сард санхүүгийн хэрэглүүрийн чанаргүйдлийн үр дүнгээр ЗҮЦХА-ыг илэрхийлнэ. Банк нь ирээдүйн 12 сарын ЗҮЦХА тайлагналын өдрөөс хойш 12 сарын дотор ЧМ-д үндэслэн тооцдог. ЧӨД-ийн урьдчилсан төсөөлөлд 12 сарын дотор хүлээгдэж буй ЧМ-ыг хэрэглэх бөгөөд хүлээгдэж буй АХЧ-аар үржүүлэгдэж анхны үр ашигт хүүтэй ойролцоо дүнгээр хорогдуулна.
Шатлал 2:	Зээлийг анх олгосноос хойш тухайн зээлд зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлттэй байгаа нь тогтоогдсон зээлүүдэд Банк нь нийт хугацааны ЗҮЦХА-ын сан байгуулан бүртгэнэ. Санг байгуулахдаа хэд хэдэн хувилбарууд дээр үндэслэн тооцоолох боловч ЧМ болон АХЧ-ыг нь нийт хугацаанд тооцоолж гаргана. Хүлээгдэж буй мөнгөний дутагдалыг үр ашигт хүүтэй ойролцоо хувиар хорогдуулна.
Шатлал 3:	Үнэ цэнэ буурсан гэж үзсэн зээлийн хувьд, Банк нь нийт хугацааны ЗҮЦХА-ыг бүртгэнэ. Энэ аргачлал нь Шатлал 2-т ашигласантай ижил аргачлалаар тооцогдох бөгөөд ЧМ-ыг 100% гэж үзнэ
ХАҮҮЦБ:	ХАҮҮЦБ хөрөнгө анх хүлээн зөвшөөрөх үед үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгө юм. Банк нь зөвхөн анх хүлээн зөвшөөрсөн үеэс хойших магадлалаар жигнэсэн гурван хувилбарыг зээлээр тохируулсан үр ашигт хүүгээр хорогдуулсан хуримтлагдсан нийт хугацааны ЗҮЦХА-г хүлээн зөвшөөрнө.
Зээлийн үүрэг болон аккредитив	Зээлийн үүрэгт нийт хугацааны ЗҮЦХА тооцоход, Банк нь ирээдүйд олгогдох зээлийн үүргийн дүнг тооцоолно. Зээл олгогдох тохиолдолд ЗҮЦХА нь магадлал жигнэсэн гурван хувилбараар хүлээгдэж буй мөнгөний дутагдлын өнөөгийн үнэ цэнээр тооцогдоно. Хүлээгдэж буй мөнгөний дутагдал нь хүлээгдэж буй үр ашигт хүүгээр хорогдуулсан байна. Зээлийн үүрэг болон аккредитивын хувьд, ЗҮЦХА нь бусад өглөгт хүлээн зөвшөөрөгдөнө.
Санхүүгийн баталгааны гэрээнүүд	Банкны санхүүгийн баталгаа тус бүрийн үүрэг нь анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрөгдсөн хуримтлагдсан хорогдол хассан дүн болон ЗҮЦХА сангийн аль ихээр нь хэмжигдэнэ. Банк нь ЗҮЦХА-ыг эзэмшигчид нөхөн олгох дүнгийн өнөөгийн үнэ цэн дээр үндэслэн тооцно. Эрсдэлээр тохируулсан хүүгээр дутагдлыг хорогдуулна. Тооцоолол нь магадлалын-жигнэсэн гурван хувилбар дээр хийгдэнэ. Санхүүгийн баталгааны ЗҮЦХА нь бусад өглөгт хүлээн зөвшөөрөгдөнө

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэх өрийн хэрэглүүр.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүрийн ЗҮЦХА нь санхүү байдлын тайланд санхүүгийн хөрөнгийн дансны үнийг бууруулахгүй бөгөөд бодит үнэ цэнээр байна. Үүний оронд, хэрвээ хөрөнгө нь хорогдуулсан өртгөөр бүртгэсэн байсан бол үүсэх үнэ цэнийн бууралтыг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хуримтлагдсан үнэ цэнийн бууралтаар болон нөгөө талд ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ. Бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэсэн хуримтлагдсан алдагдлын хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх үед ашиг, алдагдлын тайланд шилжүүлэн бүртгэнэ.

Зээлийн сайжруулалт: Барьцаа хөрөнгийн үнэлгээ болон санхүүгийн баталгаа

Санхүүгийн хөрөнгийн эрсдэлийг бууруулах үүднээс, Банк нь боломжтой үедээ барьцаа хөрөнгийг ашигладаг. Барьцаа хөрөнгө нь төрөл бүрийн хэлбэрээр байдаг, жишээ нь: мөнгөн хөрөнгө, үнэт цаас, аккредитив болон баталгаа, үл хөдлөх хөрөнгө, авлага, бараа материал, бусад санхүүгийн бус хөрөнгө болон үр дүнгийн тооцооны гэрээ байна. Барьцаа хөрөнгийг эзэмшээгүй тохиолдолд Банкны санхүүгийн байдлын тайланд бүртгэхгүй.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)**Зээлийн сайжруулалт: Барьцаа хөрөнгийн үнэлгээ болон санхүүгийн баталгаа (үргэлжлэл)**

Зээлийн сайжруулалтаас хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг, СТОУС-ын дагуу тусад нь хүлээн зөвшөөрөх шаардлагагүй бөгөөд өр төлбөрийн хэрэглүүрийн гэрээний нөхцөлүүдийн салшгүй хэсэг гэж тооцогддог ба зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын хэмжилтэд оруулдаг. Үүний үндсэн дээр барьцаа хөрөнгийн бодит үнэ цэн нь үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын тооцоонд нөлөөлдөг. Барьцаа хөрөнгийг ерөнхийд нь хамгийн багадаа анх хүлээн зөвшөөрөхдөө болон хагас жилийн хугацаанд дахин үнэлдэг.

Боломжийг нэмэгдүүлэх зорилгоор, Банк нь барьцаа хөрөнгийн зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгийг үнэлэхдээ идэвхтэй зах зээлийн мэдээллийг ашигладаг. Идэвхтэй зах зээл байхгүй бусад санхүүгийн хөрөнгийг үнэлгээний аргыг ашиглан үнэлдэг.

Санхүүгийн бус барьцаа хөрөнгийг (жишээ нь: үл хөдлөх хөрөнгө) ипотекийн зуучлагч буюу 3 дагч этгээдээс ирсэн мэдээлэлд эсвэл орон сууцны үнийн индексүүдэд үндэслэн үнэлнэ. Барьцаалагдсан зээл нь зээлийн гэрээний нөхцөлд тусгагдсан эсвэл зээлийн салшгүй хэсэг болох ба зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын тооцоонд хамрагдсан болно.

Зээлийн гэрээний нөхцөлтэй холбоогүй баталгааг балансын гадуурх зүйл ангид салангид үзүүлэх бөгөөд үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын тооцооллыг хийдэг

Данснаас хасах Банк нь хөрөнгийн эргэн төлөлтийг зогсоосон үед санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн данснаас хасна. Хэрвээ данснаас хасах үнэ хуримтлагдсан алдагдлаас их тохиолдолд, зөрүүгээр нь алдагдлыг нэмэгдүүлж дараа нь дансны нийт үнийн дүнг бууруулна. Дараах үеийн эргэн төлөлтүүд нь зээлийн алдагдлын зардлыг бууруулна.

Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд түргэн хөрвөх боломжтой, үнэ цэнээ алдах эрсдэл багатай хэрэгсэл хамаарна. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд 3 сараас доош хугацаанд дуусгавар болох засгийн газрын хөрөнгө оруулалтууд болон Монголбанкны хөрөнгө оруулалтын үнэт цаасыг хамруулсан болно. 3 сараас дээш хугацаатай ашиглалтад нь хязгаарлалт хийсэн хөрөнгийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд оруулахгүй. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ

Банкнүүдэд байршуулсан мөнгөн хадгаламж

Мөнгөн хадгаламжийг Банк бусад банкнүүдэд арилжааны бус зорилгоор 3 сараас дээш хугацаатай мөнгө шилжүүлснээр зах зээлд бүртгэлгүй санхүүгийн үүсмэл бус хэрэглүүрүүд ба тодорхой эсвэл тодорхойлох боломжтой хугацаанд эргүүлэн төлөгдөх авлага үүсэх үед бүртгэдэг. Банкнүүдэд байршуулсан мөнгөн хадгаламжийг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Санхүүгийн хэрэглүүрүүдийг хооронд нь хаах. Хуулийн дагуу баталгаажуулах эрх нь байгаа тохиолдолд хүлээн зөвшөөрсөн цэвэр дүнгээр эсвэл эсхүл хөрөнгө, өр төлбөрийг нэгэн зэрэг цэвэр дүнгээр барагдуулах хүсэлтэй байгаа тохиолдолд санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүдийг хооронд нь хааж цэвэр дүнгээр санхүүгийн байдлын тайланд тусгаж бүртгэдэг.

Урьдчилж төлсөн төлбөрүүд.

Урьдчилж төлсөн төлбөр нь урьдчилж бэлэн мөнгө төлсөн боловч бодитоор гараагүй байгаа зардлуудыг хэлнэ. Урьдчилж төлсөн төлбөрүүд нь эхлээд хөрөнгө хэсэгт бүртгэгдэх ба төлсөн бэлэн мөнгөний дүнгээр хэмжигдэнэ. Үүний дараа үйл ажиллагаанд хэрэглэсэн буюу хугацаа нь дуусахад ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Үндсэн хөрөнгө. Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Тайлант хугацаа бүрийн эцэст үндсэн хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан элэгдэл, хорогдол болон үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр тусгадаг. Хөрөнгийг олж эзэмшихтэй холбоотой гарсан зардлыг өртөгт шингээнэ.

Хөрөнгийн өртгийг дор хүлээгдэж буй ашиглах хугацааны туршид шулуун шугамын аргаар элэгдүүлнэ:

– Барилга байгууламж	40 жил
– Тоног төхөөрөмж	3 жил
– Тавилга, эд хогшил	10 жил
– Тээврийн хэрэгсэл	10 жил

Үндсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх. Үндсэн хөрөнгийг зарж борлуулсан эсвэл ирээдүйд тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ашиглахад эдийн засгийн өгөөж хүртэхгүй гэж үзсэн тохиолдолд үл хүлээн зөвшөөрдөг. Үндсэн хөрөнгийг данснаас хассан эсвэл борлуулснаас үүссэн олз, гарзыг тухайн хөрөнгийн дансны үнэ ба борлуулалтын үнийн зөрүүгээр тооцож, ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдүүлэх аргыг тайлант хугацаа бүрийн эцэст хянаж үздэг ба шаардлагатай үед залруулж тохируулдаг.

Биет бус хөрөнгө. Банкны худалдан авсан ашиглах хугацаа нь тодорхой биет бус хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Тайлант хугацаа бүрийн эцэст анхны өртгөөс хуримтлагдсан хорогдуулалт ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр биет бус хөрөнгийг хэмждэг. Биет бус хөрөнгийн өртөгт худалдан авалтын үнэ, гаалийн татвар хураамж, бусад нөхөн олгогдохгүй татвараас худалдааны хөнгөлөлт, хямдралыг хассан цэвэр дүн ба биет бус хөрөнгийг зориулалтаар нь ашиглах бэлтгэлийг хангахтай холбоотой шууд гарах аливаа зардлаас бүрддэг.

Хэрвээ дараагийн зардлууд нь тухайн хөрөнгийн ирээдүйн өгөөжийг нэмэгдүүлэхээр бол анхны өртөг дээр нэмж капиталжуулна. Бусад бүх зардлуудыг гарсан үед нь ашиг алдагдлаар тусгана.

Ашиглах хугацаа нь тодорхой биет бус хөрөнгийг хорогдуулахдаа хөрөнгийн өртөг эсвэл өртгийг орлох дүнгээс үлдэх өртгийг хассан дүнгээр тооцно. Биет бус хөрөнгийг ашиглаж эхэлсэн өдрөөс эхлэн нийт хүлээгдэж буй ашиглах жилд үндэслэн шулуун шугамын аргаар хорогдуулах ба хорогдуулгын зардлыг тухайн тайлант хугацаан дахь ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Энэ нь уг хөрөнгийн ирээдүйд авчрах өгөөжийг зарцуулах төлөв байдлыг хамгийн дөхөмтэй байдлаар тусгана. Биет бус хөрөнгийг ашиглах жил дараах байдалтай байна:

– Программ хангамж болон лиценз	10 жил
---------------------------------	--------

Биет бус хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх. Биет бус хөрөнгийг зарж борлуулах эсвэл ирээдүйд орж ирэх эдийн засгийн өгөөж нь байхгүй болсон үед үл хүлээн зөвшөөрнө. Бүртгэлээс хасахтай холбоотой гарах олз, гарзыг тодорхойлохдоо бүртгэлээс хассан эсвэл борлуулснаас орж ирэх мөнгө болон хөрөнгийн дансны үнийн зөрүүгээр тооцох ба түүнийг тайлант үеийн тусдаа ашиг, алдагдалд тусгана.

Биет болон биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт. Удирдлага тайлант хугацаа бүрийн эцэст үл хөдлөх хөрөнгө, биет ба биет бус хөрөнгөнд үнэ цэнийн бууралт үүссэн шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлнэ. Хэрвээ үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрвэл, удирдлага тухайн хөрөнгийн нөхөн төлөгдөх боломжит хэмжээг тогтоох ба ингэхдээ тухайн хөрөнгийн бодит үнэ цэнээс худалдан борлуулахтай холбоотой зардлыг хассан дүн болон ашиглалтын үнэ цэнийн аль ихээр тооцдог. Дансны үнийг нөхөн төлөгдөх дүн хүртэл бууруулах ба үнэ цэнэ бууралтын зардлыг тухайн тайлант үеийн ашиг, алдагдалд тусгана. Хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ болон бодит үнэ цэнээс худалдах зардлыг хассан дүнг тодорхойлоход ашигласан тооцоололд өөрчлөлт орсон тохиолдолд, өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрсөн байсан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын зардлыг буцаана.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

Харилцагчдын харилцах данс. Харилцагчдын харилцах данс нь улсын, байгууллагын болон хувь хүмүүсийн үүсмэл бус өр төлбөр бөгөөд хорогдуулсан өртгөөр бүртгэгдэг. Эдгээр дансуудыг харилцагчийн төлбөр тооцоог хийхэд ашигладаг бөгөөд хүү боддоггүй.

Худалдах болон буцаан худалдан авах хэлцлүүд. Худалдах болон буцаан худалдан авах хэлцэл (“репо хэлцэл”) нь зээлдэгчийн эргэн төлөлтийг үр дүнтэйгээр хангах бөгөөд ийм хэлцлүүдийг баталгаа бүхий санхүүгийн гүйлгээ гэж үздэг. Репо хэлцлээр худалдсан үнэт цаасыг бүртгэлээс хасдаггүй. Үнэт цаасны тусдаа санхүүгийн байдлын тайлан дахь ангиллыг ерөнхийдөө өөрчилдөггүй боловч үнэт цаасаа шилжүүлж буй тал гэрээний дагуу эсвэл тогтсон хэвшлийн дагуу үнэт цаасыг зарах эсвэл барьцаанд өгөх эрхтэй тохиолдолд үнэт цаасыг буцаан худалдан авах авлага гэж ангилна. Холбогдох өглөгийг банкнуудаас байршуулсан хөрөнгө эсвэл зээлээр авсан санхүүжилт гэж тайлагнадаг. Худалдан авсан ба буцаан худалдах үнийн зөрүүг хүүгийн зардал гэж бүртгэх ба үр ашигт хүүгийн аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна.

Эсрэгээрээ, тодорхойлсон ирээдүйн өдөр дахин худалдахаар тохиролцон худалдан авсан үнэт цаасыг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөггүй. Ажил гүйлгээний эдийн засгийн мөн чанар нь Банкнаас олгосон зээлийн гүйлгээтэй ижил тул төлсөн төлбөрийг хуримтлагдсан хүүгийн хамтаар санхүүгийн байдлын тайланд "Урвуу буцаан худалдан авах хэлцэл"-ээр бүртгэнэ. Худалдан авсан ба дахин худалдах үнийн зөрүүг ‘хүүгийн орлого’ гэж бүртгэх ба үр ашигт хүүгийн аргыг ашиглан гэрээний хугацааны туршид хуримтлуулна.

Өрийн бичиг болон зээлээр авсан санхүүжилт. Банкнаас гаргасан өрийн бичиг, зээлээр авсан санхүүжилт зэрэг өрийн үнэт цааснуудыг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Зээлээр авсан эх үүсвэрийн хорогдуулсан өртгийг тооцохдоо үр ашигт хүүгийн аргыг ашиглан гүйлгээтэй холбоотой гарсан аливаа зардлуудыг тооцно. Хэрэв Банк өөрийн гаргасан өрийн бичгийг эргүүлэн худалдаж авбал эсвэл Зээлээр авсан санхүүжилтээрээ төлбөл тэдгээрийг санхүүгийн тайлангаас хасаж, төлсөн дүн болон өр төлбөрийн дансны үнэ хоёрын зөрүүгээр өрийн хэрэгслийг данснаас хасахад үүссэн олз эсвэл гарзаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Өмчлөх бусад хөрөнгө. Банкны журмын дагуу өмчлөх бусад хөрөнгүүдийг банкны дотоодын үйл ажиллагаанд ашиглах болон борлуулах хоёрын аль нь үр ашигтай болохыг сонгодог. Дотоодын үйл ажиллагаанд хэрэгцээтэй гэж үзсэн хөрөнгүүдийг тухайн өмчилсөн хөрөнгийн дансны үнэ болон өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний аль багаар холбоотой дансны ангилал руу шилжүүлнэ. Борлуулахаар шийдвэрлэсэн хөрөнгүүдийг “Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө” дансанд, тус хөрөнгийн бодит үнэ цэнээр (хэрэв санхүүгийн хөрөнгө бол) эсвэл санхүүгийн бус хөрөнгүүдийг бодит үнэ цэнээс борлуулахад шаардагдах зардлыг хассан дүнгээр өмчлөлийн өдрөөр шилжүүлнэ. 12 сараас дээш хугацаанд борлуулагдахаар хүлээгдэж буй хөрөнгүүд нь “Өмчлөх бусад хөрөнгө” дансанд, өртөг болон бодит үнэ цэнээс борлуулахад гарах зардлыг хассан дүнгээр бүртгэгдэнэ.

Хувь нийлүүлсэн хөрөнгө. Хувь нийлүүлсэн хөрөнгө нь банкны өмчлөгчөөс мөнгөн хөрөнгө оруулах, хуримтлагдсан ашгийг капиталжуулах эсвэл өмчлөгчийн бусад хэлбэрээр оруулсан хөрөнгө оруулалтыг илэрхийлдэг.

Орлогын албан татвар. Орлогын албан татварыг тайлант үеийн эцэст батлагдсан хууль тогтоомжийн дагуу тусдаа санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрнө. Орлогын албан татварын зардал нь тухайн тайлант үеийн болон хойшлогдсон татвараас бүрдэх бөгөөд тухайн буюу өөр тайлант хугацаанд бусад дэлгэрэнгүй орлогод эсвэл өмчид шууд бүртгэгдсэнээс бусад тохиолдолд тухайн тайлант үеийн орлого, зарлагад хүлээн зөвшөөрнө. Тайлант хугацааны татвар нь тухайн болон өмнөх хугацаанд үүссэн татвар ногдуулах ашиг, алдагдалтай холбоотой татварын байгууллагад төлөх эсвэл түүнээс нөхөн авах дүн болно. Санхүүгийн тайланг холбогдох татварын албанд тушаахаас өмнө баталж амжаагүй тохиолдолд татвар ногдуулах ашиг, алдагдлыг урьдчилан тооцно. Орлогын албан татвараас бусад татваруудыг үйл ажиллагааны зардалд бүртгэдэг.

Хойшлогдсон орлогын албан татвар. Хойшлогдсон орлогын татварыг Балансын өглөгийн аргыг ашиглан дараагийн тайлант үед шилжүүлсэн татварын алдагдал, хөрөнгө өр төлбөрийн татварын суурь болон санхүүгийн тайлангийн зорилгоорх бүртгэлийн суурийн зөрүүнд үндэслэн хүлээн зөвшөөрнө. Бизнесийн нэгдлээс бусад тохиолдолд, хэрэв ажил гүйлгээг анхны удаа хүлээн зөвшөөрөх үед татвар эсвэл бүртгэлийн ашиг алдагдлын алинд ч нөлөөлөхгүй байвал хөрөнгө, өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөх үед хойшлогдсон татвар үүсэхгүй. Хойшлогдсон татварын үлдэгдлийг ирээдүйд түр зөрүүг буцаах эсвэл шилжүүлсэн татварын алдагдлыг ашиглах үед хэрэглэгдэх балансын өдрөөр хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувиар тооцоолж гаргана.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Хойшлогдсон орлогын албан татвар (үргэлжлэл). Хасагдах түр зөрүү болон ирээдүйд шилжүүлсэн татварын алдагдлаас үүссэн хойшлогдсон татварын хөрөнгийг хасагдах түр зөрүүг ашиглах хангалттай хэмжээний ашиг олох магадлал өндөр байгаа тохиолдолд хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр хянаж үздэг ба энэхүү хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн ашиглахад хангалттай хэмжээний татвар ногдох орлого орж ирэх магадлал буурах үед уг бүртгэлийн дүнг бууруулна.

Борлуулахад бэлэн хөрөнгийн бодит үнэ цэнийн дахин хэмжилттэй холбоотой бусад дэлгэрэнгүй орлогод тусгагдсан татвараас бусад хойшлогдсон татвар ба орлогын албан татвар нь орлогын тайланд орлогын албан татварын буцаан авалт эсвэл зардлаар хүлээн зөвшөөрөгдөнө. Энэ нь дараагийн тайлант үед бусад дэлгэрэнгүй орлогоос орлогын тайлан руу холбогдох хойшлуулсан ашиг алдагдлын хамт дахин ангилна. Мөн Банк нь өөрийн хөрөнгө гэж ангилсан санхүүгийн хэрэглүүрүүдтэй холбоотой зардал, төлбөрийн татварын үр дагаврыг өөрийн хөрөнгөөр шууд хүлээн зөвшөөрнө.

Нөөцийн сан, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө

Нөөцийн сан. Банк өнгөрсөнд болсон үйл явдлаас үүссэн хуулийн хариуцлага хүлээх үед Банк эдийн засгийн хувьд үр өгөөжтэй байдлаар шаардлагыг биелүүлэх бөгөөд энэ үед нөөцийн санг хүлээн зөвшөөрч дүнг бодитоор тооцоолно. Хүлээн зөвшөөрсөн нөөцийн сангийн хэмжээ, дүнг тухайн үүрэгтэй холбоотой бүх эрсдэл ба тодорхойгүй байдлыг харгалзаж бий болсон үүргийн гүйцэтгэлийг тайлант хугацааны эцэст хангуулахаар төсөөлж тооцоолно. Нөөцийн санг хэмжихдээ одоо бий болсон үүргийг хангуулахаар төсөөлсөн бэлэн мөнгөний урсгалыг ашиглах ба түүний бүртгэлийн үнэ нь энэхүү бэлэн мөнгөний урсгалын өнөөгийн үнэ байна.

Нөөцийн санг барагдуулахад шаардлагатай эдийн засгийн өгөөжийг бүгдийг нь эсвэл заримыг нь гуравдагч тал нөхөн төлөх магадлалтай ба хэрэв нөхөн төлөх нь тодорхой болсон бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг найдвартай хэмжих боломжтой үед уг авлагыг хөрөнгө хэмээн хүлээн зөвшөөрнө.

Нөөцийн санг тайлант хугацаа бүрийн эцэст хянах ба ингэхдээ хамгийн сайн төсөөллийг тусгаж залруулдаг. Эдийн засгийн өгөөжийг шилжүүлж өр төлбөрийг барагдуулах шаардлагагүй болсон үед нөөцийн санг буцаана.

Болзошгүй өр төлбөр ба хөрөнгө. Аж ахуйн нэгжийн бүрэн хяналтаас гадуурх нэг болон түүнээс дээш ирээдүйн үйл явдал тохиолдох, эс тохиолдохоос хамаарч үүсэх эсэх нь тодорхойлогддог тул болзошгүй өр ба болзошгүй хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэхгүй. Эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн урсгалыг гадагшлуулах магадлал өндөр бол болзошгүй өр төлбөрийн мэдээллийг толилуулна. Эдийн засгийн өгөөж орж ирэх өндөр магадлалтай үед болзошгүй хөрөнгийн талаарх мэдээллийг толилуулна.

Эрсдэлтэй холбогдсон хүлээх үүрэг. Банк нь хуулиар аккредитив болон санхүүгийн батлан даалт гаргах зэргээр эрсдэлтэй холбогдсон үүрэг хүлээсэн хэлцэл хийж болно. Санхүүгийн батлан даалт нь харилцагч гуравдагч талд төлөх төлбөрийн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Банк харилцагчийн өмнөөс төлбөр төлөхөөр эргэж буцалтгүй баталгаа гаргах бөгөөд зээлтэй нэгэн адил эрсдэлийг бий болгодог.

Санхүүгийн батлан даалт болон зээл олгохтой холбоотой үүргийг анх бүртгэлд тусгахдаа бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрөх ба энэ нь хүлээн авсан үйлчилгээний хөлсөөр нотлогдоно. Энэхүү дүн нь зээл олгохтой холбоотой үүрэгт хугацааны турш шулуун шугамын аргаар хорогдуулах ба энэ нь Банк тусгайлан зээл олгох үүрэг хүлээсэн болон уг зээлийн гэрээг богино хугацааны дараа худалдах зорилгогүй тохиолдолд шулуун шугамын аргаар хорогдуулахгүй бөгөөд энэ тохиолдолд ийм төрлийн зээл гаргах үүргийн төлөө авсан төлбөрийг хойшлуулж, зээлийн анх хүлээн зөвшөөрсөн дүнд оруулж бүртгэдэг.

Тайлант хугацаа бүрийн эцэст зээлийн үүргийг (i) анх хүлээн зөвшөөрсөн дүнгийн хорогдуулаагүй үлдэгдэл дүн (ii) тайлант хугацаа бүрийн эцсийн байдлаарх тухайн үүргийг барагдуулахад шаардагдах хөрөнгийн төсөөлж тооцсон дүнгийн аль ихээр хэмжинэ. Хэрэгжиж буй зээлийн үүргийн үйлчилгээний төлбөрийг зохих хугацаанд хүлээн авч байгаа бол холбогдох хугацаанд хуваарилан орлогоор хүлээн зөвшөөрч үүрэг хүлээсэн нийт хугацааны турш бүртгэнэ.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)**Нөөцийн сан, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө (үргэлжлэл)*****Ажилчдын цалин хөлстэй холбоотой зардал*****(i) Богино хугацааны тэтгэвэр, тэтгэмж**

Тайлант хугацаанд ажилтнуудад төлсөн цалин, цалин хөлстэй холбоотой бусад зардал нь Банкны ажилчидтай холбогдон гарах үйлчилгээний зардал юм. Богино хугацаанд хамаарагдах хуримтлагдсан нөхөн олговор нь жил бүрийн ээлжийн амралтын олговор бөгөөд ирээдүйд авах нөхөн олговрын хэмжээг нэмэгдүүлж байдаг ажилчдын үйлчилгээгээр тайлбарлана. Ажилтнуудын богино хугацаат цалин хөлс, тэтгэмж, урамшууллын өр төлбөрийг тухай бүрд нь бүртгэх бөгөөд холбогдох үйлчилгээ үзүүлсний дараа зарлагадна.

(ii) Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд хуульд заасны дагуу Засгийн газрын тэтгэвэр, тэтгэмжийн тогтолцоо болох Нийгмийн даатгалын санд шимтгэл төлөх ёстой. Энэхүү шимтгэл нь тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрөгдөнө. Банк нь тогтоосон тэтгэвэр, тэтгэмжийн шимтгэлийн төлөвлөгөөнд мөн шимтгэл төлдөг. Төлсөн шимтгэлийг “тэтгэврийн сангийн зардал”- д ажилчдын Банкинд үзүүлсэн үйлчилгээний харьцуулалтаар тооцон зардалд бүртгэнэ.

(iii) Урт хугацаат тэтгэвэр, тэтгэмж

Банк нь өөрсдийн ажилтнууддаа хямд өртөгтэй цалингийн болон орон сууцны зээл олгох зорилгоор гуравдагч банкинд эх үүсвэр байршуулсан. Энэхүү хөтөлбөрийн өртгийг анх урьдчилж төлсөн зардлаар тусгасан бөгөөд зээлийн хугацааны турш тусдаа ашиг, алдагдал болон бусад орлогын дэлгэрэнгүй тайланд тусган зарлагадна.

Орлого болон зардлыг хүлээн зөвшөөрөх. Бүх өрийн хэрэгслийн хувьд хүүгийн орлого ба хүүгийн зардлыг бодит хүүгийн хувийг ашиглан тооцож аккрузал сууриар бүртгэнэ. Энэ аргачлал нь хүүгийн орлого ба зарлагын бүрэлдэхүүн болох гэрээний талуудын хүлээн авсан ба төлсөн шимтгэл, хураамжийг хамруулан тооцох ба энэ шимтгэл хураамж нь бодит хүү, гүйлгээний зардал ба бусад нэмэгдэл, хямдруулалтын салшгүй хэсэг байна.

Санхүүгийн хөрөнгийг бий болгох эсвэл олж авах эсвэл санхүүгийн өр төлбөр гаргахтай холбоотойгоор Банкны хүлээн авсан болон төлсөн шимтгэл зэрэг шимтгэл хураамжууд нь бодит хүүгийн хувийн салшгүй хэсэг байна. Жишээлбэл: зээлжих чадварыг үнэлэх, баталгаа, барьцааг үнэлэх, бүртгэх, санхүүгийн хэрэгслийн нөхцөлийг хэлэлцэн тохирох болон хэлцлийн бичиг баримтыг боловсруулахтай холбоотой бүх шимтгэл хураамжууд. Хэрэв Банк тусгайлан зээл олгох үүрэг хүлээсэн бөгөөд уг зээлийн гэрээг богино хугацааны дараа худалдах зорилгогүй тохиолдолд Банкны зах зээлийн хүүгээр олгосон зээлээс хүлээн авсан шимтгэл, хувь нь бодит хүүгийн хувийн салшгүй хэсэг болно. Банк зээлтэй холбоотой үүргийг ашиг, алдагдлаар дамжуулах бодит үнэ бүхий санхүүгийн өр төлбөр хэмээн үзэхгүй.

Зээл болон өрийн бусад хэрэгслүүд эргэн төлөгдөх нь эргэлзээтэй болоход тэдгээрээс хүлээгдэж буй орох мөнгөн урсгалыг өнөөгийн үнэ цэнэ хүртэл нь бууруулж, харин хүүгийн орлогыг үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжихэд ашигласан хөрөнгийн бодит хүүгийн хувиар тооцсон хямдруулалтын өнөөгийн үнэ цэнээр салган бүртгэнэ.

Тодорхой хугацааны туршид үйлчилгээг үзүүлж олох орлогыг тэр хугацааны туршид нь хуримтлуулна. Эдгээр хураамжид шимтгэлийн орлого, хөрөнгийн удирдлага, хамгаалалтын болон бусад удирдлага, зөвлөгөөний хураамжууд орно.

Гуравдагч талтай гүйлгээний талаар хэлэлцээр хийх эсхүл гүйлгээнд оролцохтой холбоотойгоор үүссэн хураамжууд (хувьцаа эсхүл бусад үнэт цаасыг худалдан авах, бизнес худалдан авах, худалдах зохицуулалт гэх мэт)-ыг холбогдох гүйлгээ дууссан үед хүлээн зөвшөөрнө. Тодорхой нэг гүйцэтгэлтэй уягдсан хураамж эсхүл хураамжийн бүрэлдэхүүн хэсгийг холбогдох шалгуурууд хангагдсаны дараа хүлээн зөвшөөрнө.

Гадаад валютын ажил гүйлгээ. Банкны ажил гүйлгээ бүртгэдэг валют нь үйл ажиллагаагаа явуулдаг эдийн засгийн орчны анхдагч валют бөгөөд Банкны тайлагналын болон бүртгэлийн валют нь төгрөгөөр илэрхийлэгддэг.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)***Гадаад валютын ажил гүйлгээ (үргэлжлэл)***

Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ хийгдсэн өдрийн холбогдох валютын ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлж, ханшийн тэгшитгэлийг тооцно. Тайлант хугацаа бүрийн эцэст гадаад валютаар илэрхийлсэн хөрөнгө ба өр төлбөрийг тухайн тайлант хугацааны эцэс дэх холбогдох валютын ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлж ханшийн тэгшитгэлийг тооцно. Ханшийн тэгшитгэлийн хөрвүүлгээс үүссэн олз, гарзыг тухайн тайлант үеийн ашиг, алдагдалд тусгана. Түүхэн өртгөөр хэмжигддэг гадаад валютаарх мөнгөн бус хөрөнгө ба өр төлбөрийг хөрвүүлж ханшийн тэгшитгэл хийхгүй. Мөнгөн хөрөнгө ба өр төлбөрийн хөрвүүлэлтийн ханшийн зөрүүг ашиг, алдагдлаар тухайн тайлант жилд хүлээн зөвшөөрнө.

Үндсэн үүрэг гүйцэтгэгч ба агентын гэрээ. Банк нь тусгайлсан зээлдэгчдэд тусгай зээлийн багцыг олгох зорилгоор санхүүжилт авдаг. Энэ төрлийн хэлцэлд, санхүүжилт олгогч талын хувьд Банк нь үндсэн үүрэг гүйцэтгэгч, эсвэл агентын үүрэг гүйцэтгэх эсэхийг дараах шаардлагуудыг хангасан эсэхээр тодорхойлно, а) Банк нь олгосон хөрөнгийн хэмжээтэй ижил хэмжээгээр эргүүлэн цуглуулж чадаагүй бол боломжит хүлээн авагчид төлөх үүрэг хүлээгээгүй, б) дамжуулах гэрээний нөхцөлөөр боломжит хүлээн авагчид төлөх үүргийн дагуу хөрөнгийг худалдах болон барьцаалахыг Банкинд хориглосон, в) хүлээн авагчийн өмнөөс цуглуулсан мөнгөн урсгалыг Банк удаан хугацаагаар хойшлуулалгүй шилжүүлэх үүрэгтэй. Хэрэв дээрх шалгуурууд хангагдаж чадахгүй байвал, Банк үндсэн үүрэг гүйцэтгэгч ба тусдаа санхүүгийн байдлын тайланд хөрөнгө ба өр төлбөрөөр тусгагдах олгох санхүүжилт болон хүлээн авах санхүүжилтийг, тусдаа ашиг, алдагдал болон бусад орлогын дэлгэрэнгүй тайланд тусгагдах холбогдох хүүгийн орлого болон хүүгийн зарлагын хамтаар хүлээн зөвшөөрнө. Хэрэв дээрх шалгуурууд хангагдаж байвал, Банк нь агентын үүргийг гүйцэтгэх ба гэрээний төлбөрийг тусдаа ашиг, алдагдал болон бусад орлогын дэлгэрэнгүй тайланд бүртгэнэ. Олгосон санхүүжилт болон хүлээн авсан санхүүжилт нь хөрөнгө, өр төлбөрөөр тодорхойлогдохгүй бөгөөд тусдаа санхүүгийн байдлын тайланд тусгагдахгүй.

Охин компани. Охин компани гэдэг нь Банкны хяналтад байдаг аж ахуйн нэгжийг хэлнэ. Банк нь охин компанийн үйл ажиллагаанаас өгөөж хүртэх болон тухайн үйл ажиллагааны өгөөжид нөлөөлөх эрх мэдэлтэй үед охин компанийг хянадаг гэж үзнэ. Тусдаа санхүүгийн тайланд охин компанид оруулсан хөрөнгө оруулалтыг өртгөөр нь бүртгэх бөгөөд охин компаниас хүртэх ногдол ашгийг хүлээн авахаар хүлээгдэж буй үед орлогоор хүлээн зөвшөөрнө.

Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ. Банк, түүний холбоотой этгээдийн хооронд хөрөнгө, ажил үйлчилгээ эсвэл үүргийг нөхөн төлбөртэй, төлбөргүй нөхцөлөөр шилжүүлэг хийхийг холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ гэнэ.

Банктай дараах байдлаар холбогдсон хувь хүн эсвэл тухайн хувь хүний ойрын төрөл садан:

- Банканд дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон;
- Банканд томоохон нөлөөлөлтэй эсвэл
- Банкны эсвэл Банкны толгой компанийн гол удирдах албан тушаалтнуудын нэг.

Дараах нөхцөлүүдийн аль нэг нь биелсэн тохиолдолд аж ахуй нэгж нь Банканд хамааралтай болно. Үүнд:

- Аж ахуй нэгж болон Банк нь нэг ижил группийн гишүүд байх (толгой компани, охин компани болон нөгөө охин компани тус бүр нь бусадтайгаа холбоотой).
- Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат компани эсвэл хамтын хэлэлцээрт компани эсвэл нөгөө аж ахуйн нэгж нь гишүүн болох Банкны хараат компани эсвэл хамтарсан хэлэлцээрт компани.
- Аль аль аж ахуйн нэгж нь нэг ижил гуравдагч этгээдийн хамтарсан хэлэлцээрт компаниуд.
- Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч аж ахуйн нэгжийн хамтарсан хэлэлцээрт компани бөгөөд нөгөө этгээд нь гуравдагч аж ахуйн нэгжийн хараат компани.
- Аж ахуйн нэгж нь Банкны эсвэл Банктай холбоотой аж ахуйн нэгжийн ажиллагсдыг урамшуулах зорилгоор ажил эрхлэлтийн дараах тэтгэмж олгодог. Хэрвээ Банк нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бол дэмжлэг хүртэж буй ажиллагсад нь мөн Банктай холбоотой тал болно.
- Аж ахуйн нэгжийг Банканд дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон хувь хүн дангаараа эсвэл хамтран хяналт тогтоодог.
- Банканд дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон хувь хүн нь аж ахуйн нэгжид томоохон нөлөөлөлтэй эсвэл уг аж ахуйн нэгжийн (эсвэл аж ахуйн нэгжийн толгой компанийн) гол удирдах албан тушаалтнуудын нэг.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)*Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ (үргэлжлэл)*

Банкны үйл ажиллагааны чиглэлээс хамаарахаас гадна бодлого хэрэгжүүлэгч банкны хувьд олон зээл болон ажил гүйлгээнүүд нь холбоотой талуудтай хийгдсэн байдаг. Банк нь НББОУС 24-ийн 24.25-д заасны дагуу Засгийн газартай холбоотой этгээдтэй хийсэн материаллаг бус ажил гүйлгээг толилуулах үүргээс чөлөөлөх заалтыг хэрэгжүүлсэн.

Санхүүгийн байдлын тайланг хөрвөх чадвараар эрэмбэлэн тайлагнах. Банк нь тодорхой заасан үйл ажиллагааны давтамжгүй бөгөөд эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө, өр төлбөрийг тусдаа санхүүгийн байдлын тайланд тусад нь ангилж тайлагнадаггүй. Харин хөрөнгө, өр төлбөр нь хөрвөх чадвараар эрэмбэлэгдэн тайлагнадаг. Тодруулга 29-д хөрвөх чадварын удирдлагын зорилгоор толилуулсан санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн шинжилгээний дүнгээр санхүүгийн хөрөнгө, өр төлбөр нь тайлангийн хугацааны дараа ойролцоогоор 12 сарын өмнө болон хойно барагдаж эсвэл төлөгдөж дуусна гэсэн хүлээлттэй байдаг. Санхүүгийн бус хөрөнгө, өр төлбөрийн хувьд удирдлага эдгээр хөрөнгө, өр төлбөртэй холбоотой тодруулгуудад тусдаа санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд хүргэх хангалттай мэдээлэл агуулагдсан гэж үзэж байна.

2.5 СТОУС-ын анх удаа хэрэгжүүлэлт

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн энэхүү санхүүгийн тайлан нь Банкны СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн анхны тайлан юм. Банк нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангуудыг СТОУС 9 "Санхүүгийн хэрэглүүр"-ийн хэрэгжилтээс бусдаар НББОУСЗ-өөс баталж гаргасан СТОУС-ын дагуу боловсруулсан Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу бэлтгэж толилуулсан ба санхүүгийн хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтын бүртгэлдээ Монголбанкаас баталсан заавар, журмыг мөрдөж байсан.

Иймд Банк СТОУС 1 Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартыг Анх Удаа Хэрэгжүүлэлт-ийг хэрэгжүүлж 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлан болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх харьцуулсан үзүүлэлтүүдийг нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудад тодорхойлсноор СТОУС-ын дагуу бэлтгэв. Санхүүгийн тайланг бэлтгэхдээ СТОУС-д анх шилжсэн өдөр болох 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр Банкны санхүүгийн тайлангийн эхлэлтийн балансыг бэлтгэв. Энэхүү тодруулгад тайлан бэлтгэх үндэслэлийн дагуу өмнөх жилүүдэд бэлтгэсэн Банкны 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлангуудыг дахин толилуулахад хийсэн гол залруулгуудыг тайлбарлав.

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД - 2024 ОНЫ 12 САРЫН 31

2.5 СТОУС-ын анх удаа хэрэгжүүлэлт (үргэлжлэл)

Санхүүгийн байдлын тайлангийн тохируулга - 2023 оны 1 сарын 1-нээр (СТОУС-т шилжсэн өдөр):

	Тод.	СТОУС-д Тулгуурлан Монголбанк-наас баталсан заавар, журмын дагуу мян.төг	Дахин ангилал мян.төг	Дахин хэмжилт мян.төг	СТОУС-ын Дагуу мян.төг
ХӨРӨНГӨ					
Бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		884,865,829			884,865,829
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	(а)	14,635,964		(14,635,964)	–
Бодит үнэ цэнээр хэмжсэн борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт		305,576,369	(305,576,369)		–
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өрийн хэрэглүүр рүү	(б)		(243,135,961)		
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өмчийн хэрэглүүр рүү	(в)		(62,440,408)		
Санхүүгийн хөрөнгө оруулалт – дуусгавар хугацаа хүртэл эзэмших		568,788,930	(568,788,930)		–
Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэглүүр рүү	(г)		(568,788,930)		
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд бүртгэх санхүүгийн хөрөнгө		15,939,053	(15,939,053)		–
Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэглүүр рүү	(г)		(15,939,053)		
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өрийн хэрэглүүр рүү			243,135,961	(2,054,837)	241,081,124
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтаас	(б)		243,135,961	(2,054,837)	
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өрийн хэрэглүүр рүү			62,440,408		62,440,408
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтаас	(в)		62,440,408		
Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэглүүр			588,037,514	(15,038,698)	572,998,816
Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалтаас	(г)		588,037,514	(15,038,698)	
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр		21,753,965			21,753,965
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	(д)	1,759,178,799		(311,611,233)	1,447,567,566
Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт		114,961,047			114,961,047
Бусад татварын авлага	(е)	7,242,597	441,937	(7,684,534)	–
Бусад хөрөнгө	(е)	3,932,680	75,105,401	8,754,082	87,792,163
Үндсэн хөрөнгө		23,724,723			23,724,723
Биет бус хөрөнгө		306,228			306,228
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	(е)	257,073,386	(82,267,682)		174,805,704
Хойшлогдсон татварын хөрөнгө		47,414,084			47,414,084
НИЙТ ХӨРӨНГӨ		4,025,393,654	(3,410,813)	(342,271,184)	3,679,711,657
ӨР ТӨЛБӨР					
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр		5,681,789			5,681,789
Харилцагчдын харилцах		35,390,012			35,390,012
Гэрээний өр төлбөр	(ё)	3,852,750	(3,852,750)		–
Бусад өр төлбөр	(ё)	6,824,479	441,937	3,774,520	11,040,936
Орлогын албан татварын өглөг		8,063,524			8,063,524
Бусад татварын өглөг		17,980			17,980
Бусад банкуудад өгөх өглөг		29,583,716			29,583,716
Өрийн бичиг		2,572,205,220			2,572,205,220
Зээлээр авсан санхүүжилт		582,540,605			582,540,605
НИЙТ ӨР ТӨЛБӨР		3,244,160,075	(3,410,813)	3,774,520	3,244,523,782
БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД НОГДОХ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ					
Хувь нийлүүлсэн хөрөнгө		1,216,300,341			1,216,300,341
Бусад нөөц	(ж)	23,816,452		(2,054,837)	21,761,615
Хуримтлагдсан алдагдал	(ж)	(458,883,214)		(343,990,867)	(802,874,081)
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ		781,233,579		(346,045,704)	435,187,875
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		4,025,393,654	(3,410,813)	(342,271,184)	3,679,711,657

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД - 2024 ОНЫ 12 САРЫН 31

2.5 СТОУС-ын анх удаа хэрэгжүүлэлт (үргэлжлэл)

Санхүүгийн байдлын тайлангийн тохируулга - 2023 оны 12 сарын 31-нээр (СТОУС-т шилжсэн өдөр):

Тод	СТОУС-д тулгуурлан Монголбанк-наас баталсан заавар, журмын дагуу мян.төг	Дахин ангилал мян.төг	Дахин хэмжилт мян.төг	СТОУС-ын дагуу мян.төг
ХӨРӨНГӨ				
Бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	142,882,488			142,882,488
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	(a) 2,280,730		(2,280,730)	–
Санхүүгийн хөрөнгө оруулалт-борлуулахад бэлэн	205,287,555	(205,287,555)		–
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өрийн хэрэглүүр рүү	(b)	(137,484,545)		
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өмчийн хэрэглүүр рүү	(в)	(67,803,010)		
Санхүүгийн хөрөнгө оруулалт – дуусгавар хугацаа хүртэл	180,962,377	(180,962,377)		–
Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэглүүр рүү	(г)	(180,962,377)		
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд бүртгэх санхүүгийн хөрөнгөрүү	11,807,750	(11,807,750)		–
Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэглүүр рүү	(г)	(11,807,750)		
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өрийн хэрэглүүр рүү		137,484,545	(844,864)	136,639,681
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтаас	(б)	137,484,545	(844,864)	
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өрийн хэрэглүүр рүү		67,803,010		67,803,010
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтаас	(в)	67,803,010		
Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэглүүр		192,770,127	(5,019,248)	187,750,879
Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалтаас	(г)	192,770,127	(5,019,248)	
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр				
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	(д)	1,144,096,559	70,177,181	1,214,273,740
Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт		110,000,000		110,000,000
Бусад татварын авлага	(e)	(1,843,700)	691,071	–
Орлогын албан татварын авлага	(ё)	(8,954)	11,465	2,511
Бусад хөрөнгө	(e)	9,724,424	1,422,618	82,820,806
Үндсэн хөрөнгө		22,879,917		22,879,917
Биет бус хөрөнгө		245,016		245,016
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	(e)	241,529,319	(75,502,096)	166,027,223
Хойшлогдсон татварын хөрөнгө	(ё)	46,073,433	(46,073,433)	–
НИЙТ ХӨРӨНГӨ		2,115,916,914	(3,137,261)	2,131,325,271
ӨР ТӨЛБӨР				
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр		4,227,824		4,227,824
Харилцагчдын харилцах		37,915,273		37,915,273
Хугацаат хадгаламж		34,123,720		34,123,720
Гэрээний өр төлбөр	(e)	3,828,332	(3,828,332)	–
Бусад өр төлбөр	(e)	6,959,397	3,895,985	10,855,382
Бусад татварын өглөг		92,184	691,071	783,255
Хойшлогдсон татварын өр төлбөр	(ё)		11,537,956	11,537,956
Бусад банкуудад өгөх өглөг		225,210,272		225,210,272
Өрийн бичиг		687,477,828		687,477,828
Зээлээр авсан санхүүжилт		707,401,712		707,401,712
НИЙТ LIABILITIES		1,707,236,542	(3,137,261)	1,719,533,222
БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД НОГДОХ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ				
Хувь нийлүүлсэн хөрөнгө		1,216,300,341		1,216,300,341
Бусад нөөц	(ж)	38,817,504	(844,864)	37,972,640
Хуримтлагдсан алдагдал	(ж)	(846,437,473)	3,956,541	(842,480,932)
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ		408,680,372	3,111,677	411,792,049
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		2,115,916,914	(3,137,261)	2,131,325,271

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД - 2024 ОНЫ 12 САРЫН 31

2.5 СТОУС-ын анх удаа хэрэгжүүлэлт (үргэлжлэл)

Ашиг, алдагдал бас бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн тохируулга - 2023 оны 12 сарын 31-нээр (СТОУС-т шилжсэн өдөр):

Тод.	СТОУС-д тулгуурлан Монголбанк-наас баталсан заавар, журмын дагуу мян.төг	Дахин ангилал мян.төг	Дахин хэмжилт мян.төг	СТОУС-ын дагуу мян.төг
Хүүгийн орлого	(е)	173,672,550	7,000,152	180,672,702
Хүүгийн зардал		(215,093,546)		(215,093,546)
Хүүгийн цэвэр зардал		(41,420,996)	7,000,152	(34,420,844)
Үнэ цэнийн бууралтын сангийн буцаалт/(зардал)	(ж)	73,474,870	(11,061,605)	59,209,225
Үнэ цэнийн бууралтын сангийн дараах хүүгийн цэвэр орлого		32,053,874	(11,061,605)	24,788,381
Шимтгэл, хураамжийн орлого		55,090		55,090
Шимтгэл, хураамжийн зардал		(136,294)		(136,294)
Бусад орлого	(е)	5,371,340	(4,870,887)	500,453
Цэвэр арилжааны олз/(гарз)		16,991,078	(16,991,078)	–
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн цэвэр (гарз)/олз		(14,121,067)		(14,121,067)
Хугацаат хадгаламж, өмчлөх бусад хөрөнгө болон бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал	(ж)	(130,779)	130,779	–
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдалын тайланд бүртгэгдэх санхүүгийн хэрэглүүрийн цэвэр гарз	(ж)	(10,930,826)	10,930,826	–
Гадаад валютын ханшийн цэвэр гарз	(д)	(75,346,162)	16,991,078	19,431,456
Удирдлагын болон бусад үйл ажиллагааны зардал		(12,513,481)		(12,513,481)
Татварын өмнөх ашиг/(алдагдал)		(58,707,227)	76,711,765	18,004,538
Орлогын албан татварын зардал		(11,465)	(57,599,924)	(57,611,389)
Тайлант жилийн алдагдал		(58,718,692)	19,111,841	(39,606,851)
Бусад дэлгэрэнгүй орлого/(зардал) (татварын дараах):				
<i>Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдах бусад дэлгэрэнгүй орлого – (татварын дараах)</i>				
Ашиг, алдагдлын тайлан руу шилжсэн цэвэр дүн	(ж)	24,607,464	(2,811,978)	21,795,486
<i>Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдахгүй бусад дэлгэрэнгүй орлого – (татварын дараах):</i>				
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өмчийн хэрэглүүрийн дахин үнэлгээний өөрчлөлт	(ж)		4,021,951	4,021,951
Ашиг, алдагдлын тайлан руу шилжсэн цэвэр дүн		(9,606,412)		(9,606,412)
Бусад дэлгэрэнгүй орлого		15,001,052	1,209,973	16,211,025
Тайлант жилийн татварын дараах нийт дэлгэрэнгүй алдагдал		(43,717,640)	20,321,814	(23,395,826)

2.5 СТОУС-ын анх удаа хэрэгжүүлэлт (үргэлжлэл)

2023 оны 1 сарын 1 болон 2023 оны 12 сарын 31-нээрх Санхүүгийн байдлын тайлан, 2023 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн тохируулгуудын тайлбар:

- (а) Бусад банкуудад байршуулсан хөрөнгөд бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан төгрөгийн болон бусад валютын харилцах дансууд багтдаг. Эдгээр хөрөнгийн ЗҮЦХА-г дансны үлдэгдлээс тооцсон.
- (б) Бодит үнэ цэн нь СТОУС- 9-ийн дагуу бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгддэг өрийн хэрэгслүүдэд өмнө нь борлуулахад бэлэн гэж ангилагдсан Эрдэнэс Тавантолгой ТӨХК-ийн компанийн бонд орно. Банкны хийсэн үнэлгээнд үндэслэн дээрх хэрэгслүүдийг гэрээний дагуу мөнгөн урсгал цуглуулах болон санхүүгийн хөрөнгийг борлуулах бизнесийн загварын хүрээнд зохицуулагддаг гэж дүгнэсэн тул СТОУС 9-ийн дагуу бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх өрийн хэрэглүүр гэж ангилагдсан.
- (в) Банк нь МИК Холдинг ХК-д оруулсан хөрөнгө оруулалтыг СТОУС 9-н дагуу БҮЦӨАА-р бүртгэх өмчийн хэрэглүүр болгон ангилсан. 2023 оны 1 сарын 1-нээр, энэхүү бондыг Банк нь гэрээнд заасан мөнгөн төлбөрийг цуглуулан авах зорилгоор эзэмшдэг бөгөөд өмнөх бүртгэлээр буюу борлуулахад бэлэн, БҮЦӨБДО-р бүртгэгдэх өрийн хэрэглүүр рүү шилжүүлсэн.
- (г) Хорогдуулсан өртгөөр бүртгэх өрийн хэрэглүүр өмнө нь дуусгавар хугацаа хүртэл эзэмших ангилалд байсан хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй “Дархан Арьс Ширний Цогцолбор” ХХК болон “Төрийн Орон Сууцын Корпораци” ТӨХК-ийн бонд орсон. Энэхүү бондыг Банк нь гэрээнд заасан мөнгөн төлбөрийг цуглуулан авах зорилгоор эзэмшдэг бөгөөд гэрээний нөхцөл нь тодорхой заасан өдрүүдэд үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрөөс бүрдсэн мөнгөн гүйлгээг бий болгодог.
- (д) Харилцагчдад олгосон зээл нь хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн.
- (е) Өмчлөх бусад хөрөнгөд СТОУС-ын дагуу тохируулга хийж, хүлээн авсан төлбөрийг бусад авлагад бүртгэж, хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгө гэж ангилсан.
- (ё) СТОУС-ын дагуух үнэ цэнийн бууралтын тохируулгуудаас үүсч буй хойшлогдсон татварын нөлөө
- (ж) СТОУС -н шилжилтээс хуримтлагдсан ашиг болон нөөцүүдэд нөлөөлсөн нөлөөг доорх хүснэгтээс харна уу.

	Үлдэгдэл мян.төг
2023 оны 1 сарын 1-нээр	
Бусад нөөц	
СТОУС-д тулгуурлан Монголбанк-наас баталсан заавар, журмын дагуу	23,816,452
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүрийн СТОУС 9-н дагуу ЗҮЦХА хүлээн зөвшөөрөлт	(2,054,837)
Бусад нөөцөд үзүүлэх цэвэр нөлөө	(2,054,837)
СТОУС-н дагуу	21,761,615
Хуримтлагдсан алдагдал	
СТОУС-д тулгуурлан Монголбанк-наас баталсан заавар, журмын дагуу	(458,883,214)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх санхүүгийн хэрэглүүрээс бусад санхүүгийн хэрэглүүрийн СТОУС 9-н дагуу ЗҮЦХА хүлээн зөвшөөрөлт	(14,635,964)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүрийн СТОУС 9-н дагуу ЗҮЦХА хүлээн зөвшөөрөлт	(15,038,698)
Бусад хөрөнгийн дахин хэмжилт	8,754,082
Борлуулахад бэлэн үнэт цааснаас бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг алдагдлын тайланд бүртгэх өмчийн үнэт цаас руу дахин ангилал	(3,774,520)
Бусад татварын авлагын дахин хэмжилт	(7,684,534)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүрийн СТОУС 9-н дагуу ЗҮЦХА хүлээн зөвшөөрөлт	(311,611,233)
Хуримтлагдсан ашигт үзүүлэх цэвэр нөлөө	(343,990,867)
СТОУС-н дагуу	(802,874,081)

2.5 СТОУС-ын анхлан хэрэгжүүлэлт (үргэлжлэл)

2023 оны 1 дүгээр сарын 1 болон 2023 оны 12 дугаар сарын 31-нээрх Санхүүгийн байдлын тайлан, 2023 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн тохируулгуудын тайлбар:

	Үлдэгдэл мян.төг
2023 оны 12 сарын 31-нээр	
Бусад нөөц	
СТОУС-д тулгуурлан Монголбанк-наас баталсан заавар, журмын дагуу	38,817,504
СТОУС-9-ийн дагуу БҮЦӨБДО-д бүртгэгдэх өрийн хэрэглүүрийн хүлээгдэж буй зээлийн үнэ цэнийн бууралт	(844,864)
Бусад нөөцийн цэвэр нөлөө	(844,864)
СТОУС-н дагуу	37,972,640
Хуримтлагдсан ашиг	
СТОУС-д тулгуурлан Монголбанк-наас баталсан заавар, журмын дагуу	(846,437,473)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүрээс бусад санхүүгийн хэрэглүүрийн СТОУС 9-н дагуу ЗҮЦХА хүлээн зөвшөөрөлт	(2,280,730)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгийн СТОУС 9-н дагуу ЗҮЦХА хүлээн зөвшөөрөлт	(5,019,248)
Бусад авлагын дахин хэмжилт	1,422,618
Борлуулахад бэлэн үнэт цааснаас бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг алдагдлын тайланд бүртгэх өмчийн үнэт цаасруу дахин ангилал	(3,895,985)
Бусад татварын авлагын дахин хэмжилт	1,152,629
Хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийн дахин хэмжилт	(57,599,924)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүрийн СТОУС 9-н дагуу ЗҮЦХА хүлээн зөвшөөрөлт	70,177,181
Хуримтлагдсан ашигт үзүүлэх цэвэр нөлөө	3,956,541
СТОУС-н дагуу	(842,480,932)

3. Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол болон төсөөллүүд

Үнэлэмж болон таамаглал, тооцооллыг өмнөх жилүүдийн туршлага ба холбогдох бусад хүчин зүйлсэд үндэслэн гүйцэтгэдэг. Үүнд бодит үр дүн нь зөрүүтэй байж болох тул таамаглал, тооцооллыг байнга хянадаг. Таамаглал тооцоололд гарсан өөрчлөлт нь зөвхөн тайлант жилд нөлөөлөх бол өөрчлөлтийг тухайн тайлант хугацаанд, хэрэв өөрчлөлтийн нөлөө тайлант жил болон ирээдүйн тайлант жилүүдэд гарвал тухайн тайлант хугацаа болон өөрчлөлт гарах ирээдүйн тайлант жилүүдэд бүртгэлд тусгана.

Тооцооллын тодорхой бус байдлыг бий болгож буй гол хүчин зүйлс. Тайлант хугацаа бүрийн эцэст дараагийн санхүүгийн 12 сарын хугацаанд хөрөнгө ба өр төлбөрийн бүртгэлийн үнэд материаллаг залруулга хийгдэх эрсдэлтэй дор дурдсан нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж ба тодорхой бус байдлууд байна.

Зээл ба урьдчилгаа болон өмчлөх бусад хөрөнгөд тооцсон үнэ цэнийн бууралтын сан

Банк нь үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг харилцагчийн зээлд илэрсэн эсэхийг үнэлж, эрсдэлийн санг хүлээн зөвшөөрөх үгүйг тодорхойлдог. Үнэ цэнийн бууралт илэрсэн харилцагч байгаа үед, удирдлага нь харилцагчдын төлбөрийн хоцролтоос бий болсон үнэ цэнийн бууралтын санг хүлээн зөвшөөрөх шаардлага гарах бөгөөд харилцагчийн эргэн төлөлтийн хүсэлтийг хүлээн авах магадлалыг үнэлнэ.

Банк зээлийн багцын үнэ цэнийн бууралтыг тогтмол хянадаг. Харилцагчийн төлөх зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг тухайн тайлант үеийн ашиг алдагдлаар бүртгэх эсэхийг тодорхойлохдоо зээлийн багц дахь тухайлсан зээлийн үнэ цэнийн бууралтыг үнэлэхээс өмнө зээлийн багцын хүлээгдэж буй мөнгөн урсгалд хэмжигдэхүйц үнэ цэнийн бууралт ажиглагдаж байгаа эсэхийг тогтоодог. Үүнд Банкны зээлдэгчдийн эргэн төлөлтөд сөргөөр гарсан өөрчлөлтүүд эсвэл Банкны хөрөнгөд шууд нөлөө үзүүлэхүйц үндэсний болон бүс нутгийн эдийн засгийн нөхцөл байдалд үүссэн сөрөг өөрчлөлт зэрэг ажиглагдахуйц мэдээлэл орно. Удирдлага нь ирээдүйн мөнгөн урсгалыг товллохдоо ижил төрлийн зээлийн эрсдэлийн шинж чанартай хөрөнгийн үзүүлэлтүүдийн хувьд хохирол учирсан түүхэн мэдээлэл, мөн багц доторх хөрөнгийн үнэ цэнийн бууралтын талаарх бодит нотолгоонд үндэслэн тооцоолол хийдэг. Ирээдүйн мөнгөн урсгалын хэмжээ ба хугацааг төсөөлөхөд ашиглагдсан энэ аргачлал ба таамаглалыг тооцоолсон алдагдал болон бодит алдагдлын зөрүүг багасгах зорилгоор байнга хянадаг. Тусгайлсан зээлүүдэд байгуулсан үнэ цэнийн бууралтын зардлыг тухайн зээл бүрийн ирээдүйн мөнгөн урсгалыг хямдруулсан дүнд аливаа эргэн төлөлт болон зээлийн барьцаа хөрөнгийг борлуулснаас орж ирэх орлого зэргийг харгалзан үзэж тооцоолдог.

3. Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол болон төсөөллүүд (үргэлжлэл)

Зээл ба урьдчилгаанд тооцсон үнэ цэнийн бууралтын сан (үргэлжлэл)

Хураан авсан барьцаа хөрөнгийг анхлан өмчлөх бусад хөрөнгөөр хүлээн зөвшөөрөхдөө анх хураан авсан үнэ буюу анхны дансны үнээр бүртгэж, дараа нь дансны үнэ ба бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүн хоёрын аль багаар нь бүртгэнэ. Энэхүү хөрөнгийн үнэлгээ нь удирдлагын шийдвэр гаргах чадвар болон бие даасан үнэлгээчний туршлага болон бусад таамаглалуудаас хамаарна.

Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ

Санхүүгийн тайланд бүртгэлтэй санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийг нь идэвхтэй зах зээлийн нээлттэй үнэд үндэслэн хэмжихгүй бөгөөд бодит үнэ цэнийг хорогдуулсан мөнгөн урсгалын арга гэх мэт үнэлгээний арга техник ашиглан тооцоолно. Энэхүү арга техникийн өгөгдлийг ил зах зээлийн мэдээлэл дээр үндэслэн хэрэв мэдээлэл олдоц багатай бол шүүн тунгаалт ашиглан бодит үнэ цэнийг тодорхойлно. Таамаглалд өөрчлөлт орох нь бүртгэлтэй байгаа санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнд нөлөөлж болзошгүй. Тодруулга 6-с дэлгэрүүлэн харна уу.

4. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

	2024 мян.төг	2023 мян.төг
Монголбанк дахь харилцах	89,251,691	104,397,326
Сангийн Яам дахь харилцах	57,055	843,615
Бусад банкуудад байршуулсан харилцах:		
- Дотоод	109,676,604	3,718,179
- Гадаад	162,968,746	33,923,368
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	361,954,096	142,882,488
Хасах нь: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан	—	—
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр дүн	361,954,096	142,882,488

Монгол банк болон бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан

Мөнгө ба түүнтэй адилтгах мөнгөн хөрөнгийн эрсдэлийн чанарыг Мүүдийз, Стандарт энд Пүүрс болон Фитчийн тогтоосон зэрэглэлээр үнэлсэн. 2024 болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх зээлжих зэрэглэл дараах байдалтай байна:

	2024 мян.төг		2023 мян.төг	
	Чанаргүйдэлд		Чанаргүйдэлд	
	12 сар	өртөх дүн	12 сар	өртөх дүн
	ЧМ шатлал	Шатлал 1	ЧМ шатлал	Шатлал 1
2024 оны 12 дугаар сарын 31				
A1	0.006%	158,917,412	0.006%	19,475,439
Baa1	0.183%	4,051,160	0.161%	14,447,751
Монголбанк - B2 (2023: B3)	3.286%	89,251,691	3.002%	104,397,326
Сангийн Яам - B2 (2023: B3)	3.286%	57,055	3.002%	843,709
B2 (2023: B3)	3.286%	109,676,518	3.002%	3,718,090
Зэрэглэлгүй	100%	260	100%	173
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах мөнгөн хөрөнгө, касс дахь бэлэн мөнгийг хассан		361,954,096		142,882,488

5. БУСАД БАНКУУДАД БАЙРШУУЛСАН МӨНГӨН ХАДГАЛАМЖ

Бусад банкуудад байршуулсан мөнгөн хадгаламжууд нь тухайн хадгаламжийг авснаас хойш гурван сараас дээш хугацаатай хадгаламжууд байна.

Мөнгөн хадгаламжийн эрсдэлийн чанарыг Мүүдийз, Стандарт энд Пүүрс болон Фитчийн зэрэглэлээр үнэлсэн. 2024 болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх зээлжих зэрэглэл дараах байдалтай байна:

	2024 мян.төг	2023 мян.төг
Дотоодын зэрэглэлгүй банкуудад байршуулсан хадгаламж	36,555,562	39,172,483
Нийт банкуудад байршуулсан мөнгөн хадгаламж	36,555,562	39,172,483
Хасах нь: Бусад банкуудад байршуулсан мөнгөн хадгаламжийн үнэ цэнийн бууралтын сан	(36,555,562)	(39,172,483)
Нийт бусад банкуудад байршуулсан мөнгөн хадгаламжийн цэвэр дүн	—	—

Бусад банкуудад байршуулсан мөнгөн хадгаламжийн үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан

Бусад банкуудад байршуулсан мөнгөн хадгаламжид байгуулсан үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сангийн хөдөлгөөнийг харуулав:

	2024 мян.төг	2023 мян.төг
Шатлал 3	Шатлал 3	Шатлал 3
1 сарын 1-ний байдлаарх дансны дүн	39,172,483	40,253,717
Төлөгдсөн	(646,647)	(1,205,612)
Нийт хуримтлагдсан хүүгийн хөдөлгөөн	—	280,565
Данснаас хассан	(1,970,274)	—
Гадаад валютын ханшийн тохируулга	—	(156,187)
12 сарын 31-ний байдлаар	36,555,562	39,172,483
1 сарын 1-ний байдлаарх ЗҮЦХА	39,172,483	40,253,717
Тайлант жилийн цэвэр буцаалт (Тод. 23)	(646,647)	(925,047)
Данснаас хассан	(1,970,274)	—
Гадаад валютын ханшийн тохируулга	—	(156,187)
12 сарын 31-ний байдлаар	36,555,562	39,172,483

6. ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРҮҮД

Доорх хүснэгтэд хөрөнгө болон өр төлбөрт бүртгэгдсэн санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийг нэрлэсэн үнийн хамтаар харууллаа. Нэрлэсэн үнэ нь санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн суурь болж буй хөрөнгө, жишиг ханш эсхүл индекс байх бөгөөд санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн үнэ цэнийн өөрчлөлтийг хэмжих суурь болно. Нэрлэсэн үнэ нь тайлант жилийн эцсийн байдлаарх гүйлгээний дэнг харуулах бөгөөд энэ нь зах зээлийн эрсдэл эсхүл зээлийн эрсдэлийг тодорхойлох үзүүлэлт болж чадахгүй юм.

	Нэрлэсэн үнэ мян.төг	Бодит үнэ цэнэ	
		Хөрөнгө мян.төг	Өр төлбөр мян.төг
2024 оны 12 сарын 31-нээр			
<i>Санхүүгийн үүсмэл хэрэглүүр</i>			
МБ-тай хийсэн валют, хүүгийн своп хэлцэл (а)	193,244,125	2,539,724	1,381,978
Форвард хэлцэл (б)	206,882,172	20,272	—
	400,126,297	2,559,996	1,381,978
2023 оны 12 сарын 31-нээр			
<i>Санхүүгийн үүсмэл хэрэглүүр</i>			
Форвард хэлцэл (в)	244,309,213	—	4,227,824
	244,309,213	—	4,227,824

Санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн хувьд анхны хөрөнгө оруулалт бага байх буюу эсхүл огт шаардахгүй. Хэдий тийм боловч эдгээр санхүүгийн хэрэглүүр нь ихэвчлэн хөшүүргийн зэргийг өндөрсгөх бөгөөд нилээд тогтворгүй байна. Санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн хэлцлийн хөрөнгө, түвшин, индексийн үнэлгээний жижиг хэмжээний өөрчлөлт нь банкны ашиг, алдагдалд томоохон нөлөө үзүүлж болзошгүй.

Банк нь санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн гэрээний эрсдэлд өртөх дүнг банкны зах зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд тодорхойлдог. Банкны эрсдэлийн удирдлагын стратеги ба түүний хэрэгжүүлэлтийн талаар Тодруулга 29-д толилуулав.

(а) Банк нь Монголбанктай валют, хүүгийн своп хэлцэл хийсэн. Банк нь анх Монгол банкинд америк долларын санхүүжилт төлж, спот ханшаар тооцон төгрөгийн санхүүжилт хүлээн авсан. Монголбанктай байгуулсан гэрээний хугацаанд, Банк нь америк долларын санхүүжилтэд LIBOR дээр тодорхой хэмжээний ашиг нэмсэн хүүг хүлээн авах ба төгрөгийн санхүүжилтэд төв банкны бодлогын хүүтэй тэнцүү хувиар тооцсон хүү төлнө. Гэрээний хугацаа дуусгавар болоход талууд анхны гүйлгээний валютын ханшаар үндсэн төлбөрийг солилцоно.

(б) 2024 оны 12 сарын 31-ний байдлаар Банк “Си Ай Си Си Финаншиал Продакт ЛТД”-тэй форвард гэрээ байгуулсан. Энэ гэрээ 2024 оны 12-р сарын 23-наас 2025 оны 1-р сарын 24-ний хооронд хугацаатай. Гэрээний хугацаа дуусгавар болоход Банк 3,558 мянган ам.доллар, Си Ай Си Си нь 26,000 мянган юань хүлээн авна.

(в) Банк 2023 оны 12-р сарын 31-ний байдлаар “Саксо Банк”-тай форвард гэрээ байгуулсан бөгөөд энэ нь 2023 оны 12-р сарын 13-наас 2024 оны 1-р сарын 18-ны хугацаатай байна.

7. САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

	2024 мян.төг	2023 мян.төг
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүр :		
Компанийн бонд –Эрдэнэс Тавантолгой ТӨХК (а)	—	136,639,681
	—	136,639,681
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өмчийн хэрэглүүр:		
Хөрөнгийн биржид бүртгэлтэй – МИК Холдинг ХК (б)	51,067,994	67,803,010
	51,067,994	67,803,010
Хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх өрийн хэрэглүүр:		
Компанийн бонд – Төрийн Орон Сууцны Корпораци ТӨХК (в)	187,696,678	179,680,511
Компанийн бонд – Дархан Арьс Ширний Цогцолбор ХХК (г)	8,070,369	8,070,368
	195,767,047	187,750,879
Нийт санхүүгийн хөрөнгө оруулалт	246,835,041	392,193,570

- (а) Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй бонд нь дотоодын компанийн хаалттай бондууд болно.
- (б) Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй үнэт цаас гэдэгт дотоодын зах зээлд бүртгэлтэй МИК Холдинг ХК-ийн үнэт цаас орно.
- (в) Компанийн бондууд нь 2013 болон 2015 онд Төрийн Орон Сууцны Корпораци ТӨХК-д олгосон зээлийн төлбөрийн оронд олгосон нийт 180,500 сая төгрөгийн үнэтэй бондууд бөгөөд 2027 оны 12 дугаар сард дуусах хугацаатай байна.
- (г) Компанийн бондууд нь 2020 онд Дархан Арьс Ширний Цогцолбор ХХК-тай байгуулсан өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээний дагуу авсан нийт 15 тэрбум төгрөгийн үнэтэй бондууд бөгөөд 2025 оны 2 дугаар сард дуусах хугацаатай.

Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан

	2024 мян.төг	2023 мян.төг
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүр		
1 сарын 1-нээр	137,484,545	243,135,960
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(137,474,150)	(94,672,314)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт	(10,395)	(10,979,101)
12 сарын 31-нээр	—	137,484,545
Үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан		
1 сарын 1-нээрх	844,864	2,054,837
Тайлант жилд буцаасан (Тодруулга 20)	(844,864)	(1,209,973)
12 сарын 31-нээр	—	844,864
Нийт бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүр	—	136,639,681

7. САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан (үргэлжлэл)

	2024 мян.төг	2023 мян.төг
1 сарын 1-нээр	209,649,163	593,985,725
Шинээр худалдаж авсан	10,117,809	3,489,991
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	—	(387,826,553)
12 сарын 31-нээр	219,766,972	209,649,163
Үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан		
1 сарын 1-нээр	21,898,284	20,986,909
Шинээр худалдаж авсан	3,383,507	3,044,292
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(1,281,866)	(2,132,917)
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 23)	2,101,641	911,375
12 сарын 31-нээр	23,999,925	21,898,284
Нийт хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэглүүр	195,767,047	187,750,879

8. ЗЭЭЛ БА УРЬДЧИЛГАА

Зээл ба урьдчилгаа нь доорх байдалтай харагдаж байна:

	2024 мян.төг	2023 мян.төг
Улсын байгууллагын зээл	904,378,395	784,218,720
Хувийн байгууллагын зээл	1,367,180,969	1,478,157,289
Харилцагчдад олгосон нийт зээл ба урьдчилгаа	2,271,559,364	2,262,376,009
Хасах нь: үнэ цэнийн бууралтын сан	(977,236,569)	(1,048,102,269)
Харилцагчдад олгосон цэвэр зээл ба урьдчилгаа	1,294,322,795	1,214,273,740

Банкны зээлдэгчид нь Банкнаас шууд санхүүжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж буй компаниуд болон Банкны зээлийг дамжуулан зээлдүүлдэг арилжааны банкуудаас бүрдэнэ.

Банк нь Монгол Улсын Засгийн Газрын эдийн засгийн хөгжлийн бодлогод түшиглэсэн гол стратегийн салбарууд болох цахилгаан, агаарын тээвэр, уул уурхай, барилгын салбарууд болон боловсруулах үйлдвэрийн салбаруудад голчлон санхүүжилт олгодог. Банк нь эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, эдийн засгийг төрөлжүүлэх, нэмүү өртөг шингэсэн, экспортыг дэмжих, импортыг орлоход чиглэсэн хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг дунд болон урт хугацаанд санхүүжүүлэхээр зорьж байна.

Банкны үйл ажиллагааны онцлог, мөн зээлдэгчдийн тоо цөөн байгаагийн улмаас Банкинд тодорхой эрсдэлийн төвлөрөл бий. 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар, банкны хамгийн том 5 зээлдэгчийн нийт зээл, үнэ цэнийн бууралтын өмнө 1,305,037 сая төгрөгт (2023 оны 12-р сарын 31-нд: 1,236,622 сая төгрөг) хүрч, нийт зээл ба авлагын 57.5%-ийг (2023 оны 12-р сарын 31-нд: 56.9%) эзэлж байна. Эдгээр 5 том зээлдэгчийн зээл, 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар үнэ цэний бууралтын дараа 9298230 сая төгрөгт (2023 оны 12-р сарын 31-нд: 654,393 сая төгрөг) хүрч, цэвэр зээл ба авлагын 70.2%-ийг (2023 оны 12-р сарын 31-нд: 58.2%) эзэлж байна. Эдгээр 5 том зээлдэгчдэд олгосон зээлд дотоодын арилжааны банкуудаар дамжуулан олгосон зээл ороогүй болно.

8. ЗЭЭЛ БА УРЬДЧИЛГАА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа

Доорх хүснэгтэд Банкны дотоодын зээлийн үнэлгээний систем, жилийн эцсийн ангилал дээр тулгуурлаж зээлийн чанарыг багц болон сангийн хөдөлгөөнөөр илэрхийлж харуулсан болно.

	Улсын байгууллага мян.төг	Хувийн байгууллага мян.төг	Нийт мян.төг
2024 оны 1 сарын 1-нээр	784,218,720	1,478,157,289	2,262,376,009
Шинээр олгосон	91,813,285	–	91,813,285
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(12,446,118)	(121,630,691)	(134,076,809)
Хуримтлагдсан хүүгийн цэвэр хөдөлгөөн	40,792,508	15,933,711	56,726,219
Данснаас хассан	–	(5,279,340)	(5,279,340)
2024 оны 12 сарын 31-нээр	904,378,395	1,367,180,969	2,271,559,364
2024 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаарх ЗҮЦХА-ын сан	42,223,142	1,005,879,127	1,048,102,269
Шинээр олгосон	419,388	–	419,388
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(7,362,493)	(65,556,485)	(72,918,978)
Хуримтлагдсан хүүгийн цэвэр хөдөлгөөн	(190,188)	7,663,319	7,473,131
Тайлант хугацааны цэвэр зардал (Тод. 23)	(7,133,293)	(57,893,166)	(65,026,459)
Данснаас хассан	–	(5,279,340)	(5,279,340)
Гадаад валютын ханшийн тохируулга	–	(559,901)	(559,901)
2024 оны 12 сарын 31-нээр	35,089,849	942,146,720	977,236,569

8. ЗЭЭЛ БА УРЬДЧИЛГАА (ҮРГЭЛЖЛЭЛ)

	Улсын байгууллага мян.төг	Хувийн байгууллага мян.төг	Нийт мян.төг
2023 оны 1 сарын 1-нээр	694,803,036	1,946,971,704	2,641,774,740
Шинээр олгосон	78,399,636	–	78,399,636
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(18,324,477)	(353,916,567)	(372,241,044)
Хуримтлагдсан хүүгийн цэвэр хөдөлгөөн	29,340,525	(33,241,786)	(3,901,261)
Данснаас хассан	–	(81,656,062)	(81,656,062)
2023 оны 12 сарын 31-нээр	784,218,720	1,478,157,289	2,262,376,009
2023 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаарх ЗҮЦХА-ын сан	39,781,545	1,154,425,629	1,194,207,174
Шинээр олгосон	1,999,043	–	1,999,043
Төлөгдсөн эсвэл хүлээн зөвшөөрсөн	(1,265,064)	(45,775,051)	(47,040,115)
Хуримтлагдсан хүүгийн цэвэр хөдөлгөөн	1,707,618	(22,532,056)	(20,824,438)
Тайлант хугацаанд буцаасан (Тод. 23)	2,441,597	(68,307,107)	(65,865,510)
Данснаас хассан	–	(77,786,541)	(77,786,541)
Валютын ханшийн тохируулга	–	(2,452,854)	(2,452,854)
2023 оны 12 сарын 31-нээр	42,223,142	1,005,879,127	1,048,102,269

2024 оны 12 сарын 31-ний байдлаарх дансны үнийг зээлийн чанараар харуулбал:

	Улсын байгууллага мян.төг	Хувийн байгууллага мян.төг	Нийт мян.төг
2024 оны 12 сарын 31-нээр			
Хэвийн	753,865,654	89,497,079	843,362,733
Анхаарал хандуулах	124,862,807	–	124,862,807
Хэвийн бус	–	168,875,268	168,875,268
Эргэлзээтэй	25,649,934	560,745,689	586,395,623
Муу	–	548,062,933	548,062,933
Нийт	904,378,395	1,367,180,969	2,271,559,364

2023 оны 12 сарын 31-ний байдлаарх дансны үнийг зээлийн чанараар харуулбал:

	Улсын байгууллага мян.төг	Хувийн байгууллага мян.төг	Нийт мян.төг
2024 оны 12 сарын 31-нээр			
Хэвийн	369,425,518	174,617,946	544,043,464
Анхаарал хандуулах	268,237,422	106,865,685	375,103,107
Хэвийн бус	–	373,533,740	373,533,740
Эргэлзээтэй	146,555,780	616,913,044	763,468,824
Муу	–	206,226,874	206,226,874
Нийт	784,218,720	1,478,157,289	2,262,376,009

8. ЗЭЭЛ БА УРЬДЧИЛГАА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Улсын байгууллагад олгосон зээл

	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
2024 оны 1 сарын 1-нээр	369,425,518	268,237,422	146,555,780	784,218,720
Шинээр олгосон	91,813,285	–	–	91,813,285
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(4,476,398)	(7,744,850)	(224,870)	(12,446,118)
Хуримтлагдсан хүүгийн цэвэр хөдөлгөөн	26,149,930	10,460,747	4,181,831	40,792,508
Шатлал хоорондын шилжилт	270,953,319	(270,953,319)	–	–
2024 оны 12 сарын 31-нээр	753,865,654	–	150,512,741	904,378,395
2024 оны 1 сарын 1-ний өдрийн байдлаарх ЗҮЦХА-ын сан	2,810,055	4,130,280	35,282,807	42,223,142
Шинээр олгосон	419,388	–	–	419,388
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(223,820)	(2,443,532)	(4,695,141)	(7,362,493)
Хуримтлагдсан хүүгийн цэвэр хөдөлгөөн	114,736	64,030	(368,954)	(190,188)
Шатлал хоорондын шилжилт	1,750,778	(1,750,778)	–	–
Тайлант жилд байгуулсан/(буцаасан)	2,061,082	(4,130,280)	(5,064,095)	(7,133,293)
2024 оны 12 сарын 31-нээр	4,871,137	–	30,218,712	35,089,849

Улсын байгууллагад олгосон зээл

	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
2023 оны 1 сарын 1-нээр	275,619,694	278,866,454	140,316,888	694,803,036
Шинээр олгосон	78,399,636	–	–	78,399,636
Төлсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(6,714,597)	(10,748,049)	(861,831)	(18,324,477)
Хуримтлагдсан хүүгийн цэвэр хөдөлгөөн	22,120,785	119,017	7,100,723	29,340,525
2023 оны 12 сарын 31-нээр	369,425,518	268,237,422	146,555,780	784,218,720
2023 оны 1 сарын 1-ний өдрийн байдлаарх ЗҮЦХА-ын сан	2,376,915	3,848,357	33,556,273	39,781,545
Шинээр олгосон	599,764	279,643	1,119,636	1,999,043
Төлсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(335,730)	–	(929,334)	(1,265,064)
Хуримтлагдсан хүүгийн цэвэр хөдөлгөөн	169,106	2,280	1,536,232	1,707,618
Тайлант жилд байгуулсан	433,140	281,923	1,726,534	2,441,597
2023 оны 12 сарын 31-нээр	2,810,055	4,130,280	35,282,807	42,223,142

8. ЗЭЭЛ БА УРЬДЧИЛГАА (ҮРГЭЛЖЛЭЛ)

2023 болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх дансны үнийг зээлийн чанараар харуулвал:

	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
2024 оны 12 сарын 31-нээр				
Хэвийн	753,865,654	—	—	753,865,654
Анхаарал хандуулах	—	—	124,862,807	124,862,807
Эргэлзээтэй	—	—	25,649,934	25,649,934
Нийт	753,865,654	—	150,512,741	904,378,395
2023 оны 12 сарын 31-нээр				
Хэвийн	369,425,518	—	—	369,425,518
Анхаарал хандуулах	—	268,237,422	—	268,237,422
Эргэлзээтэй	—	—	146,555,780	146,555,780
Нийт	369,425,518	268,237,422	146,555,780	784,218,720

Хувийн байгууллагад олгосон зээл

	Шатлал 1 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
2024 оны 1 сарын 1-нээр	174,617,946	1,303,539,343	1,478,157,289
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(84,825,563)	(36,805,128)	(121,630,691)
Хуримтлагдсан хүүгийн цэвэр хөдөлгөөн	(295,304)	16,229,015	15,933,711
Данснаас хассан	—	(5,279,340)	(5,279,340)
2024 оны 12 сарын 31-нээр	89,497,079	1,277,683,890	1,367,180,969
2024 оны 1 сарын 1-ний өдрийн байдлаарх			
ЗҮЦХА-ын сан	3,656,344	1,002,222,783	1,005,879,127
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(2,346,903)	(63,209,580)	(65,556,483)
Хуримтлагдсан хүүгийн цэвэр хөдөлгөөн	(7,598)	7,670,915	7,663,317
Тайлант жилийн буцаалт	(2,354,501)	(55,538,665)	(57,893,166)
Данснаас хассан	—	(5,279,340)	(5,279,340)
Валютын ханшийн тохируулга	—	(559,901)	(559,901)
2024 оны 12 сарын 31-нээр	1,301,843	940,844,877	942,146,720

8. ЗЭЭЛ БА УРЬДЧИЛГАА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (үргэлжлэл)

	Шатлал 1 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
2023 оны 1 сарын 1-нээр	345,940,473	1,601,031,231	1,946,971,704
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(170,281,065)	(183,635,502)	(353,916,567)
Хуримтлагдсан хүүгийн цэвэр хөдөлгөөн	(1,041,462)	(32,200,324)	(33,241,786)
Данснаас хассан	—	(81,656,062)	(81,656,062)
2023 оны 12 сарын 31-нээр	174,617,946	1,303,539,343	1,478,157,289
2023 оны 1 сарын 1-ний өдрийн байдлаарх ЗҮЦХА-ын сан	5,960,194	1,148,465,435	1,154,425,629
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(2,292,767)	(43,482,284)	(45,775,051)
Хуримтлагдсан хүүгийн цэвэр хөдөлгөөн	(11,083)	(22,520,973)	(22,532,056)
Тайлант жилийн буцаалт	(2,303,850)	(66,003,257)	(68,307,107)
Данснаас хассан	—	(77,786,541)	(77,786,541)
Валютын ханшийн тохируулга	—	(2,452,854)	(2,452,854)
2023 оны 12 сарын 31-нээр	3,656,344	1,002,222,783	1,005,879,127

2023 болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх дансны үнийг зээлийн чанараар харуулвал:

	Шатлал 1 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
2024 оны 12 сарын 31			
Хэвийн	89,497,079	—	89,497,079
Хэвийн бус	—	168,875,268	168,875,268
Эргэлзээтэй	—	560,745,689	560,745,689
Муу	—	548,062,933	548,062,933
Нийт	89,497,079	1,277,683,890	1,367,180,969
2023 оны 12 сарын 31			
Хэвийн	174,617,946	—	174,617,946
Анхаарал хандуулах	—	106,865,685	106,865,685
Хэвийн бус	—	373,533,740	373,533,740
Эргэлзээтэй	—	616,913,044	616,913,044
Муу	—	206,226,874	206,226,874
Нийт	174,617,946	1,303,539,343	1,478,157,289

9. ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ

Өмчлөх бусад хөрөнгө гэж Банкны хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулахтай холбоотой олж авсан үл хөдлөх хөрөнгүүдийг хэлнэ. Банк нь энэхүү хөрөнгийг ойрын хугацаанд борлуулна гэсэн төлөвлөгөөтэй байна.

2024 оны 12 сарын 31-ний өдрөөрх өмчлөх бусад хөрөнгийн нийт дансны үнэ 88,306,386 мянган төгрөг (2023 оны 12 сарын 31-ний өдрөөр: 90,165,083 мянган төгрөг) ба энэ нь Монгол Мах Экспо ХХК-ийн чанаргүй зээлийн үлдэгдэл болон Капитал Банк ХХК-аас авах дамжуулан зээлийн өр төлбөрт болон бусдаас тооцон авсан өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгүүд болно.

2024 онд, Банк нь 44 ширхэг орон сууцны барилга, нэг зогсоолын талбайг нийт 4,571,344 мянган төгрөгийн дансны үнэтэй өмчлөх бусад хөрөнгийг мөнгөжүүлсэн. Олз нь мөнгөжүүлсэн өмчлөх бусад хөрөнгүүдээс бүртгэгдсэн, Тодруулга 24-ийг харна уу.

Өмчлөх бусад хөрөнгө дараах хөрөнгүүдээс бүрдэнэ:

	2024 мян.төг	2023 мян.төг
Дуусаагүй үл хөдлөх	64,729,747	59,961,874
Ашиглахад бэлэн үл хөдлөх	103,044,850	112,384,067
Нийт өмчлөх бусад хөрөнгө	167,774,597	172,345,941
Хасах: Өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан	(1,430,881)	(6,318,718)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө рүү шилжүүлсэн (Тодруулга 10)	(76,508,604)	—
Өмчлөх бусад хөрөнгийн цэвэр дүн	89,835,112	166,027,223

Өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан

Өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сангийн хөдөлгөөнийг доор харуулав:

	2024 мян.төг	2023 мян.төг
Эхний үлдэгдэл	6,318,718	2,928,625
Тайлант жилд байгуулсан	463,191	5,925,665
Тайлант жилд буцаасан	(5,351,028)	(2,535,572)
Цэвэр хөдөлгөөн (Тодруулга 23)	(4,887,837)	3,390,093
Эцсийн үлдэгдэл	1,430,881	6,318,718

10. БОРЛУУЛАХ ЗОРИЛГООР ЭЗЭМШИЖ БУЙ ХӨРӨНГӨ

	2024 мян.төг	2023 мян.төг
1 сарын 1-нээр	—	—
Өмчлөх бусад хөрөнгөөс шилжсэн (Тодруулга 9)	76,508,604	—
12 сарын 31-нээр	76,508,604	—

Удирдлагын зүгээс эдгээр барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгийг одоогийн нөхцөл байдалд нь богино хугацаанд борлуулах боломжтой гэж үнэлсэн. Борлуулалтын ажил эхэлсэн байгаа ба эдгээр хөрөнгийг борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийн ангилалд бүртгэснээс хойш 1 жилийн хугацаанд борлуулна гэж төлөвлөж байна. Тайлангийн өдрийн байдлаар тухайн хөрөнгүүдийг худалдан авах боломжит худалдан авагчдыг тодорхойлон, борлуулалтын хэлцлийн үйл явц дуусах шатанд байна.

11. ОХИН КОМПАНИУД ДАХЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

(а) Охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт 2023 болон 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дараах байдалтай байна:

Компани	Үйл ажиллагаа	2024 мян.төг		2023 мян.төг	
		Эзэмшил (%)	Дансны үнэ	Эзэмшил (%)	Дансны үнэ
Ди Би Эм Лизинг ХХК	Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа	100	100,000,000	100	100,000,000
Ди Би Эм ассет менежмент ҮЦК ХХК	Хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ	100	10,000,000	100	10,000,000
Нийт охин компаниуд дахь хөрөнгө оруулалт			110,000,000		110,000,000

12. БУСАД ХӨРӨНГӨ

	2024 мян.төг	2023 мян.төг
Бусад авлага	80,824,017	90,915,851
Бусад урьдчилж төлсөн төлбөр	417,141	1,336,513
Хангамжийн материал	28,722	12,416
Нийт бусад хөрөнгө	81,269,880	92,264,780
Хасах: Бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан	(8,526,810)	(9,443,974)
Цэвэр бусад хөрөнгө	72,743,070	82,820,806

Бусад авлагад багтсан 78,164,611 мянган төгрөгийн авлага нь (2023 онд 90,912,629 мянган төгрөг) 2013 онд Төрийн Орон Сууцны Корпораци (ТОСК) -д олгосон зээл нь чанаргүй зээл болсонтой холбоотойгоор хураан авсан барьцаа хөрөнгүүд багтна. Банк 2020 онд өмчлөх бусад хөрөнгүүдийг орон нутгийн засаг даргын тамгийн газруудад шилжүүлэх үйл явцыг эхлүүлж, Улаанбаатар хот, Говь-Алтай аймаг, Хөвсгөл аймаг, Орхон аймгуудтай хураан авсан өмчлөх бусад хөрөнгүүдийг шилжүүлэх гэрээг байгуулсан. Гэрээний нөхцөлийн дагуу, өмчлөх бусад хөрөнгүүдтэй холбоотой бүх ирээдүйд хүртэх эдийн засгийн ашиг болон эрсдэл өгөөж нь орон нутгийн засаг захиргаанд шилжиж байгаа тул Банк борлуулсан хөрөнгүүдийн хяналтыг борлуулалтын гэрээний өдөр худалдан авагч талд шилжүүлсэн гэж үнэлсэн. Эдгээр хөрөнгийн төлбөрийг үндсэн болон хүүгийн төлбөрийг багтаасан зээлийн нөхцөлөөр эргүүлэн төлдөг.

Бусад авлагын үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан

Бусад авлагад байгуулсан үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сангийн хөдөлгөөнийг харуулав:

	2024 мян.төг	2023 мян.төг
Эхний үлдэгдэл	9,443,974	10,058,472
Тайлант жилд байгуулсан	191,421	534
Тайлант жилд буцаасан	(1,108,585)	(616,654)
Тайлант жилд байгуулсан/(буцаалт) (Тодруулга 23)	(917,164)	(616,120)
Гадаад валютын ханшийн зөрүү	—	1,622
Эцсийн үлдэгдэл	8,526,810	9,443,974

13. ҮНДСЭН ХӨРӨНГӨ БОЛОН БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Банкны үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийн дансны үнийн хөдөлгөөнийг дор харуулав:

	Барилга, байгууламж мян.төг	Тоног төхөөрөмж мян.төг	Тавилга, эд хогшил мян.төг	Тээврийн хэрэгсэл мян.төг	Нийт үндсэн хөрөнгө мян.төг	Программ хангамж, лиценз мян.төг	Нийт хөрөнгө мян.төг
Өртгөөрх							
2023 оны 1 сарын 1-нээр	27,731,006	1,525,203	622,480	523,742	30,402,431	1,815,542	32,217,973
Нэмэгдсэн	–	92,498	14,134	–	106,632	–	106,632
Данснаас хассан	–	–	(2,739)	(46,843)	(49,582)	–	(49,582)
2023 оны 12 сарын 31-нээр	27,731,006	1,617,701	633,875	476,899	30,459,481	1,815,542	32,275,023
Нэмэгдсэн	–	332,403	5,127	–	337,530	43,692	381,222
Данснаас хассан	–	–	(1,073)	–	(1,073)	–	(1,073)
2024 оны 12 сарын 31-нээр	27,731,006	1,950,104	637,929	476,899	30,795,938	1,859,234	32,655,172
Хуримтлагдсан элэгдэл							
2023 оны 1 сарын 1-нээр	4,619,907	1,320,626	411,097	326,078	6,677,708	1,509,314	8,187,022
Тайлант жилийн элэгдлийн зардал	691,361	164,904	52,114	43,061	951,440	61,212	1,012,652
Данснаас хассан	–	–	(2,740)	(46,844)	(49,584)	–	(49,584)
2023 оны 12 сарын 31-нээр	5,311,268	1,485,530	460,471	322,295	7,579,564	1,570,526	9,150,090
Тайлант жилийн элэгдлийн зардал	693,278	109,056	45,552	32,691	880,577	52,327	932,904
Данснаас хассан	–	–	(1,073)	–	(1,073)	–	(1,073)
2024 оны 12 сарын 31-нээр	6,004,546	1,594,586	504,950	354,986	8,459,068	1,622,853	10,081,921
Дансны цэвэр дүн							
2024 оны 12 сарын 31-нээр	21,726,460	355,518	132,979	121,913	22,336,870	236,381	22,573,251
2023 оны 12 сарын 31-нээр	22,419,738	132,171	173,404	154,604	22,879,917	245,016	23,124,933

14. ХАРИЛЦАГЧДЫН ХАРИЛЦАХ

	2024 мян.төг	2023 мян.төг
Харилцагчдын харилцах	3,160,662	37,915,273

Харилцагчдын харилцах дансыг Банкны харилцагчдад зээл олгох болон зээлийн эргэн төлөлтийн төлбөр тооцоонд голлон ашигладаг. Эдгээр харилцах дансанд хүү төлдөггүй. 2024 оны 12 сарын 31-ний өдрөөрх харилцагчдын харилцах нь 23 данснаас бүрдэж байна. (2023 оны 12 сарын 31-ний өдрөөр: 11 данс).

14.1 ХУГАЦААТ ХАДГАЛАМЖ

	2024 мян.төг	2023 мян.төг
Хугацаат хадгаламж	—	34,123,720

15. БУСАД ӨР ТӨЛБӨР

	2024 мян.төг	2023 мян.төг
Бусад санхүүгийн өр төлбөр		
Тэнцлийн гадуурх үүргийн нөөц	—	7,670,504
Банк хоорондын тооцоо	669,037	789,507
Бусад	2,090,232	2,384,112
Бусад санхүүгийн бус өр төлбөр	76,620	11,259
Нийт бусад өр төлбөр	2,831,889	10,855,382

16. БУСАД БАНКУУДАД ӨГӨХ ӨГЛӨГ

	2024 мян.төг	2023 мян.төг
Бусад банкуудаас байршуулсан богино хугацаат хадгаламж	108,043,345	225,210,272

Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан хөрөнгөнд 3 сар хүртэл хугацаатай хадгаламжууд орсон бөгөөд хүүгийн түвшин нь 1%-ээс 4.25% хүртэл байна (2023 онд: 6%-аас 15% хүртэл).

17. ӨРИЙН БИЧИГ

Өрийн бичиг нь дараах байдалтай байна:

	2024 мян.төг	2023 мян.төг
Баталгаагүй:		
2026 он хүртэлх, 200 сая ам.долларын өрийн бичиг	704,879,020	—
2031 он хүртэлх, 142.5 тэрбум төгрөгийн хаалттай өрийн бичиг	145,035,310	145,231,182
2025 он хүртэлх, 76.5 тэрбум төгрөгийн хаалттай өрийн бичиг	78,612,130	79,071,313
2027 он хүртэлх, 346 тэрбум төгрөгийн хаалттай өрийн бичиг	353,710,744	353,710,744
Дотоодын арилжааны банкуудад гаргасан 32 ам.долларын өрийн бичиг	109,775,264	109,464,589
Нийт гаргасан өрийн бичиг	1,392,012,468	687,477,828

2021 оны 10 дугаар сард Банк 142,458 сая төгрөгийн хаалттай өрийн бичгийг Монголын биржийн бус зах зээлд гаргасан. Энэхүү өрийн бичиг нь Монгол Улсын зах зээлд гаргасан хамгийн том өрийн бичиг байсан. Банк нь 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр төгрөгийн үнэт цаасны 2 дахь транч болох 76,531 сая төгрөгийг 2025 оны 4 дүгээр сард төлөх нөхцөлтэйгөөр, Монголын биржийн бус зах зээл дээр амжилттай гаргасан. 2024 оны 10 дугаар сард Банк тус өрийн бичгийн эхний транчийг 2031 он хүртэл 7 жилийн хугацаатай сунгасан.

2023 оны 5 дугаар сард Банк 260,073 сая төгрөгийн хаалттай өрийн бичгийг гаргасан. 2023 оны 6 дугаар сард төгрөгийн үнэт цаасны 2 дахь транч болох 85,935 сая төгрөгийг 2027 оны 5 дугаар сард дуусах нөхцөлтэй амжилттай гаргасан.

2023 оны 12 дугаар сард Банк дотоодын арилжааны банкнуудад нийт 32 сая ам.долларын үнэт цаасыг 2025 оны 12 сард дуусах нөхцөлтэйгөөр арилжаалсан.

2024 оны 3 дугаар сард Банк олон улсын зах зээлд хаалттай үнэт цаас арилжаалж 2026 онд дуусах хугацаатай 200 сая ам.долларын эх үүсвэр татсан.

18. ЗЭЭЛЭЭР АВСАН САНХҮҮЖИЛТ

Зээлээр авсан санхүүжилт нь дараах байдалтай байна:

	2024 мян.төг	2023 мян.төг
Баталгаатай:		
Хятадын Хөгжлийн Банк	176,981,277	106,689,216
Баталгаагүй:		
ВЭБ.РФ	124,622,080	170,819,236
Сангийн Яам	44,105,600	—
Монгол Банк	—	429,893,260
Бусдаас авсан нийт зээлийн дүн	345,708,957	707,401,712

ВЭБ.РФ. Банк нь 2018 оны 10-р сард ВЭБ.РФ-тай хоёр талын зээлийн гэрээ байгуулсан. Санхүүжилт татсан зорилго нь газар тариалангийн тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулсан санхүүжилтийг дахин санхүүжүүлэх зорилготой. Энэхүү зээлийн хугацаа нь 2026 оны 10-р сард дуусна.

Банк 2019 оны 6-р сард ВЭБ.РФ-тай нэмэлт хоёр талын гэрээ байгуулсан бөгөөд зээлийн хэмжээ нь 16.4 сая евро болон 2.9 сая евро байна. Эдгээр зээлийн хугацаа тус тус 2026 оны 7-р сар болон 2025 оны 6-р сард дуусна. Эдгээр зээлийн зорилго нь Дулааны Дөрөвдүгээр Цахилгаан Станц ТӨХК-ийн (ДЦС-4) өргөтгөлийн төслүүдийг санхүүжүүлэх юм.

Банк 2025 оны 3 дугаар сарын байдлаар ВЭБ.РФ банкнаас авсан еврогийн зээлүүдийн эргэн төлөлтийг бүрэн гүйцэтгэсэн байна.

18. ЗЭЭЛЭЭР АВСАН САНХҮҮЖИЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хятадын Хөгжлийн Банк. Банк нь 2020 онд Чойбалсан Дулааны Цахилгаан Станц төслийг санхүүжүүлэх зорилгоор Хятадын Хөгжлийн Банктай зээлийн гэрээ байгуулан нийт 420.0 сая юанийн санхүүжилтийг 10 жилийн хугацаатай, тогтмол хүүтэйгээр татан төвлөрүүлэх зээлийн гэрээг байгуулсан. Банк нь төслийн санхүүжилттэй уялдуулан зээлийн гэрээний хүрээнд 44.2 сая юанийг 2021 оны 10 дугаар сард, 25.6 сая юанийг 2022 оны 5 дугаар сард, 11.3 сая юанийг 2023 оны 3 дугаар сард, 145.1 сая юанийг 2023 оны 11 дүгээр сард тус тус татсан. 2024 оны 5 дугаар сард 148.9 сая юан, 10 дугаар сард 44.5 сая юанийг татсан. Нийт Хятадын Хөгжлийн Банкнаас 420 сая юанийн олголт авсанаас 43.5 сая юан эргэн төлсөн байна.

Сангийн яам. Банк нь 2024 оны 12 дугаар сард Сангийн яамтай тогтмол хүүтэй зээлийн гэрээ хийсэн.

Зээлийн шалгуур үзүүлэлтүүд. ВЭБ.РФ банк болон Хятадын Хөгжлийн банктай байгуулсан зээлийн гэрээ нь Банкны санхүүгийн тайлан болон бусад мэдээлэлтэй холбоотой хэд хэдэн санхүүгийн шалгуур үзүүлэлтийг агуулсан байдаг ба эдгээрт дараах зүйлс орно:

- Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч агентлагаас гаргасан зээлжих зэрэглэл
- Хөрөнгийн зохистой харьцаа
- Тогтвортой эх үүсвэрийн харьцаа
- Чанаргүй зээлийн харьцаа
- Цэвэр нээлттэй позиц
- Нээлттэй зээлийн харьцаа.

2024 болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дээр дурдсан зарим гэрээнүүдэд заагдсан харьцаа үзүүлэлт хангагдаагүй байна.

18.1 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ҮҮССЭН ӨР ТӨЛБӨРИЙН ТОХИРУУЛГА

Доорх хүснэгт нь Банкны санхүүгийн мөнгөн болон мөнгөн бус үйл ажиллагааны өөрчлөлтөөс үүссэн өр төлбөрийн тохируулгыг харуулж байна. Өнгөрсөн мөнгөн урсгал болон ирээдүйн мөнгөн урсгалын санхүүгийн үйл ажиллагаанаас үүсэх өр төлбөрийг Банкны тусдаа мөнгөн гүйлгээний тайланд тусгана.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн өр төлбөрийн хөдөлгөөнийг харуулав:

	2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр	Санхүүгийн мөнгөн гүйлгээ		Ханшийн зөрүү	Бусад өөрчлөлт (*)	2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
		Орох урсгал	Гарах урсгал			
Өрийн бичиг	687,477,828	817,615,836	(143,480,902)	9,269,282	21,130,425	1,392,012,469
Зээлээр авсан санхүүжилт	707,401,712	135,024,132	(487,207,780)	(9,842,168)	333,061	345,708,957

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн өр төлбөрийн хөдөлгөөнийг харуулав:

	2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр	Санхүүгийн мөнгөн гүйлгээ		Ханшийн зөрүү	Бусад өөрчлөлт (*)	2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
		Орох урсгал	Гарах урсгал			
Өрийн бичиг	2,572,205,220	455,359,860	(2,327,858,348)	(209,280)	(12,019,624)	687,477,828
Зээлээр авсан санхүүжилт	582,540,605	503,373,558	(383,576,833)	4,016,772	1,047,610	707,401,712

*Бусад өөрчлөлтүүд нь хуримтлагдсан хүүгийн хөдөлгөөн болно.

19. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ

Холбоотой талууд болон холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээг НББОУС 24 “Холбоотой талуудын тодруулга” стандартад заасны дагуу үнэлдэг. Тодруулга 1-д дурдсанаар Банкныг Монгол Улсын Засгийн газар 100% эзэмшдэг бөгөөд үндсэн үйл ажиллагаа нь Монгол Улс дахь төслүүдийг санхүүжүүлэх юм. Тиймээс Банк нь Монгол Улсын Засгийн Газрын эзэмшлийн үр дүнд холбоотой талуудтай ажил гүйлгээнүүдийг хийдэг. НББОУС 24 “Холбоотой талуудын тодруулга”-ын дагуу Банкны бусад холбоотой талуудад Монгол Улсын Засгийн газар хяналттай, хамтарсан хяналттай болон мэдэгдэхүйц нөлөө бүхий төрийн өмчийн компаниуд болон бусад байгууллагууд багтдаг.

Үйл ажиллагааны онцлогоос хамаараад Банк нь Монгол Улсын Засгийн газар болон бусад холбоотой талуудтай их хэмжээний ажил гүйлгээнүүдийг хийдэг бөгөөд үүнд Монгол Улсын Засгийн Газрын гаргасан баталгаа хамаарна. Банкны үйл ажиллагааны орчны мэдээллийг Тодруулга 1-д толилуулсан. Зээлийн үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сангийн түвшинг тодорхойлох удирдлагын үнэлэмжийг Тодруулга 2.4-өөс харна уу.

Холбоотой талуудын ажил гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг доор нэгтгэв.

Холбоотой талуудад хамаарах хөрөнгө болон ажил гүйлгээ

Банк дараах холбоотой талуудтай хийсэн гүйлгээнүүд болон үлдэгдлийг тодруулсан:

1. Монгол Улсын Засгийн газар (ЗГ-аас удирдлагыг томилдог Сангийн Яам болон бусад яамдууд багтана),
2. Монгол Улсын Засгийн Газрын хяналттай аж ахуйн нэгжүүд, үүнд төрийн байгууллагууд багтана (жишээ нь корпорацын аж ахуйн нэгжүүд), дотоодын арилжааны банк (Төрийн Банк ХХК), Монголбанк; эдгээр аж ахуйн нэгжүүд нь Банктай нэгдсэн хяналтад байдаг аж ахуйн нэгжүүд юм.
3. Охин компаниуд

19. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банкны холбоотой талуудын эзэмшиж буй хөрөнгө болон өр төлбөр (зээл ба урьдчилгаа багтаагүй), тэдгээртэй хийсэн ажил гүйлгээний шинжилгээг дор толилуулав:

	Санхүүгийн байдлын тайлан		Дэлгэрэнгүй орлогын тайлан	
	2024	2023	2024	2023
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Сангийн яаманд байршуулсан харилцах	57,055	843,615	—	—
Монголбанкинд байршуулсан харилцах	89,251,691	104,397,326	—	2,931,565
Төрийн банкинд байршуулсан харилцах	237,308	72,236	—	—
Ажилтнуудын тэтгэмжид зориулсан Төрийн банк дахь харилцах данс	2,762	2,774	—	—
Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид байршуулсан харилцах	1,000	—	—	—
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	1,157,746	—	(9,845,008)	(49,917,851)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүр	—	137,484,545	—	23,399,438
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өмчийн хэрэглүүр	51,067,994	67,803,010	—	—
Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэглүүр	187,696,678	187,750,879	15,384,534	15,342,500
Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт (Тодруулга 11)	110,000,000	110,000,000	—	101,334
Төрийн байгууллагуудын харилцах данс (Тодруулга 14)	(3,034,986)	(8,746,735)	—	—
Ди Би Эм Лизинг ХХК-ийн харилцах данс	(8,291)	(29,099,931)	—	—
Эрдэнэс Таван Толгой ТӨХК-ийн хадгаламжийн данс	—	(34,123,720)	(22,426)	(1,033,428)
Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас авах бусад авлага	44,273,033	53,174,982	4,831,595	4,310,555
Хөвсгөл аймгийн ЗДТГ-аас авах бусад авлага	7,752,148	9,621,957	782,209	754,031
Говь-Алтай аймгийн ЗДТГ- аас авах бусад авлага	5,033,430	5,447,393	544,750	533,786
Орхон аймгийн ЗДТГ- аас авах бусад авлага	13,185,768	13,639,479	1,364,161	1,287,687
Сангийн яамд байршуулсан богино хугацаат хадгаламж (Тодруулга 17)	—	(100,391,71)	(2,704,110)	(391,781)
Монголбанкнаас авсан зээл (Тодруулга 18)	—	(429,893,260)	(15,632,055)	(28,493,119)
Сангийн яамнаас авсан зээл (Тодруулга 18)	(44,105,600)	—	(919)	—

Өр төлбөр болон зардлын дансуудыг хаалтанд харуулав.

19. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Холбоотой талуудад олгосон зээл ба урьдчилгаа

Банкны холбоотой талуудад олгосон зээл ба урьдчилгааны дэлгэрэнгүй дараах байдалтай байна. Доор харуулсан бүх байгууллагууд нь Банктай нэгдсэн нэг хяналтад байдаг төрийн өмчит байгууллагууд юм.

	Санхүүгийн байдлын тайлан		Дэлгэрэнгүй орлогын тайлан	
	2024	2023	2024	2023
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
-Төрийн Орон Сууцны Корпораци	25,649,932	25,649,932	—	—
-“ДЦС-4” ТӨХК	270,953,319	268,237,422	37,964,772	12,667,495
-Монгол Газрын Тос Боловсруулах Үйлдвэр ТӨХК	288,466,213	255,659,982	24,843,969	21,525,654
-Эрдэнэс Монгол ХХК	—	—	—	2,984,683
-Таван Толгойн Цахилгаан Станц	64,246,052	60,919,705	3,127,694	3,188,736
-Эгийн Голын Цахилгаан Станц	60,616,754	59,986,141	1,243,748	4,297,689
-Дорнод Бүсийн Эрчим Хүчний систем ТӨХК	194,446,122	109,263,993	11,796,606	3,693,275
-Зорчигч Тээвэр Гурав ТӨК	—	4,501,543	215,445	930,527
Холбоотой талуудад олгосон нийт зээл ба урьдчилгаа	904,378,392	784,218,718	79,192,234	49,288,059
Холбоотой талуудад олгосон нийт зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан:	(35,089,849)	(42,223,142)	29,973,373	(3,208,408)
Холбоотой талуудад олгосон цэвэр зээл ба урьдчилгаа	869,288,543	741,995,576	—	—

2024 болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх гол удирдлага (Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын баг)-ийн цалин хөлс ба урамшуулалд 1,049 сая төгрөг ба 1,116 сая төгрөгийг тус тус олгосон.

Хүлээн авсан баталгаа

2024 оны 12 сарын 31-нээр Банк нь Хятадын Хөгжлийн Банкнаас авсан зээлд Монгол Улсын Засгийн газрын баталгаа авсан.

Гаргасан баталгаа

2020 онд Банк нь Эрдэнэс МГЛ ХХК болон Эрдэнэс Силвер Ресурс ХХК-тай санхүүгийн баталгааны гэрээ байгуулсан ба эдгээр компаниудын гаргасан бондод 1,146 тэрбум төгрөгийн санхүүгийн баталгааг гаргасан. Тодруулга 33-с дэлгэрэнгүйг харна уу.

20. ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө нь Монгол Улсын Хөгжлийн Банкны тухай хуульд зааснаар Монгол Улсын Засгийн Газраас оруулсан хувь оролцооноос бүрдэнэ. Банкны эрх бүхий хувыцаа нь дор тодруулсан хувь нийлүүлсэн хөрөнгөтэй тэнцүү юм.

	2024 мян.төг	2023 мян.төг
Батлагдсан:		
Хувь нийлүүлсэн хөрөнгө, 12 сарын 31-ны өдрөөрх	1,216,300,341	1,216,300,341
Төлөгдсөн:		
1 сарын 1-ний өдрөөр	1,216,300,341	1,216,300,341
Тайлант хугацаанд нэмэгдсэн	—	—
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө, 12 сарын 31-ны өдрөөрх	1,216,300,341	1,216,300,341

2024 оны 12-р сарын 20-ний өдөр Монгол Улсын Засгийн газар холбогдох яамддаа Банкинд хөрөнгө оруулах боломжийг судлах, Засгийн газрын холбогдох сангуудын хөрөнгийг Банк руу чиглүүлэх боломжуудыг судлах үүргийг өгсөн байна.

Бусад нөөц

	2024 мян.төг	2023 мян.төг
1 сарын 1-нээр	37,972,640	21,761,615
БҮЦӨБДО-д бүртгэгдэх өрийн хэрэглүүрийн үнэ цэнийн бууралтын сангийн цэвэр өөрчлөлт (Тодруулга 7)	844,864	1,209,973
БҮЦӨБДО-д бүртгэх хэрглүүрийн цэвэр олз	(16,724,621)	16,341,703
Хойшлогдсон татварын өр (Тодруулга 28)	4,183,754	(1,340,651)
12 сарын 31-нээр	26,276,637	37,972,640

21. ХҮҮГИЙН ОРЛОГО

2024 оны 12-р сарын 31-ний болон 2023 оны жилийн эцэст, Банк нь зээл, хадгаламж, мөн хэрэглэгчидтэй хийсэн гүйлгээ зэрэг нэг төрөлд хамаарагдах бизнесийн сегментэд оролцсон байна.

	2024 мян.төг	2023 мян.төг
<i>Үр ашигт хүүгийн аргаар тооцоолон гаргасан хүүгийн орлого</i>		
Зээл ба урьдчилгаа	120,864,829	94,127,610
Банкуудад байршуулсан мөнгөн хадгаламж	6,666,303	3,227,275
Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэглүүр	18,768,041	44,221,030
БҮЦӨБДО-д илэрхийлэгдсэн өрийн хэрэглүүр	7,490,482	32,213,237
Бусад авлага	7,521,046	6,883,550
Нийт хүүгийн орлого	161,310,701	180,672,702

22. ХҮҮГИЙН ЗАРДАЛ

	2024 мян.төг	2023 мян.төг
<i>Үр ашигт хүүгийн аргаар тооцоолон гаргасан хүүгийн зардал</i>		
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	10,913,859	6,044,417
Монголбанкнаас авсан зээл	15,632,055	28,493,119
Сангийн яамны зээл	919	—
Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан хөрөнгө	6,133,223	3,610,440
Японы хөрөнгийн зах зээлд гаргасан 2023 онд дуусгавар болох өрийн бичиг	—	24,764,231
Олон улсын зах зээлд гаргасан 2023 онд дуусгавар болох өрийн бичиг	—	89,815,706
2026 онд дуусгавар болох 200 сая ам.долларын өрийн бичиг	62,181,828	—
Дотоодын арилжааны банкуудад гаргасан өрийн бичиг	10,365,167	341,730
Хугацаат хадгаламж	22,426	1,033,428
Биржийн бус зах зээлд гаргасан 2031 онд дуусгавар болох өрийн бичиг	14,957,997	13,865,912
Биржийн бус зах зээлд гаргасан 2025 онд дуусгавар болох өрийн бичиг	12,067,584	12,646,665
Биржийн бус зах зээлд гаргасан 2027 онд дуусгавар болох өрийн бичиг	56,380,426	34,477,898
Нийт хүүгийн зардал	188,655,484	215,093,546

23. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТЫН АЛДАГДЛЫН БУЦААЛТ

	2024 мян.төг	2023 мян.төг
Харилцагчидад олгосон зээл ба урьдчилгаа (Тодруулга 8)	(65,026,459)	(65,865,510)
Өмчлөх бусад хөрөнгө (Тодруулга 9)	(4,887,837)	3,390,093
Бусад хөрөнгө (Тодруулга 12)	(917,164)	(616,120)
Хорогдуулсан өртгөөр бүртгэх өрийн хэрэглүүр (Тодруулга 7)	2,101,641	911,375
Бусад банкуудад өгөх өглөг (Тодруулга 5)	(646,647)	(925,047)
Тэнцлийн гадуурх зээлийн үүрэг	(7,670,504)	3,895,984
Нийт хүлээгдэж буй үнэ цэнийн бууралтын буцаалт	(77,046,970)	(59,209,225)

24. БУСАД ОРЛОГО

	2024 мян.төг	2023 мян.төг
Торгуулийн орлого	—	215,148
Өмчлөх бусад хөрөнгө борлуулсны олз	244,045	229,062
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз	580	1,420
Бусад	5,119,856	54,823
Нийт бусад орлого	5,364,481	500,453

Торгуулийн орлого: Банк нь дотоодын арилжааны банкуудад байршуулсан байсан банкны хадгаламжуудаа дуусах хугацаанаас өмнө эргүүлэн татсан. Үүнтэй холбоотой арилжааны банкуудаас бэлэн мөнгө авах хугацаа хойшлогдсон тул торгуулийн орлогыг гэрээний нөхцөлийн дагуу эдгээр арилжааны банкуудаас авахаар тооцсон.

Өмчлөх бусад хөрөнгөтэй холбоотой олз: Банк нь өмчлөх бусад хөрөнгө борлуулсантай холбоотойгоор олз хүлээн зөвшөөрсөн

25. ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ТЭГШИТГЭЛИЙН ОЛЗ БОЛОН ГАРЗ, ЦЭВЭР

Ашиг, алдагдлын тайланд тусгасан гадаад валютын ханшийн тэгшитгэлийн олз болон гарзыг доор харуулав.

	2024	2023
	мян.төг	мян.төг
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн хэрэгжээгүй цэвэр гарз	(14,700,183)	2,440,378
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн хэрэгжсэн (гарз) /олз	(3,586,177)	16,991,078
Ханшийн тэгшитгэлийн (гарз)/ олз, цэвэр	(18,286,360)	19,431,456

Банк нь гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө болон өр төлбөрийн эзэмшдэг ба эдгээр нь монгол төгрөгийн эсрэг гадаад валютын ханшийн хэлбэлзэлд өртдөг. Банк нь гадаад валютын хэрэгслийн зээлийн төлбөр болон гадаад валютын свопуудын хугацааг зэрэгцүүлэн хэрэгжүүлэх холимог стратегийг ашиглан зах зээлийн эрсдлүүдийг бууруулдаг.

26. ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРИЙН ОЛЗ БОЛОН ГАРЗ

Банк нь үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс үүссэн олз, гарзыг сар бүр хүлээн зөвшөөрдөг ба хийгдсэн своп хэлцлийн дуусгавар хугацаанаас өмнө хэрэгжсэн хэсгийг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрдөг. Үнэлгээ нь санхүүгийн хэрэглүүрийн үнэлгээний цэвэр өөрчлөлтийг үүсгэж буй Монгол төгрөгтэй харьцах ханшийн өөрчлөлт, индекс, ханшийн хэлбэлзлээс хамаардаг.

	2024	2023
	мян.төг	мян.төг
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн хэрэгжсэн олз	950,170	50,185,779
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн хэрэгжсэн гарз	(3,586,595)	(1,280)
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн хэрэгжээгүй олз	20,483,816	95,302,372
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн хэрэгжээгүй гарз	(15,101,125)	(159,607,938)
Нийт үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн олз болон гарз	2,746,266	(14,121,067)

2023 оны 11-р сарын 7-ны өдөр Монгол банктай хийсэн нийт 325 сая ам.долларын дөрвөн урт хугацааны своп гэрээ дуусгавар болж 15,834 сая төгрөгийн цэвэр олз олсон. Мөн 2023 онд Saxo Bank-тэй хийсэн арван нэгэн форвард хэлцэл дуусгавар болж 34,352 сая төгрөгийн үнэлгээний цэвэр олз олсон. 2024 онд Банк нь Монголбанктай 56.5 сая ам.долларын своп хэлцэл хийсэн ба бодит үнэ цэнийн үнэлгээний олз 1.6 тэрбум төгрөгийг хүлээсэн. Мөн 2023 оны 12 сарын 31-нээр үлдэгдэлтэй байсан форвард гэрээнээс 950 сая төгрөгийн цэвэр олз олсон.

27. УДИРДЛАГЫН БОЛОН БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Банкны удирдлагын болон үйл ажиллагааны бусад зардал дараах байдалтай байна.

	Тодруулга	2024 мян.төг	2023 мян.төг
Цалин хөлс тэтгэмж		9,203,841	7,140,131
Хууль, бусад мэргэжлийн үйлчилгээ		1,386,312	1,532,697
Аудитын төлбөр		700,000	578,015
Элэгдэл ба хорогдол	13	932,904	1,012,652
Мэдээлэл технологи ба программ хангамж		744,810	601,235
Зээл цуглуулахтай холбоотой зардал		353,900	345,310
Хөрөнгийн татварын зардал		275,981	275,981
Харилцаа холбоо ба бичиг хэрэг		234,061	205,938
Ашиглалт, засвар үйлчилгээ, харуул хамгаалалт		266,845	216,470
Албан томилолт		392,808	274,043
Зар сүталчилгаа		182,626	184,560
Шатахуун болон тээврийн зардал		30,988	26,484
Сургалтын зардал		65,162	11,225
Бага дүнтэй болон богино хугацаат түрээсийн зардал		15,165	12,888
Даатгалын зардал		6,040	2,140
Бусад зардал		9,283	93,512
Нийт үйл ажиллагааны зардал		14,800,726	12,513,481

28. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР

Банк нь санхүүгийн тайлагналын зорилгоор орлогын татварын үндсэн дээр үнэлэгддэггүй эсвэл хасагддаг зүйлсийг зохицуулан орлогын татварын төлбөрийг тооцдог. Банк нь Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу 6 тэрбум (2023 онд: 6 тэрбум) төгрөг хүртэлх татвар ногдох орлогоос 10% (2023 онд: 10%), 6 тэрбум (2023 онд: 6 тэрбум)-аас илүү гарсан дүнгээс 25% (2023 онд: 25%) орлогын албан татвар төлдөг. Засгийн Газрын бондын хүүгийн орлого нь хуулийн дагуу татвар ногдохгүй орлого болно.

2024 оны 12 сарын 31-нээр болон 2023 оны 12 сарын 31-нээр орлогын албан татварын зардал нь:

	2024 мян.төг	2023 мян.төг
Тайлант үеийн орлогын албан татварын зардал	9,052,004	—
Түр зөрүүний буцаалт болон үүсэлтэй хамааралтай хойшлогдсон татварын зардал	27,863,478	57,611,389
Тайлант үеийн орлогын албан татварын зардал	36,915,482	57,611,389

28. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банк нь татварын өмнөх ашгаас хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардлыг Банкинд хүчин төгөлдөр үйлчлэх орлогын татварын хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардалд 2024 оны 12 сарын 31-нээр болон 2023 оны 12 дугаар сарын 31-нээр хэрхэн тохируулсныг дараах байдлаар үзүүлэв. Үүнд:

	2024 мян.төг	2023 мян.төг
Татварын өмнөх ашиг/ (алдагдал)	24,631,178	18,004,538
Хуульд заасан хувиар тооцсон татварын зардал	6,157,795	4,501,135
Татвар ногдохгүй орлого, татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын татварын нөлөө:		
-Бага хувиар татвар ногдуулах орлогын нөлөө	(1,941,652)	(7,799,597)
-Татварын зорилгоор хасагдахгүй зардал	6,352,873	10,580,775
-Дансаас хассан хойшлогдсон татварын хөрөнгө	26,346,466	50,329,076
Тайлант жилийн орлогын албан татварын зардал	36,915,482	56,547,089

Татвар ногдох орлогоос татварын алдагдалыг хасах дүн нь жилд 50%-иар (2023: 50%) хязгаарлагддаг. 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар Банк нь 79,616,029 мянган төгрөгийн татвар ногдох орлоготой бөгөөд 2021 онд үүссэн татварын алдагдлаас 39,808,015 мянган төгрөгийг ашигласан.

2024 оны 12-р сарын 31-ний байдлаар Групп нь ирээдүйд татвар ногдох орлогоос хасах боломжтой татварын алдагдалтай бөгөөд эдгээр алдагдал нь гарсан хугацаанаас хамааран дараагийн дөрөв эсвэл гурван жилд ашиглагдах боломжтой. Тухайн жилд татвар ногдох орлогоос хасагдах татварын алдагдлын хэмжээ нь тухайн жилийн татвар ногдох орлогын 50% (2023: 50%)-аар хязгаарлагддаг.

Татварын алдагдлаас үүдэлтэй хойшлуулах татварын активуудыг Банк нь ирээдүйд татвар ногдох хангалттай ашиг гарах эсэх нь эргэлзээтэй тул хүлээн зөвшөөрөхгүй.

28. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийн үлдэгдэл нь 2024 оны 12 сарын 31-ний өдрөөр дараах байдалтай байна:

	2024 оны 01 дүгээр сарын 1 мян.төг	Ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн мян.төг	Бусад дэлгэрэнгүй орлогод тусгасан мян.төг	2024 оны 12 сарын 31 мян.төг
<i>Хойшлогдсон татварын (өр төлбөр)/ хөрөнгөнд хамаарах:</i>				
Банкуудад байршуулсан мөнгөн хадгаламж	690	71,748	—	72,438
Санхүүгийн хэрэглүүр	313	37,772		38,085
БҮЦӨБДО-д бүртгэгдэх өмчийн хэрэглүүр	(16,229,843)	—	4,183,754	(12,046,089)
Зээл ба урьдчилгаа	(47,093,924)	20,575,494	—	(26,518,430)
Биет бус хөрөнгө	864,208	(859,670)	—	4,538
Харилцагчдын харилцах данс	231,423	(233,089)	—	(1,666)
Бусад өр төлбөр	120,782	198	—	120,980
Бусад банкуудад өгөх өглөг	841,833	610,018	—	1,451,851
Өрийн бичиг	(61,958)	(5,228,538)	—	(5,290,498)
Зээлээр авсан санхүүжилт	11,882,545	(4,931,436)	—	6,951,109
Татварын алдагдал	37,905,975	(37,905,975)	—	—
Хойшлогдсон татварын хөрөнгө	(11,537,956)	(27,863,478)	4,183,754	(35,217,680)

Хойшлогдсон татварын хөрөнгийн үлдэгдэл 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дараах байдалтай байна:

	2023 оны 01 сарын 1 мян.төг	Ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн мян.төг	Бусад дэлгэрэнгүй орлогод тусгасан мян.төг	2023 оны 12 сарын 31 мян.төг
<i>Хойшлогдсон татварын (өр төлбөр)/ хөрөнгөнд хамаарах:</i>				
Банкуудад байршуулсан мөнгөн хадгаламж	(8,138,068)	8,138,758	—	690
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	6,357,094	(6,356,781)	—	313
БҮЦӨБДО-д бүртгэгдэх өмчийн хэрэглүүр	(14,889,192)	—	(1,340,651)	(16,229,843)
Зээл ба урьдчилгаа	(101,835,919)	54,741,995	—	(47,093,924)
Биет бус хөрөнгө	(311,974)	1,176,182	—	864,208
Бусад хөрөнгө	(3,472)	3,472	—	—
Харилцагчдын харилцах данс	236,269	(4,846)	—	231,423
Бусад өр төлбөр	176,190	(55,408)	—	120,782
Бусад банкуудад өгөх өглөг	624,340	217,493	—	841,833
Өрийн бичиг	118,019,538	(118,081,496)	—	(61,958)
Зээлээр авсан санхүүжилт	9,273,303	2,609,242	—	11,882,545
Татварын алдагдал	37,905,975	—	—	37,905,975
Хойшлогдсон татварын хөрөнгө	47,414,084	(57,611,389)	(1,340,651)	(11,537,956)

29. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Танилцуулга ба Ерөнхий тойм

Банк нь үйл ажиллагаандаа учирч буй эрсдэлүүдийг дараах ерөнхий төрлүүдээр ангилдаг. Үүнд:

- Зээлийн эрсдэл
- Зах зээлийн эрсдэл
- Хөрвөх чадварын эрсдэл
- Үйл ажиллагааны эрсдэл
- Хөрөнгө оруулалтын эрсдэл

Энэхүү тодруулгад дурдсан Банкны эрсдэлүүдийн талаар мэдээлэл болон эрсдэлийн удирдлагын бодлого, журам ба эрсдэлийг хэрхэн үнэлж, удирдах ба хянах үйл ажиллагааг тусгасан болно.

Эрсдэлийн удирдлагын бодлого

Банкны эрсдэлийн удирдлагын бодлого нь Банкны эрсдэлийг тодорхойлох аргачлалыг тогтмол сайжруулах, эрсдэлийн удирдлагын үр ашигтай системийг бий болгож, хэрэгжүүлэх замаар Банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлж, үнэлж, урьдчилан сэргийлж, бууруулж, зохистой удирдахад чиглэнэ.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Банкны эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлж, түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны хязгаарлалт, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, эрсдэлийн аппетитийг баталж эрсдэлийн удирдлагын үр дүнтэй хяналтын тогтолцоог бүрдүүлэн, тогтмол хяналт тавих үүрэгтэй.

Гүйцэтгэх Захирлын удирдлага доорх Удирдлагын баг нь эрсдэлийн удирдлагын бодлого, зохицуулалтын дагуу Банк нь тогтоосон эрсдэлийн параметруудийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, эрсдэлийн удирдлагын үр дүнтэй тогтолцоог боловсруулж ажиллах үүрэгтэй.

Эрсдэлийн Удирдлагын Газар нь эрсдэлийн удирдлагын хүрээг хянах, журмын хэрэгжилтийг хангах, эрсдэлийг тодорхойлох, хэмжих, удирдах, тайлагнах арга хэлбэрийг боловсруулах үүрэгтэй.

Дор дурдсан гурван хороодоос гадна Монгол Улсын Хөгжлийн банкны Захирлуудын зөвлөл нь гүйцэтгэх удирдлагын өдөр тутмын үйл ажиллагааны уялдааг ханган, үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмж гаргах замаар Гүйцэтгэх Захирлыг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй.

Зээлийн Удирдлагын Хороо-ны үндсэн зорилго нь зээлийн ерөнхий болон багцын удирдлага болон бусад зээлтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд оршино. Зээлийн Удирдлагын Хорооны зүгээс зээлийн үнэлгээ хийх, зээлийн эрсдэлийг багасгах, түүнийг удирдах арга замуудыг судлан, зээлийн нөхцөлийг тогтоодог.

Зээлийн Удирдлагын Хороо нь ирээдүйн төсөл түүний үйл ажиллагааны санхүүжилтийг зохион байгуулах, зээлдэгч-зээлдүүлэгчийн харилцааг тогтоосон стандарт, зарчмуудыг хэрэгжүүлэх, санхүүжилтийн горимд учирч болзошгүй эрсдэлийг багасгах явдлыг хангах үүрэгтэй. Мөн Зээлийн Удирдлагын Хороо нь Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталсан журмын дагуу Гүйцэтгэх Удирдлагад санхүүжилтийн шийдвэр гаргалтад мэргэжлийн талаас санал бодлоо илэрхийлж, зөвлөмж өгөх үүрэгтэй. Зээлийн эрсдэлийн удирдлага болон зээлийн багцын хязгаарлалт, түүнд тогтоосон бодлого, журмууд нь Зээлийн Удирдлагын Хороогоор хянагддаг. Зээлийн Удирдлагын Хороо нь зээлийн эрсдэлийг хянаж, үнэлэх, зээлийн бүтээгдэхүүнийг барьцаалах, удирдамжийг хянах, мөрдүүлэх зорилгоор байгуулагдсан.

Түүнчлэн, журмын дагуу Зээлийн Удирдлагын Хороо нь зээл олгох, батлах, зээл олгох нөхцөлийг өөрчлөх, зээлийн гэрээг удирдах, зээлийн багцын үр ашигт байдлыг зохицуулах байдлаар Банкны дүрмийн хүрээнд Зээлийн үйл ажиллагаанд хяналт тавина.

29. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хөрөнгийн Удирдлагын Хороо (ХУХ) нь хөрөнгө удирдлагын үйл ажиллагааг зохицуулах, актив, пассивын бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах, хянах, түүнд санал оруулах зорилгоор байгуулагдсан. ХУХ нь Хөгжлийн банкны шинэчлэгдсэн хуулийн шаардлагад нийцүүлэн богино болон урт хугацааны хөрөнгийн хөрвөх чадварыг удирдах, цэвэр хүүгийн ашгийг хамгийн их байлгах аргаар балансын актив пассивын бүтцийг тодорхойлох үүрэгтэй. Мөн өдөр тутмын төлбөрийн чадварын зөрүүг хянах, стресс тест хийх, актив, пассив хөрөнгийн зохистой бүтцийг сар бүр тодорхойлж, шаардлагатай тохиолдолд тухай бүр өөрчлөлт оруулах санал өгөх үүрэгтэй. ХУХ-ны хурлыг сард нэг удаа тухайн улирал дуусахаас арван хоногийн өмнө санхүүгийн үйл ажиллагааг үнэлэх, Банкны улирлын тайлан болон хөндлөнгийн аудитын байгууллагаас баталгаажуулах аудитын тайланг хэлэлцэх зорилгоор хуралдана. Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага нь ХУХ болон Хөрөнгийн Удирдлагын газарт төвлөрөх бөгөөд хөрвөх чадварын зөрүүг хянаж, стресс тест хийн хөрвөх чадварын шинжилгээний тайланг тогтмол явуулдаг.

Эрсдэлийн Удирдлагын Хороо нь Банкны эрсдэлийн удирдлагын бодлогын зорилго зорилтыг хэрэгжүүлэх үүднээс банкны зээл, хөрвөх чадвар, зах зээл болон үйл ажиллагааны эрсдэлийн төвшин, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх, бууруулах арга замуудыг тодорхойлон, хууль, журмын дагуу тогтоосон эрсдэлийн хэм хэмжээ, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг хангахад чиглэн ажилладаг. ЭУХ нь дараах асуудлуудыг хэлэлцэн дүгнэлт гаргах үүрэгтэй.

Үүнд:

- Монгол Улсын Хөгжлийн Банкны тухай хууль, холбогдох журамд тусгагдсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хязгаарлалтуудын хэрэгжилтийг хянах, холбогдох журамд өөрчлөлт оруулах саналыг хэлэлцэх;
- Банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгын хүрээнд банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох, шинэчлэх, тэдгээрийн хэрэгжилтийн тайлан мэдээг хэлэлцэх;
- Банкны бизнес төлөвлөгөө, түүний зорилго зорилтын хэрэгжилтийн хүрээнд эрсдэлийн аппетит, Банкны хүлээн зөвшөөрөх алдагдлын хэмжээг тодорхойлох;
- Банкны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх холбогдох журам, заавар, аргачлалыг хэлэлцэх;
- Банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж үнэлэн, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ, стратегийг хэлэлцэх;
- Банкны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн төвшний үнэлгээ дүгнэлтийг гаргах, эрсдэлийн удирдлагын зүй зохистой тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэх;
- Эрсдэлийн хэмжээний хязгаарлалтыг шинээр тогтоох, өөрчлөх, холбогдох арга аргачлалыг батлах, гүйцэтгэлийг дүгнэх;
- Засгийн газар, Монгол банк, хөндлөнгийн аудит болон Банкны дотоод хяналтын нэгжүүдийн хяналт шалгалтын дүгнэлт, зөвлөмжийг хэлэлцэх;
- Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний эрсдэлийн төвшин, эрсдэлийг хаах үйл ажиллагааны зардал, ашгийн тооцоолол, нэвтрүүлэх явцад гарах эрсдэл, хяналт, зохион байгуулалттай холбоотой асуудлыг хэлэлцэх;
- Банкны бүртгэл тайлагналын эрсдэл, мэдээллийн технологи, системийн аюулгүй тогтвортой үйл ажиллагаа, мэдээ мэдээллийн нууцлал, зүй зохистой хүрэлцээг хангах талаар хэлэлцэх;
- Банкны ажлын байрны аюулгүй байдал, харуул хамгаалалт, Банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй гадаад орчны нөлөөллийн эрсдэлийг бууруулах, онцгой нөхцөл байдлын үед хяналт тавих, даван туулах нөхцөл бололцоог хэрхэн хангаж байгаа эсэхийг хэлэлцэх;
- Банкны санхүүгийн онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөө, зааврыг жил тутам хянаж, гадаад дотоод нөлөөллийн үнэлгээний дагуу шаардлагатай өөрчлөлтийг оруулах талаар хэлэлцэх;
- Банкны журам, заавраар зохицуулагдаагүй бусад үйл ажиллагааны эрсдэл, эрүүгийн гэмт хэргийн шинжтэй үйлдэл гарах нөхцөл, терроризм мөнгө угаалтын эсрэг үйл ажиллагааны хяналт, ажиллах хүчний тогтвортой байдал талаар хэлэлцэх;
- Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, холбогдох шийдвэрүүд тэдгээрийн хэрэгжилт, үр дүн болон цаашид баримтлах чиглэл, төлөвлөгөөний талаар санал боловсруулах;
- Хорооны хурлын үйл ажиллагааны үр дүн, дүгнэлтийн биелэлтийг улирал тутам хянах;
- Эрсдэлийн удирдлагатай холбоотой бусад асуудлын талаар хэлэлцэх.

29. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)**Зээлийн эрсдэл**

Зээлийн эрсдэл нь зээлдэгч болон бусад харилцагчид Банкны өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, барьцаа баталгааны хөрөнгө нь гэрээний үүргийн гүйцэтгэлийг үл хангах эрсдэл юм.

Банкны төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх үйл ажиллагааг чиглүүлэн зохион байгуулах, санхүүжилтийн багцын чанарын болон төвлөрлийн хязгаарлалт, зээлийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг ханган ажиллах, санхүүжилт, хөрөнгө оруулалтын учирч болзошгүй эрсдэлийг удирдах, өдөр тутмын зээл санхүүжилтийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг Зээлийн Удирдлагын Хороо хариуцдаг. Тайлант хугацаанд Банк зээлийн бодлого, Зээлийн Удирдлагын Хорооны ажиллах болон зээлийн үйл ажиллагааны журмуудыг шинэчлэн батлуулж мөрдөн ажиллаж байна.

Банк нь зээлийн эрсдэлийн удирдлагын бодлого, журамд байнга хяналт тавьж, шинэчлэлт хийдэг. Тайлант жилд Банк нь эрсдэлтэй зээлдэгчдийн жагсаалтын журам, хөрөнгийн үнэлгээний журмыг шинэчилсэн.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль, Монгол Улсын Хөгжлийн Банкны дүрмийн дагуу Гүйцэтгэх Захирал нь Банкны өөрийн хөрөнгийн 0.6%-иас доош үнийн дүнтэй төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх, баталгаа, батлан даалт гаргахтай холбоотой шийдвэрийг гаргадаг бөгөөд өөрийн хөрөнгийн 0.6%-иас дээш үнийн дүнтэй төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх, баталгаа, батлан даалт гаргахтай холбоотой шийдвэрийг ГҮЗ-өөс гаргуулан ажилладаг. Мөн Банкны Гүйцэтгэх Захирал нь Банкны гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгчийн хувьд төсөл хөтөлбөрийн санхүүжилт, санхүүжилтийн нөхцөл өөрчлөх, санхүүжилтийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах талаар шийдвэр гаргахдаа мэргэжлийн хороо буюу Зээлийн Удирдлагын Хорооны дүгнэлтэд үндэслэдэг.

Банк нь 2017 онд батлагдсан Монгол Улсын Хөгжлийн Банкны хуулийн шинэчилсэн найруулгын дагуу банкны зээл санхүүжилтийн үйл ажиллагааны стратеги чиглэл, санхүүжилтийн тэргүүлэх салбар, төсөл хөтөлбөрт тавигдах шаардлагыг тогтоож, улс орны стратегийн өндөр ач холбогдол бүхий эдийн засаг, санхүүгийн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэх шийдвэрийг бие даан гарган ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн үйл ажиллагааны чиг үүргийн хүрээнд үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох, түүнд хяналт тавин шинэчлэх мөн зээлийн эрсдэлийн аппетитыг тодорхойлон үйл ажиллагааны зохистой харьцааг хянадаг. Хяналтын үйл ажиллагаа болон загварт хяналт тавихаас гадна Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Эрсдэлийн Удирдлагын Хороо болон Дотоод Аудитад шаардлагатай заавар, зөвлөмжийг тогтмол хүргүүлэн ажилладаг.

Зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцохдоо үндсэн зээл болон хүүгийн төлбөрийн хугацаа хэтэрсэн эсвэл оролцогч талын мөнгөн гүйлгээнд мэдэгдэхүйц хүндрэл учирсан, зээлжих чадварын үнэлгээ буурсан, гэрээний үндсэн нөхцөлийг зөрчсөн эсэхийг голлон анхаардаг. Үнэ цэнэ бууралтын хувь хэмжээгээр зээлийг таван бүлэгт ангилдаг байна.

Банк нь Монгол банкнаас баталсан “Активыг ангилах, эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам”-ийн дагуу зээлийг ангилж зээлийн чанарыг хянадаг.

Балансын гадуурх санхүүгийн хэрэгслүүдийн хувьд Банк нь шийдвэр гаргах, хязгаарлалт тогтоох, байнгын хяналт тавих зэргээр балансын санхүүгийн хэрэгсэлтэй нэгэн адил зохицуулалтыг баримталдаг.

29. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Барьцаа хөрөнгө

